1. Монгол банкны Санхүү мэдээллийн алба 2016 он
2. Азийн Сан, Монгол Улсын Авлигын Индексийн Судалгаа VIII – 2009 оны 12 сар
3. /www.shuukh.mn/
4. Эрүүгийн хууль /2002 он/
5. Эрүүгийн хууль /2017 он/
6. 2012 оны 07 дугаар сарын 18–ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргын 459 дүгээр тушаал
7. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо /ФАТФ/
8. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал (Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл)

**ЦААЗААР АВАХ ЯЛ БА ХҮНИЙ ЭРХ**

**Б.Хулан**
*ДХИС-ийн ЭЗНУС-ийн*
*Хувийн эрх зүйн тэнхимийн багш,*
*цагдаагийн ахлах дэслэгч*

**Удиртгал**

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд цаазаар авах ял ба хүний эрхийн тухай тусгаж өгсөн ба цаазаар авах ял одоо ямар хэмжээнд байж хүний эрхийг хангаж буй талаарх ойлголтыг бий болгохын тулд өнгөрсөн дэх цаазаар авах ялын тухай ойлголт болон өнөө үед тухайн ял нь ямар түвшинд байгаа талаар судлан тухайн өгүүллийг бичих ба эрдэм шинжилгээний өгүүлэлд Д.Баярсайнхан, И.Дашням, Э.Авирмэнд, Б.Амарбаясгалан, Г.Сүхбаатар, Сайшаал зэрэг олон эрдэмтэдийн бүтээлээс иш татан өгүүлэлд тусгана.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулахаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно гэж заасан байдаг ба ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ял нь хүн бүр амьд явах эрхтэй гэх эрхийг зөрчиж буй хүний эрхийн эсрэг үйлдэл болж байна. Энэ эрхийг олон улсын эрх зүйн хувьд улам баталгаажуулж хүн бүр амьд явах салшгүй эрхтэй, энэ эрхийг хуулиар хамгаалах ба хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй, цаазаар авах ялыг цуцлаагүй улс оронд уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх зориолгоор тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу тухайн этгээдэд оногдуулах үзэл бий болсон нь хүний амьд явах эрхийг хязгаарлан тасалж буй нэг хэлбэр хэмээн хоорондоо харшилж байгаа тул уг асуудлыг шийдвэрлэж зохих аргуудыг хэрэглэх шаардлага бий болж буйд тулгуурлан эрдэм шинжилгээний өгүүллийг бичлээ.

**Нэг. Цаазаар авах ял ба түүний түүхэн хөгжил**

Монголчуудын эртнээс уламжлагдаж ирсэн ёс заншил, хууль цаазын өв, уламжпалаас үзэхэд эрүүгийн ялын бодлого нь нилээд хатуу чанга, тэр тусмаа цаазаар авах ялыг өргөн хүрээнд, харьцангүй түгээмэл хэрэглэж ирсэн байдаг.

Цаазаар авах ял бол Монголын эртний уламжлалт ялын нэг бөгөөд энэ нь нэн эрт үеэс нүүдэлчин овог аймгуудын хоорондын тэмцэл, зөрчилдөөний үр дагавар болж гарч ирсэн цусан өшөө авах ёсны (талеоноос ялгаатай) үүсэл гарлаас эх үндэс авч хөгжин хэрэглэгдэж иржээ.

Цаазаар авах ялыг Монголчууд ялын дээд хэмжээ гэж үзэхээсээ илүү зайлшгүй бөгөөд шударга шийтгэлийн илэрхийлэл, хөх тэнгэрийн зарлигаар тогтоосон гэсгээл, хариуцлагын хэлбэр гэж үзэх хандлага олон жилийн турш бүрэлдэн төлөвшсөн байдаг. Өөрөөр хэлбэл, аливаа гэмт үйл учруулсан хохирлоосоо илүү тухайн гэмт үйлийг үйлдэх гэсэн санаа, зорилго, сэдэл нь тэнгэрийн ёсонд ноцтой харшилсан нүгэлт үйл гэж үзэж байснаас үүдэн цаазаар авах ялын хэрэглээг он удаан жил тогтвортой хадгалж, уг ялын хууль цаазын агуулга, ач холбогдлыг ямагт хүлээн зөвшөөрч даган мөрдөж байв.

Хүннүгийн үед тодорхой үйлдлээр хүнийг алах, хүнд гэмт хэрэг үйлдвэл цаазаар авах ял оноодог байсан байна. Энэ тухай Хүнну судлаач Г.Сүхбаатар Хятадын “Түүхэн тэмдэглэл" (Ши-Цзи) хэмээх эх сурвалжид “Тэдний баримталдаг хуулиар ирт үзүүртнийг гаргавал цаазаар авна, хулгайн ялтай хүний гэр бүлийг хураана, хөнгөн хэрэгтнийг бэрээднэ, хүнд хөдөлмөрт зүтгүүлнэ, хүндийг цаазаар авна[26] гэж бичсэн байдаг.

Энэ тухай Профессор Д.Баярсайхан Хүннүгийн хэв хуульд цаазаар авах ялыг зөвхөн хүнд ноцтой гэмт хэрэгт (ирт үзүүртний гэмт үйл) ногдуулж байсан нь тухайн ялыг хууль журмаас гадуур

[26] Г.Сүхбаатар. Монголын эртний түүх судлал 1 боть. Монголчуудын эртний өвөг. УБ. 2000. 73 дахь тал

дур зоргоор ногдуулах явдлыг хязгаарлаж байсан жишээ мөн" гэж тэмдэглэсэн билээ[27]. *Сяньбид* цаазаар авах ял байсан ч үхэр, хониор золио өгч (солих, орлуулах) ялаас хэлтэрч болдог байжээ[28]. Хүнну гүрний дараах төрт улсууд болох Тоба, Тогоон, Жужан, Түрэг, Хиргис, Хятан зэрэг эртний Монголын нүүдэлчин улсуудын эрүүгийн ял цаазын түүхэн уламжлалаас үзэхэд цаазаар авах ялыг оноох үндэслэл, зарчим нь нүүдэлчдийн ёс заншлын онцлогийг тусгасан байдгаас үүдэн нилээд хатуу чанд байсны дээр хүний амь хөнөөснөөс гадна хаан төрд тэрсэлсэн өрх гэр, ёс заншлыг гутаан доромжилсон мал хулгайлсан зэрэг гэмт хэрэгт оноож байсны дээр зарим тохиолдолд уг ялыг өөр ялаар (мал болон торгуулиар) солих журмыг бий болгож хэрэглэж байсан зэрэг нь түүхэнд үлджээ[29]. Монголын эрт цагийн заншилд садар самуун явдлыг хамгийн хүнд гэмт хэрэгт тооцож, тэр хэмжээгээр хатуу шийтгэл оноож байжээ. Тухайлбал, аймгийн тэргүүлэгчдийн эхнэр энгийн харц ардтай ханилан явалдсаныг мэдвэл тэр даруй хөвчөөр боомилон алж, явалдсан эрийн эцэг, хөвгүүн ах дүүсийн нэг л хүнийг үлдээж, бусдыг цөм үхэх ялд унагааж охид, гэр тэрэг, бүх малыг нь хураан авдаг байжээ. Хэн нэг хүн өөр хүний эзэмшихүүн газар дээр илэрхий хулгай дээрэм хийвэл түүнийг үг дуугүй алдаг байв[30]. Цаазаар авах ялыг цавчих, хөвчөөр боомилон алах, чулуу шийдмээр дэлдэх аргаар гүйцэтгэдэг байжээ.

Доктор Б.Амарбаясгалан цаазаар авах ялын асуудлыг докторын зэрэг горилсон диссертацийн хэмжээнд судлаад "Эртний Дорно болон Өрнө дахин, түүнчлэн Монголын эртний эрүүгийн ял цаазын түүхэн уламжлал дахь нийтлэг шинж нь:

- Цаазаар авах ялыг харьцангуй түгээмэл хэрэглэж ирсэн;
- Уг ялын хэрэглээнд тухайн үндэстэн, улс орны ёс заншил болон шашин шүтлэгийг ноцтой зөрчсөн болон өрх гэр, гэр бүлийн ёс журмыг гутаасан гэмт үйлдлийг тухайн ялын нөхцөлд тооцон хэрэгжүүлж байсан;
- Цаазаар авах ялыг хэрэглэх арга нь олон янз бөгөөд ихэнхидээ залхаан цээрлүүлэх, бусдад сургамж болгох зорилготой байсан зэргийг дурьдаж болно.

Харин Монголын эртний эрүүгийн ял цаазанд цаазаар авах ялын бодлого нь харьцангуй ялгарч харагддаг бөгөөд цаазын ялтай этгээдийг тухайн хүний эд хөрөнгийн байдлыг харгалзан малын торгуулиар золио болгон сольж, эрүүгийн эрх зүйн орлуулалтыг бий болгон хэрэглэж ирсэн нь дэлхийн түүхэн дэх анхны тохиолдлуудын нэг бөгөөд энэ уламжлал нь дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн цаашдын хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлжээ"[31] гэж дүгнэсэн.

IX-XII зууны үеийн Монгол ханлиг аймгууд болох Татар, Хэрэйдй Найман болон Мэргэд, Баяд, Ойрад, Жалайрын холбоонд ч элдэв харш үйлд цаазаар авах ял уламжлагдан ирсэн гэж түүхэнд үздэг[32].

1206 онд Монголын нэгдсэн улс байгуулагдсаны дараа Чингис хаан Зүрчидийн Алтан улстай жилийн аян дайн, Дундад Азид явуулсан цэргийн ажиллагааны үеэр үг дуугүй бууж өгөх шаардлагыг хүлээж авсан, бууж өгсөн хотын захирагч, эздийн амийг өршөөн хэлтрүүлж байсан. Жишээ нь: Бухар, Самаркандын эзлэх аян дайны өмнө Чингис хаан элч заран "Чингис хаан биеэрээ хэдэн мянган цэрэг дагуулж ирээд байна. Та нар хэрвээ бага ч гэсэн эсэргүүцвэл нүд ирмэхийн зуур хот чинь үнсэн товрог болж хээр талыг цусан далай болгох болно. Хэрэв та нар үнэнч 3 итгэлийг болгоон сонсох юм бол та нарын амь нас, эд хөрөнгөнд чинь үл халдах баталгаатай гэж тулган шаардсаныг хотын дарга хүлээн авч Чингис хаанд элч, бэлэг сэлт хүргүүлж ба өөрийн биеэр их хаанд эраалхан бууж өгснөө өчсөн

---

[27] Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал. УБ. 2012. 42 дахь тал

[28] И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. Тэргүүн боть. УБ. 2005. 69 дэх тал Э.Авирмэд, И.Дашням. Дурдсан бүтээл 117 дахь тал

[29] И.Дашням. Дурдсан бүтээл 117 дахь тал

[30] Э.Авирмэд, Д.Дашцэдэн. Дурдсан бүтээл. УБ., 1997. 8 дахь тал

[31] Б.Амарбаясгалан. Цаазаар авах ял: Олон улсын болон Монголын эрүүгийн эрх зүйн уялдаа холбоо. Докторын диссертаци. УБ., 2013.19-20 дахь тал

[32] Г.Сүхбаатар. Монголын эртний түүх судлал. 2 боть. УБ., 2001. 76 дахь тал; И.Дашням. Монгол Улсын төр эрх зүйн түүх /МЭӨ 2009 - МЭ XIII зууны дунд үе/ тэргүүн боть. 160-182 дахьтал

байна. Чингис хаан хотын дарга, элчийг хүлээн аваад зөөлөн үг, өршөөлийн царайгаар тэднийг тайтгаруулж. үхэх ялаас хэлтрүүлжээ”[33].

Монголын нэгдсэн улсад Хүнну, Сяньби, Нирун зэрэг эртний /лсуудын үед үүсэн хөгжсөн эрх зүйн уламжлалыг өвлөн шингээсэн заншлын эрх. хэм хэмжээ. төрөөс батлан гаргасан хууль. эрх зүйн актууд гэсэн хоёр эх сурвалж зонхилж байв. Чингис хааны тунхагласан засаг. зарлигуудыг багтаасан “Их Засаг” хуульд эрүүгийн бодлого. ял шийтгэлийн асуудал онцгой байр эзэлж байсан Жорж Вернардский "Засагт орсон эрүүгийн хууль цааз нь төр хийгээд нийгэмд тайван ес журмыг сахиулах гол хэрэгсэл болсон гээд ... Бүү худал хэл алив гэмт явдалд алах ял тогтооно гэж заасныг онцлон дурдсан[34].

Төрийн тэргүүн, их хааны махбод. эрх мэдэл. нэр төр халдашгүй дархан агаад түүний эсрэг үйлдэл гаргаваас төрийн эсрэг гэмт хэрэгт тооцож, хатуу цээрлэл хүлээлгэнэ “Хаан ба төр улсаас зөрчигсөдийг элах ялаар шийтгэх . Хаадын сонгуульгүйгээр еөрийн эрх сүлд түшиглэн хаан суусан бол түүнийг өчүүхэн ч хайр найргүй цаазлах. Хуурамч элч буюу өөрийгөө элчин сайд, төлөөлөгч хэмээн хууран мэхэлбэл цаазлах” зэргээр хаант засаглал, хааны амь нас, бие махбод гэмт халдлагаас хамгаалсан шинжтэй байсан·[35] гэж шинжлэх ухааны доктор И.Дашням тэмдэглэжээ.

Их Засаг хуульд захиргааны журам зөрчсөн зарим үйлдэлд. тухайлбал. Өерийн арваныг үл захирах насныг олж гэмт болгох, хөрөнгө мөнгө эрхэлдэг түшмэд албан мөнгө хөрөнгөнөөс авч хэрэглэвэл алах”, “хөрөнгө захирагч нар дур зоргоор ард иргэдээс алба авах. ажилд зарах”, “хүн өөрийн харъяаны мянгат, зуут, арванаас дур мэдэн гарч явбал алах", “цэрэг байлдааны даалгавар үл биелүүлэх, урван тэрслэх, байлдааны талбараас зугтах, оргох, олзлогдсон хүмүүст түүнийг барьсан хүнээс зөвшөөрөл авалгүй хоол, хүнс өгөх" зэрэг гэмт хэрэг цаазлах ял оногдуулж байжээ. Сайшаал "Хулгай хийсэн этгээдийг цаазлан хороож гэргий ба мал хөрөнгийг хураан авч хулгайд малаа алдсан хохирогсдод өгнө. Том хулгайчид үхэх ял оногдуулна” гэж бичжээ. Их засаг хуульд цаазаар авах ялаас гадна эрхтэнг хагаслах, гяндлах, цөлөх, бэрэгдэх, торгох, эд хөрөнгө хураах, тушаал эвдэх зэрэг ял оногдуулахаар зааж байсан.

Шинжлэх ухааны доктор И.Дашням "Ерөнхий хууль буюу Чингис хааны үндсэн хууль товчоо”-ны 51 дүгээр зурваст хулгайчдыг алах бөгөөд түүний гэргий мал хөрөнгийг нь хураана 52 дугаар зурваст боол хүн бусдын юмыг хулгайлбал тэрхүү боол ба боолын эзнийг алах ялаар шийтгэн, тэдний гэргий эд хөрөнгийг хураан авмой” гэж заасныг дурджээ. Энэ бүхнээс дүгнэлт хийхэд Их засаг хуульд алах ялыг өргөн хэрэглэж байсан нь харагдаж байна.

Өгөдэйн хаанчлалын үеийн эрх зүйн тулгуур эх сурвалж нь ‘Их засаг” хууль байсан бөгөөд 'Хуулийг дээдэлж, заалтыг чанд мөрдөх явдал засаг төр тогтвортой, ард олон амгалан байхын үндэс” гэж Өгөдэй хаан сургаж байв.

Энэ үед гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх. гэмт хэргийг илрүүлэх. гэмт хэрэгт холбогдогсдыг байцаах. яллах. ялтан хэрэгтнийг хадгалах төрийн үйл ажиллагаа нэгэн цогц болон явагдаж байжээ. Өгөдэйн хаанчлалын үед Их Монгол Улсад “алах. цаазлах" ялыг өргөн хэрэглэж байсан. Жишээ нь. Төрийн их хуралдайд ноёд зарласаар байхад оролцоогүй. түүнчлэн] эхнэр. нөхөртэй хүн бусадтай завхайрвал эхнэр. нөхрийг хоёуланг нь алах ял шийтгэх ёстой байв.[36]

Плано Карпини "Монголчуудын түүх’-д дурдсанаар ял оногдуулбал зохих 40 шахам гэмт үйлдлийн нэлээд илүүд нь цаазаар авах ял оногдуулж байсан[37] гэжээ.

Энэ нь цаазаар авах ялыг түгээмэл хэрэглэж байсныг харуулна. Ялангуяа төрд тэрслэх. цэрэг хөдөлгөн босгох. амь насыг нь санаатайгаар бүрэлгэх. улсаас урвах. цэрэг байлдааны журам зөрчих

[33] Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. УБ . 2004. 102 дахь тал
[34] Ж Вернадский. Чингис хааны их засгийн судалгаа. УБ.. 1992 26 дахь тал
[35] И.Дашням. Дурдсан зохиол. УБ., 2005. 364 дэх тал
[36] Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.. 1998. 18-24 дэх тал
[37] Плано Карпини. Монголчуудын түүх. УБ.. 1998. 41 дэх тал

аваас цаазаар авах ялыг чандлан хэрэглэж байсан нь зүйн хэрэг юм. Рашид-Ад-Диний ' цаазаар авах ялыг гүйцэтгэхдээ сурвалжит хүнийг бол хорт ундаа, хор өгөх хэлбэрээр амийг нь алах бусад тохиолдолд цавчих. харвах. усанд живүүлэх. эсгийнд боож бүтээж алах аргаар гүйцэтгэж байсан”[38] гэж бичжээ.

Юан гүрний нэвтэрхий хуульд алах ял нь нэн түгээмэл хэрэглэгддэг төрөл байсан бөгөөд түүнийг цавчиж алах, огтчиж алах хоёр аргаар гүйцэтгэж байв. “Алтан хааны цаазын бичиг”, “Арван буянт номын цааз”, “Халхын цааз эрхэмжийн 18 хууль”, “Монгол-Ойрадын цааз бичиг”-т цаазлах нь ялын нэг төрөл болон хэрэглэгдэж байв[39].

“Халх журам" хуульд төрд тэрслэх, хүнийг алах, гэмтээх, цэргийн гэмт хэргүүдэд алах ялыг өргөн хэрэглэж байсныг доктор С.Жалан-Аажав онцлон дурдсан байдаг[40]. Эдгээр шүүх цаазын бичигт анх удаа Тэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй хүмүүс, хөхүүл хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйд цаазаар авах ял хэрэглэхийг хориглосон” нь тэр үедээ энэрэнгүй хэм хэмжээ юм.

1934 оны Шүүх цаазын бичгийн 17 дугаар зүйлд “буудан алах ял болбоос улсыг хамгаалах онц арга хэмжээ мөн учир, туйлын хүнд гэмт хэрэгт хэрэглэх бөгөөд басхүү шүүн таслах газраас ялтан этгээдэд мөнхүү гэмт хэрэг дахин үйлдэхийг цээрлүүлэх өөр аргагүй хэмээн бодсон буюу ард түмний дайсан этгээдийг айлган сүрдүүлэх онц чухал учир тохиолдсон тухайд хэрэглэнэ" гэж заасан нь улс төрийн талаар өөрөөр сэтгэгчдийг ямар ч зөвтгөх үндэсгүйгээр төрийн цээрлэл хүртээнэ гэсэн санааг хуульд туйлын тодорхой суулгаж өгсөн нь ойлгомжтой байдаг. Эрүүгийн хуулийн энэ заалт 1930-д оноос эхэлсэн улс төрийн хэлмэгдүүлэлтийн эрх зүйн суурь болсон байна.

Гэмт хэрэг үйлдэх цаг үест насанд хүрээгүй хүмүүс ба жирэмсэн буюу хөхүүл нялхастай эмэгтэйчүүдэд буудан алах ял оноож үл болно гэж энэ хуульд заажээ.

Энэ хуульд ихэвчлэн төрийн эсрэг гэмт хэрэг /42-46-р зүйл/, дайн байлдааны цагт татвар төлөхөөс зайлсхийх, цэрэгт агт морь. тэрэг зэргийг шилжүүлэх үүрэг биелүүлээгүй хэргийг хүндэтгэх шалтгаантай үйлдэх, албан тушаалтан улсын мөнгөн хөрөнгийг хувьдаа хортой санаагаар үрэгдүүлсэн /52-р зүйл/. бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтай санаатай алах /118-р зүйл/. хүндрүүлэх шалтгаантай дээрэмдэх /141-р зүйл/, цэргийн гэмт хэрэг үйлдэх. 157. 162, 168, 171-173. 174-р зүйлд заасан гэмт хэргүүдэд буудан алж хөрөнгийг хураах туйлын тодорхой санкц хэрэглэж байв.

1942 оны Эрүүгийн хуульд нийт тусгай ангийн 44 зүйлд цаазаар авах ял хуульчилсан байдаг.

Төрийн эсрэг болон улс хоршооллын өмчийн эсрэг гэмт хэрэгт оногдуулж байсан. БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн 1953 оны 8 сарын 5-ны өдрийн “Алах ялыг өөрчлөх тухай” 93 дугаар зарлигт “БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдээс анх тайван цаг үед алах ялыг хойшид хэрэглэхийн хэрэггүй гэж үзнэ” гэж заажээ. Энэ зарлигийн дагуу БНМАУ-д дагаж шийтгүүлж байсан хуулиудаар тогтоосон алах ялыг хэрэгсэхгүй болгож, зөвхөн эх орноосоо урвагчид, тагнуулчид, хорлон сүйтгэгч нарт хэрэглэж байхаар тогтоосон билээ. Энэ өөрчлөлт нь Монгол Улсын эрүүгийн эх зүйн түүхэнд гарсан онцлог үе юм. Гэвч 1953 онд Завхан аймагт нэг гэр бүлийн 6 хүнийг, нохойтой нь алсан онц ноцтой хэргийг тус аймгийн харъяат Дорлигсүрэн гэгч этгээд үйлдсэн нь тухайн үед ард олны жигшил зэвүүцлийг төрүүлж, ард түмний хүсэл зоригоор цаазаар авах ялыг дахин сэргээсэн байна. Тухайн үед нутгийн ард олны шаардлагаар яллагдагч Дорлигсүрэн гэгчид цаазаар авах ял оноож, мөн нутгийн иргэдийн шаардлагаар олон түмний нүдний өмнө ялыг гүйцэтгэсэн нь Эрүүгийн хуулийн концепцийг зөрчиж, буцаан хэрэглэсэн нь шүүхийн практикт цаазаар авах ялыг олны өмнө гүйцэтгэсэн цорын ганц тохиолдолд болсон байна.[41] Иймд цаазаар авах ялыг хүчингүй болгосон энэ заалт 10 сар орчим хэрэгжиж, БНМАУ-ын АИХ-ын "эргүүлэгчдийн 1954 оны 67 дугаар зарлигаар хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан гэмт хэрэгт буудан алах ял хэрэглэж байхаар

[38] Б.Баярсайхан. Монгол Улсын арван буянт номын цагаан түүх. УБ., 2002. 35 дахь тал
[39] Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.. 1998. 18-24 дэх тал
[40] С.Жалан-Аажав. Дурдсан зохиол. УБ., 1958. 48 дахь тал
[41] Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ , 2011

тогтоожээ.[42] 1961 оны Эрүүгийн хуульд төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүд 45-48-р зүйл/ онц их хэмжээтэй улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулах /63-р зүйл “В”/, онц хүндрүүлэх шалтгаантай алах /70-р зүйл/, онц хүндрүүлэх шалтгаантай хулгайлах /109-р зүйл "В7, цагдаагийн ажилтны амь биед халдах /155-р зүйл/, онц хүндрүүлэх шалтгаантай дээрэмдэх /168-р зүйл В7 зэрэг 9 зүйлд цаазаар авах ял хуульчилсан нь 1942 оны хуулийн заалттай харьцуулбал 35 зүйлээр цөөрсөн. Цаазаар авах ялыг 15 жил хүртэл хугацааны хорих ялтай сонгож хэрэглэх боломжтой болсон нь дэвшил юм.

1987 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль төрийн эсрэг онц аюултай гэмт хэргүүд. зандалчлах онц хүндрүүлэх нөхцөл байдалтай санаатай алах. хүчиндэх. улс хоршоолол. олон нийтийн эд хөрөнгийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах. цагдан сэргийлэхийн ажилтан. ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах. агаарын хөлөг авч зугтаах зэрэг 12 зүйлд цаазаар авах ял хуульчилсан.

1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт. өөрчлөлт оруулах тухай хуульд 5 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр болсон. Цаазаар авах ялын талаар манай эрдэмтэн. судпаачид өөр өөрсдийн тодорхойлолт үнэлэлт дүгнэлтийг гаргасан байна Доктор Б.Содовсүрэн "БНМАУ-ын Эрүүгийн хуулийн зарим зүйлд зааснаар цаазаар авах ял шийтгэгдэгчийн хувьд хүмүүжүүлэх ач холбогдолгүй учраас үйлдсэн ба нэмэгдэл ялын аль алинд үл хамаарах онцгой ял юм.[43] Цаазаар авах ял нь ардын хувьсгалын анхны жилүүдэд хар шар феодалын ангиас ардын төрийг устгах, сулруулах зорилгоор хувьсгалыг эсэргүүцэх байгулулага байгуулах, хорлон сүйтгэх, алан хядах зэрэг нэлээд гэмт хэрэгт хэрэглэхээр тогтоосон байдаг” гэжээ.

Профессор Г.Совд 1973 онд "Манай эрүүгийн эрхэнд цаазаар авах ялыг онцгой ял гэж нэрлэсэн нь санамсаргүй тохиолдол бишээ. Цаазаар авах ял бол манай улсын ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд цаг зуурын чанартай хэрэглэгдэж. онц аюултай хэрэг үйлдсэн хүмүүст оногдуулдаг юм[44], 1993 онд шинжпэх ухааны докторын диссертацдаа "Орчин үеийн Монголын эрүүгийн эрх зүйд алах ял нь хүний амьдрах эрхийг бүрэн хасдаг учраас эрүүгийн ялын системд ордоггүй онцгой арга хэмжээ гэж үздэг байсан. Манай эрүүгийн хууль тогтоомжоор хүний амийг элдэв төрлийн гэмт халдлагаас хамгаалсан байдгийн гадна онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зарим тохиолдолд алах ялыг онцгой арга хэмжээ болгон хязгаарлагдмал бөгөөд түр зуурын чанартай хэрэглэж байна’’[45] гэж байр сууриа илэрхийлжээ.

Хуульч-судпаач Т.Дэндэв 1975 онд “Эрүүгийн хуулийн тусгай ангид нэрлэж заасан санаатай үйлдэгдсэн онц аюултай гэмт хэргүүдэд цаазаар авах ялыг оногдуулна. Гэхдээ шүүх цаазаар авах, 15 жил хүртэл хорих хоёрын аль нэгийг сонгон хэрэглэх боломжтой юм”[46] гэж, Академич С.Нарангэрэл “1993 онд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах-буудан алах ял оногдуулна гэж заахдаа хууль тогтоогч энэ ял оногдуулах хэргийн хүрээг үлэмж хэмжээгээр хумисан. үндсэн хуулиар тогтоосон хүний амьд явах эрхийг баталгаажуулах. ялын урьдчилан сэргийлэх ерөнхий нөлөөллийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор энэ ялыг үндсэн ялд хамааруулж. цаазаар авах ялыг гүйцэтгэх аргыг шууд хуульчилж өгсөн”[47] гэж тус тус үзэл бодлоо илэрхийлжээ.

## Хоёр. Цаазаар авах ял ба хүний эрх

Монгол Улсын АИХ 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлаж нийтээр дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд уг Үндсэн хуульд “Хүн бүр амьд явах эрхтэй” /16 дугаар зүйл 1 дэх хэсэг/ гэж заасан нь төрөөс

---

[42] А.Мөнх-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ялын эрүүгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал /магистрын дипломын ажил/. УБ.. 2008. 47 дахь тал

[43] Б.Содовсүрэн. Дурдсан зохиол. УБ., 1969. 112-113 дахь тал

[44] Г.Совд. Дурдсан зохиол. УБ., 1973. 348 дахь тал

[45] Г.Совд. Шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 1993. 107 дахь тал

[46] Т.Дэндэв. Дурдсан зохиол. УБ.. 1975. 27-28 дахь тал

[47] С.Нарангэрэл. Дурдсан зохиол. УБ., 1999. 299-300 дахь тал

хүний язгуур эрхийг баталгаажуулж өгсөн хэрэг юм. Мөн цааш нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулахаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно”[48] гэж заажээ. Ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялын талаар олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарт нь юуны өмнө хүний эрхийн түгээмэл тунхаглалын хэм хэмжээ бөгөөд түүний 3-р зүйлд “Хүн бүр амьд явах эрхтэй”[49] гэж заасан байдаг. Энэ эрхийг олон улсын эрх зүйн хувьд улам баталгаажуулж “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 6 дугаар зүйлийн 1.2-т “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй, Энэ эрхийг хуулиар хамгаална, Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй, цаазаар авах ялыг цуцлаагүй улс оронд уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир энэхүү Пакт болон Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн заалтад нийцсэн бөгөөд тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу тухайн этгээдэд оногдуулж болно. Энэ ялыг эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно”. 6.3-т “Хэрэв амь хороох үйлдэл нь төрлөөр устгах гэмт хэрэг мөн бол энэхүү пактад оролцогч улсууд нь төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай конвенцийн заалт ёсоор хүлээсэн аливаа үүргээсээ ямар нэгэн хэлбэрээр ухрах эрхийг энэ заалтаар олгоогүй гэдгийг анхаарвал зохино”, 6.4-т “Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр ял хэлтрүүлэх буюу ялыг хөнгөрүүлж өгөх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд ял хэлтрүүлж, өршөөл уучлал үзүүлж цаазаар авах ялыг өөрчилж болно” гэж тус тус заасан.[50] Эдгээр хэм хэмжээ нь юуны түрүүнд төрийн зүгээс хүний амь насыг хууль бусаар бусниулж хэрхэвч болохгүй гэсэн утга санааг илэрхийлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн “...Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулах тухай” заалтын агуулга нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд харшлахгүй юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 6 дугаар зүйлд цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд оногдуулах бөгөөд үүнтэй холбогдуулан цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд уучлал үзүүлэх, ялыг хөнгөрүүлэх, түүнчлэн гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүүхэд. жирэмсэн эмэгтэйчүүдэд уг ялыг хэрэглэхийг хориглосон байна. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн “Цаазаар авах ял шийтгүүлэгсдийн эрх хамгааллыг хангах арга хэмжээний тухай” баримт бичигт цаазаар авах ялыг халах уг ялыг зөвхөн “онц хүнд үр дагавар бүхий" гэмт хэргийн учир оногдуулах бөгөөд түүнийг маш тодорхой. хөдлөшгүй нотлох баримт бүрдсэн тохиолдолд шүүх оногдуулах ба хүлээлгэсэн ял үндэслэлтэй эсэхэд дараагийн шатны үр нөлөө бүхий хяналт хэрэгжих учиртай тухай онцлон тэмдэглэжээ. Энэхүү баримт бичигт цаазаар авах ял авч болзошгүй этгээдэд үзүүлэх хууль зүйн хамгааллын шаардлагыг мөн томъёолсон байна.[51]

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д “Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял[52] оногдуулж болно” гэж заасан нь энэ ялыг хэрэглэх эрх зүйн үндэс юм.

Цаазаар авах ял нь 2002 оны Эрүүгийн хуульд-үндсэн ялын төрөлд хамаардаг, цээрлэлийн хувьд хамгийн хүнд ял юм.

Энэ ялыг Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 81 дүгээр зүйлийн 81.2, 84 дүгээр зүйлийн 84.1, 91 дүгээр зүйлийн 91.2, 126 дугаар зүйлийн 126.3, 177 дугаар зүйлийн 177.2. $178^1$ дүгээр зүйлийн $178^1$.2, 302 дугаар зүйлийн 302.1-т заасан онц хүнд гэмт хэрэгт оногдуулна.

---

[48] Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

[49] Хүний эрхийн түгээмэл тунхаглал

[50] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт - Хүний эрх: Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. НҮБ. УБ.. 1992. 3. 9 дэх тал

[51] Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2009. 69 дэх тал

[52] Цаазлах буюу цаазлагдах гэж 1. Цаазаар авхуулах. хуулийн дагуу дээд хэмжээ заагдаж хороогдохыг хэлнэ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я. УБ., 2865 дахь тал

Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ. Хуульд ингэж гүйцэтгэх аргыг шууд заасан явдал Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн "гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах... зорилго. хэлбэр агуулж болохгүй" гэсэн энэрэнгүй ёсны зарчмын агуулгаас урган гарч байгаа юм. 1921 оны хувьсгалаас өмнөх Монгол Улсын Цааз хуульд энэ ялыг цавчиж алах, огтчин алах, хөвчдөн алах, бүтээж алах гэсэн дөрвөн аргаар гүйцэтгэж байсныг 1923 онд буудан алах болгосон нь өнөөг хүртэл шинэ үеийн хууль тогтоомжид уламжилагдаж ирсэн.

Богд хаант Монгол Улсын үед Нийслэл хүрээний зүүн дүүрэгт орших Шархадны ард талд нэг майхан босгож, хэрэгтнийг майханд оруулан улаан ногтоор ногтолдог байжээ. Ингэхийн учир нь тухайн ялтан нэгэнт хүний ёсыг алдсан тул ийнхүү ногтлуулж буй ажээ. Ингээд цаазын түшмэл хэрэгтний ялын тухай дурдаад хэрхэн цаазлуулах тухай сонсгоно. Дараа нь бяцхан тавганд банш хийгээд ганц савхын хамт цаазлуулах ялтанд өгдөг аж. Хэрэгтэн түүнийг идэхийг оролдовч бараг эс чадна. Үүний дараагаар хэрэгтнийг боглон майхны сүүлээр гаргана. Хэрэгтний хоёр талд улаан цув өмссөн сэлэм барьсан хүмүүс мэсээр далайлган явах бөгөөд хэрэгтэн хэзээ толгой авах бол хэмээн айж цочирдон явах үед тухайн хэрэгтний араас хэрэгтний ар дагзанд буудан цаазалдаг байжээ. Энэ үед тэр агшинд байлцсан лам хэрэгтнийг цаазалсны төлөө тодорхой ёслол үйлдэн гүйцэтгэгч нарыг шагнан. цаазлагдсан хэрэгтний хойдхыг уншин, улмаар эмэнд оруулах зорилгоор хэрэгтний биеийн зарим хэсгийг авдаг байсан байна. Олноо өргөгдсөн Монгол Улсын үед буюу 1911-1918 оны хооронд дээрх аргаар цаазалдаг байсан талаар баримт үлджээ. Улмаар Монгол Улсад үндэсний эрх чөлөөний төлөө хувьсгал ялж, анхны Эрүүгийн хууль болох Шүүх цаазын бичиг батлагдан гарч, энэ үеэс тус Шүүх цаазын бичигт заасан ёсоор цаазыг буудан алах хэлбэрээр гүйцэтгэдэг болов.[53]

Дэлхийн улс орнууд эрт үед болон өнөө үед хэрэглэж байгаа цаазлах аргуудыг товч боловч авч үзэх шаардлагатай юм. Тухайлбал эртний соёл иргэншлийн өлгий нутаг болох Грект гэм буруутай этгээдийг мөс, ус, дарсанд чанах, амьдаар нь газарт булах. арьсыг нь өвчих, зэрлэг араатанд бариулах, мөчийг нь тайрч хамгийн сүүлд толгойг нь авах зэргээр цаазалдаг байсан байх юм. Өмнөд хөрш болон оршиж байсан "Хан династи"-н үед цаазаар авах ялыг гүйцэтгэх маш харгис хэлбэр болох амсар багатай домбонд чихэх, усанд чанах, цовдлох гэх мэт аргаар гэм буруутай гэж үзсэн этгээдийг гэсгээдэг байв. Египет, Эртний Ромд дээрхээс гадна амьдаар нь шатаах. загалмайд хадах, дүүжлэх, усанд живүүлэх, гадсан дээр суулгах, заанаар гишгүүлэх аргыг хэрэглэж байжээ. Дундад зууны Франц оронд 44 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулдаг байсан бөгөөд 1610 онд нэгэн цааз түүхэнд тодорхой үлдсэн байдаг. IV Генрих хааныг хөнөөсөн гэмт хэрэгтэн Равальк гэгчийг цаазын тавцанд хүлээд бахиар махыг нь зулгаан тасдаж, тархи руу нь тугалга зутган, дараа нь хөл гараас нь моринд хүлж морьдоо тал бүр тийш нь ташуурдан зүтгүүлж хэсэгчлэн гэсгээжээ. Цаазаар авах ялыг гүйцэтгэх дундад зууны гэж хэлж болох заншил XX зууны эхэн болтол Испанид уламжлагдсан юм. Энэ нь гэмт хэрэгтнийг сандлын түшлэгт бэхэлсэн хурц ирмэг бүхий хүзүүвчний тусламжтайгаар цаазлах ялыг гүйцэтгэж байв. Ялтныг сандал дээр суулган гүйцэтгэгч бариулыг удаан эргүүлж хэрэгтний толгойд угалсан хүзүүвчийг чангалдаг. Энэ цаазыг 1931 онд цуцалсан боловч 1963 онд дахин хэрэглэсэн баримт бий. Мөн хамгийн харгис хэрцгий байдлаар цаазалж байсан жишээ нь Ирак улс бөгөөд Саддам Хусейний дэглэм ноёрхож байсан цаг үед хэрэгтнийг хүчилд хийж цаазлах аргыг ашиглаж байсан мэдээлэл байдаг. Эдгээр аргууд нь хүний бие махбодид онц их шаналал, өвдөлтийг мэдрүүлж зовоодог харгислалууд юм. Эдүгээ энэ төрлийн ялыг хэрэглэж байгаа улс орнуудад үндсэн 7 төрлийн аргаар цаазыг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ төрлүүд нь "хууль ёсны аллагын" хэмжээнд зөвшөөрөгдсөн байна.

Цаазаар авах ялыг арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулахгүй. Энд гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй байх ёстой бөгөөд

[53] А.Мөнх-Эрдэнэ. Дурдсан магистрын дипломын ажил. УБ., 2008. 42 дахь тал

шүүхээр хэргийг хэлэлцэж шийдвэр гаргах үед арван наймаас дээш насанд хүрсэн нь цаазаар авах ял оногдуулах үндэслэл болохгүй.

Нас харгалзахгүйгээр бүх эмэгтэй шүүгдэгч нарт цаазаар авах ялыг хэрэглэхгүй байхаар тайлбарлаж буй зүйлийн 4 дэх хэсэгт хуульчилжээ. Манай улс нэгдэн орсон Иргэний болон Улс Төрийн эрхийн тухай олон улсын Пактын гуравдугаар хэсгийн 6 дугаар зүйлийн ‘ гэмт хэрэг үйлдсэн арван найман нас хүрээгүй этгээдэд цаазаар авах ял оногдуулахгүй бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд ялыг ёсоор гүйцэтгэхгүй” гэж зааснаас үзэхэд хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын дагуу эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохоор байна. Тэгээд ч Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1. дэх хэсэгт “Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль. олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ.” гэж тус тус заасан нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хүйсээр нь ялгаварлахгүйгээр цаазаар авах ял хэрэглэх боломж олгосон эрх зүйн үндэс юм. Иймд эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулахаар хуульчилах шаардлагатай юм.

Жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулахгүй байх нь гэмт хэрэг үйлдэх үед заавал жаран нас хүрсэн байхыг шаардахгүй бөгөөд жаран нас хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэж, улмаар шүүхээр хэргийг нь хэлэлцэх үед жаран нас хүрсэн нь холбогдох нотлох баримтаар тогтоогдож байвал энэ ялыг хэрэглэж болохгүй гэсэн агуулгыг илэрхийлж байна.

Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар баталсаны дараа энэ тухай 10 хоногийн дотор ялтанд мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх ялтан амь уучлахыг хүссэн өргөдөл гаргах эсэхийг тодруулж, хэрэв гаргавал түүнийг. хүсэлтгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж Улсын Дээд шүүхэд ирүүлбэл зохих тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд /131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэг/ заасан.

Улсын Дээд шүүх өргөдөл буюу тэмдэглэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлнэ. Уучлал хүссэн өргөдөлд тухайн этгээдийн талаарх тодорхойлолт материал, түүний үйлдсэн гэмт хэргийг шалгаж тогтоосон хавтаст хэргийг хавсаргадаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2002 оны 156 дугаар зарлигаар "Ялтанд уучлал үзүүлэхийг хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх журам”-ыг баталсан. Уг журамд ялтанд уучлал үзүүлсэн тухай Ерөнхийлөгчийн зарлигийг ажлын 8 цагт багтаан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газарт хүргүүлэхээр заажээ. Монгол Улсын Ерөнхийлөгч хэргийг хүлээн авснаас хойш 30 зайлшгүй шаардлагатай бол 20 хоногийн дотор ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудпыг шийдвэрлэх тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд /131 дүгээр зүйлийн 131.3 дахь хэсэг/ заасан.

Уучлалын асуудпыг шийдвэрлэх хүртэл цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэхийг түдгэлзүүлдэг.

Монгол Улсын шинэ Үндсэн хуульд зааснаар иргэн хүн амьд ява> эрхтэй. Гэвч энэ нь шударгаар ажиллаж амьдарч яваа жирийн иргэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэг үйлдсэн, ялангуяа эрдэнэт хүний амийг санаатай бүрэлгэсэн этгээд хоёулаа заавал амьд байна гэсэн ойлголг биш.

Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд амь уучлахыг хүссэн өргөдлее Монгол Улсын Ерөнхийлөгчид хэрхэн гаргах, шийдвэрлүүлэх талаар өмнв нэгэнт өгүүлсэний зарим утга санааг энэ хэсэгт хамааруулан ойлгох нь зүйтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч ялтанд уучлал үзүүлээгүй бол ялыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан байна.

Цаазаар авах ялыг гүйцэтгэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан тусгай журмыг баримтлана. Энэ асуудал улсын нууцын зэрэглэлд багтдаг учир энд нарийвчлан дэлгэрэнгүй

дурьдаж боломжгүй юм.

Ерөнхийлөгч 2014 оны 1 дүгээр сарын 14-нд хэлсэн үгэндээ "Монгол Улсын Үндсэн хуульд эрэмблэн тунхагласнаар хүний эрхэм эрхийн хамгийн дээд нь амьд явах эрх юм. Миний бие ерөнхийлөгчөөр ажилласан хугацаанд Монгол Улсад цаазаар авах ялын гүйцэтгэл хийгдээгүй гэдгийг онцлоод төрийн тэргүүний хувьд миний барих зарчим бол тэр ялтны. тэр иргэний амийг уучлах явдал гээд цаашид энэ зарчмаа тууштай баримтлан ажиллахаа мэдэгдсэн нь олны талархал, дэмжлэгийг зүй ёсоор хүлээсэн нь тодорхой.

Ерөнхийлөгч хүний амины эрхэм үнэлэмжийг баталгаажуулахад хүргэсэн ийм зарчим баримтлан цаашид ажиллах болсноо онолын үндэслэлтэй практикийн ач холбогдолтой найман шалтгаан, онцгойлон авч үзэх хоёр нөхцөлөөр тайлбарлахдаа *“Ардчилсан Монголын зам ариун, цусгүй байх ёстой”,* 2010 оны шинэ жилийн эхний өдөр иргэддээ хандан “Монголынхоо сайн нэрийг та гаргаж чадна” гэсэн мессэж илгээснээ тэмдэглээд илтгэлийнхээ төгсгөлд “Монголчуудаа! миний ард түмээн! Тэнгэр заяа, их хувь, сайн нэрээ хичээж нэр төртэй амьдарцгаая” гэж нийт ард түмэндээ уриалсан явдал бол нэг иргэн нөгөө иргэнийхээ амийг хороодоггүй байх, иргэн бүр ариун нэр төр, алдар хүндээ ямагт дээдэлж явахыг хүсэмжилсэн гүн агуулгыг илэрхийлж байгаа юм. Тэгээд ч Ерөнхийлөгчийн хүний эрхийг эрхэмлэн дээдэлсэн шийдвэр. цаашид энэ талаар тууштай баримтлах түүний зарчим нь алах ялын хүнлэг бус, харгис, ноцтой шинжүүдээс шууд урган гарч байгаа юм. Энэ нь алах ялыг гүйцэтгэж байгаа нь: *Нэгдүгээрт,* Хүний амьд явах эрхийг төр санаачлан дуусгавар болгож байгаа учраас хүмүүнлэг, иргэний ардчилсан төрийн бодлого, үил ажиллагаанд үндсээрээ харш юм: *Хоёрдугаарт,* Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хувь хүнийх нь хувьд төрийн нэрийн өмнөөс шууд устгаж байгаа тул гэм буруутай этгээдийн хувьд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг хүмүүжүүлэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх тухай ялын зорилгод огт нийцэхгүй байгаа юм: *Гуравдугаарт,* Шүүхээс алдаатай өөрөөр хэлбэл. хүнийг хилсдүүлэн цаазлах шийдвэр гарч. түүнийг гүйцэтгэсэн тохиолдолд хэзээ ч дахин сэргээх боломжгүй байдагтай холбоотой гэж үзэж байна.

Ял хэлтрүүлэх буюу ялыг хөнгөрүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд ял хэлтрүүлж өршөөл, уучлал үзүүлж цаазаар авах ялыг өөрчилж болно гэсэн заалтууд. Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1984 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсам заалтууд, түүнчлэн Цаазаар авах ялыг халах тухай Хүний эрхийш Америкийн Конвенцийн протокол, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын Конвенцийн 6 дугаар протокол нь Энх тайван цагт цаазаар авах ялыг халах тухай гэрээ юм. Харин Хүний эрхийн Европын Конвенцийн 13 дугаар протокол нь ямар ч нөхцөлд цаазаар авах ял оноохыг хориглодог. Энэ ялын хамгаалалтын нэмэлтүүдийг баталсан Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1989 оны 64 дүгээр тогтоод. “Хамгаалалтыг бэхжүүлэх тухай” мөн зөвлөлийн 1996 оны 15 дугаар тогтоол зэрэгт цаазаар авах ялыг халаагүй гишүүн орнуудад энэ ялаар шийтгүүлсэн хүмүүсийн эрхийг хамгаалах талаар тодорхой аргэ хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий чуулганаас “Цаазлан хороох ял гүйцэтгэхээс татгалзахьг уриалан гаргасан 2007 оны 12 дугаар сарын 18-ны тогтоолд “Хүний эрхийн комиссын удаа дараагийн бүх хурлаар батлагдсан тогтоолуудыг тэдгээрийн хамгийн сүүлчийн 2005/59 тоот буюу цаазаар хороох яя хэрэглэсээр буй улс орнуудад хандаж уг ялыг бүрэн цуцлахын зэрэгцээ энэ ялыг гүйцэтгэхээс татгалзахыг уриалсан тогтоолыг дурьдаж цаазаас хороох ял хүчин төгөлдөр байдаг бүх оронд хандаж: а) цаазаар хороогдох ял авсан хүмүүсийн эрхийг хамгаалах баталгаа болдог олон улсын хэм хэмжээг ялангуяа Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1984 оны 1984/50 тоот тогтоолын хавсралтад заасан наад захын хэм хэмжээг хүндэтгэх; б) яваандаа цаазаар хороох ял хэрэглэхийг хязгаарлах; в) цаазаар хороох ялыг цуцлана гэсэн бодлын үүднээс цаазлах ял гүйцэтгэхээс татгалзал гаргах; г) цаазаар хороох ялыг цуцалсан орнууд уг ялыг дахин сэргээхгүй» байхыг тус тус уриалсан байдаг”

Манай улсын хувьд эдгээр олон улсын хэм хэмжээ нь дотоодод үндэсний хууль тогтоомжийн

нэгэн адил үйлчлэх ёстой юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял. эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус. хэрцгий хандах. нэр төр алдар хүндийг нь гутаах зорилго. хэлбэр агуулж болохгүи' гэж энэрэнгүй ёсны агуулгыг хуульчилсан нь агуулгаараа хүнийг хилсээр шийтгэх эрсдпийг агуулдаг. хэт харгис цаазын ялаас татгалзах эрх зүйн үндэс мөн. Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс угсаа. хэл, арьсны өнгө, нас. хүйс, нийгмийн гарал. байдал, хөрөнгө чинээ. эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг. үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ’- гэж тэгш эрхийн зарчмыг хуульчилсан. Гэтэл энэ хуулийн 53 дугаар зүйлийн 4 дэх эхсэгт "арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд. жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй” гэсэн заалт нь энэрэнгүй шинжтэй болович дээр дурдсан тэгш эрхийн зарчмыг зөрчсөн зохицуулалт юм. Ингэж гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг нас. хүйсээр ялгаварлан цаазаар авах ял хэрэглэхийн оронд бүрмөсөн халах нь илүү оновчтой гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно” гэсэн заалт агуулгын хувьд хэрэглэхгүй байж болно гэсэн утгыг илэрхийлж байна.

Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан ялтанд ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй” тухай заалтаас харахад цаазаар авах ял нь уучлагдсан ялтан 30 жилийн хорих ялыг гянданд бүрэн эдэлж дуусах нь тодорхой байна. Энэ ял нь цаазаар авахаас илүү хүнд цээрлэлийг агуулдаг болохыг Ерөнхийлөгчийн “амь уучлах гэдэг нь ял уучлах гэсэн үг биш, өнөөдрийн мэдэгдэж байгаа албан ёсны баримтаас үзэхэд хуульд заасан энэхүү ялыг бүрэн эдэлж дуусгасан амьд хүн манай улсад алга байна. Тэндээс наранд гарсан хүн одоо алга гэсэн үг. Өөрөөр хэлбэл тухайн хэрэгт ногдуулсан ял нь шударга байх юм бол тэр этгээд үхэн үхтлээ үйлээ шоронд эдлэх нөхцөл монголд үйлчилж байна” гэсэн үгнээс тодорхой харж болно. Ялтан удаан хугацаагаар гянданд ганцаарчлан хоригдож цаазаас илүүтэй зовон тарчилах болович амьд байгаа цагт уучлагдах, гэм буруугүй болох нь тогтоогдвол суллагдах горьдлого бага байна.

**Гурав. Цаазаар авах ялыг халах үндэслэлүүд**

1. Цаазаар авах ял гэмт хэргийн гаралтыг бууруулдаггүй. Нийгэм оюун санааны хувьд доройтолд орсон нөхцөлд гэмт хэргийн гаралт нэмэгдэж, эрүүгийн нөхцөл байдал хүндэрдэг нь зүй тогтол юм. Иймд төр иргэнээ хамгаалж чадаагүйн төлөө, гэмт хэргийг бууруулахад оновчтой бодлого үйл ажиллагаа явуулаагүй байж бусдын амь насыг хороох нь байж болшгүй явдал. Тийм учраас энэ ялыг хэрэглэж болохгүй. Өөрөөр хэлбэл төр иргэдээ аллагаар сүрдүүлснээрээ олон нийтийн дэмжлэгийг хүлээж чадахгүй. Гэмт хэрэг гэдэг бол нийгмийн үзэгдэл бөгөөд гагцхүү түүнийг хуулийн хяналтаас гаргаж болохгүй. Хүн амины хэрэг үйлдэж буй хүмүүс олонх тохиолдолд эрүүл бус сэтгэцийн нөхцөл байдлаасаа болж (архидан согтуурсан эсхүл сэтгэцийн хямралд орсон байх үедээ) хийж буй үйлдлийнхээ үр дагаварыг ухамсарлах чадваргүй байдаг. Тиймээс тухайн нөхцөлд цаазаар авах ялаас айж эмээх сэтгэл тэдэнд төрдөггүй. Нөгөөтэйгүүр цаазаар авах ялаас айж сүрдэх нь бүр ч эсрэг үр дүн авчирдаг. Цаазын ялаас айсан гэмт хэрэгтэн “би дүүрсэн хүн” гэсэн сэтгэхүйгээр хандаж хохирогчоосоо гадна уг гэмт хэргийг харсан бүх гэрчийг устгахыг оролддог. Гэмт хэрэгтнийг баривчлах, яллах, шийтгэх нь гэмт хэргээс сэргийлэх найдвартай хамгаалалт болдог.

2. Цаазаар авах ял нийгмийн эмзэг бүлгийнхэнд илүү оноогддог: Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн дийлэнх хувь нь амьдралын түвшин доогуур, эмзэг бүлгийн иргэд байдаг. Учир нь тэд Үндсэн хуулиар олгогдсон өөрийгөө хамгаалах, хууль зүйн туслалцаа авах зэрэг эрхээ мөнгө байхгүйн улмаас эдэлж чаддаггүй. Өнөөдөр Монголд хөдлөшгүй баримт нотолгоогоор хүний гэм буруутайг тэр бүр тогтоож чадахгүй байна. Гэрчийн мэдүүлэг хөдлөшгүй баримт нотолгоо болж чаддаггүй. Хэн ч үгсэн хуйвалдаад нэгнийхээ эсрэг мэдүүлэг өгч болно. Манай нотлох баримт

бүрдүүлэх арга ихээхэн хоцрогдсон, шинжлэх ухааны ололт дэвшлийг ашиглаж чадахгүй байгаа гэдгийг судлаачид сануулсаар байна.

3. Шүүхийн алдаатай шийдвэр хэлмэгдүүлэлт авчирдаг. Цаазаар авах ялыг оноохдоо гэмгүй иргэний амийг хууль шүүхийн ажиллагааны алдаанаас болж төр егүүтгэсэн байх, эсвэл егүүтгэх шахаж байсан зэрэг шүүхийн ноцтой алдаанууд гарч байсан удаатай. Тухайлбал Завхан аймгийн харъяат Ч.Эрдэнэ-Очирыг 6 жил 8 сар 23 хоног мөрдөн шалгаж, 6 удаа прокурор түүнд яллах дүгнэлт бичиж, 3 удаа шүүх түүнд цаазаар авах ял оноосон байдаг. Харин дээд шатных нь шүүхийн магадлангаар түүний хэрэг хэрэгсэхгүй болсон. Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт гарсан хүн амины хэрэгт Монгол Улсын 5 иргэн сэжиглэгдэж тус бүр 207-1252 хоног хоригдсон байдаг. Тэр тавын дөрөвт нь шүүхээс нэг удаа цаазаар авах ял оноосон. Харин эцсийн шатны шүүхийн шийдвэрээр тэдгээр нэр бүхий иргэд цаазаар авахуулах биш, үйлдсэн гэх хэрэг нь хэрэгсэхгүй болж цагаадсан. Нөхөшгүй алдаанаас зайлсхийх хамгийн оновчтой арга нь цаазаар авах ялыг бүх насаар нь хорих эсхүл тодорхой хугацаагаар хорих ялаар солих явдал юм. Өөрөөр хэлбэл гэмт этгээдийг баталгаатай шийтгэхийн тулд гэмгүй нэгнийг цагаатгах боломтой байлгахын тулд цаазаар авах ялыг халдаг. Хоригдож буй хүний гэм буруугүй нь нотлогдвол түүнийг суллаж болдог, гэтэл цаазлуулсан хүнийг дахин амьдруулах ямар ч арга байхгүй. Хууль дээдлэх зарчимд тулгуурласан хамгийн боловсронгуй хуулийн тогтолцоо ч гэсэн хууль зүйн алдаанаас ангид байж чаддаггүй. Хууль ёс алдаа дутагдалтай байсан цагт гэм буруугүй хүнийг цаазлах эрсдэл хэзээ ч арилахгүй.

4. Цаазаар авах ял нь хүчирхийллийг зогсоох талаар ямарваа нэг шийдэл санал болгохын оронд харин ч түүнийг бэхжүүлж байгаа хэрэг мөн. Төрөөс хүний амийг хороож байгаа нь хүч хэрэглэх явдлыг өөгшүүлж, хүчирхийллийн тойргийг бий болгодог. Төр хүний амийг хороож байгаа нь хүний амь нас ямар ч үнэ цэнэгүй болохыг бусдад харуулж бас сургаж байна. Цаазаар авах ял бол төрийн зүгээс шийдвэрлэж чадахгүй байгаа нийгмийн асуудлаа төмөр нү%үр гарган, хүчирхийллийн аргаар түргэн шийдэх гэсэн оролдлого юм. Харин өнөөдөр хорих байгууллагуудын шинэчлэлийг хийх хэрэгтэй байна. Хорих байгууллагын зорилго бол хүнийг гэмшүүлэх, ойлгуулах, хүмүүжүүлэх, өөрчилж нийгэмд нь буцаан аваачих явдал юм. Өнөөдөр манайд нийгмийн хамгийн идэвхитэй хэсэг болох 18-60 хүртэлх насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял дангаараа ногдож байна. Энэ насны эрэгтэйчүүдийг засан хүмүүжүүлэх талаар төрөөс маш бага анхаарч байгаа юм. “Мунхаг хүн нэгийг ална. Мунхаг төр дахиад нэгийн амийг хорооно” гэсэн үг байдаг.

5. Төр “Хүн байхгүй бол асуудал байхгүй” хэмээн хандаж байгаа нь шударга бус байна. Гэмт этгээдийг цаазалсанаар төр асуудлыг хаадаг. Гэтэл хүнээ алдсан гэр бүлийн уй гашуу барагдахгүй. Тэдэнд “Та нарын хүсэлтийн дагуу амийг амиар сольсон” хэмээн хэлээд хэргийг дуусгадаг. Харин цаазаар авах ялыг халсанаар хохирогчийн нөхөн төлбөрийн асуудал, ялтныг гяндanд тохирсон хөдөлмөр эрхлүүлэх замаар насан туршид нь төлбөрийг барагдуулах зэрэг бусад эдийн засгийн шийтгэлийн хувилбаруудыг хэрэгжүүлэх боломж нээгдэнэ.

6. Цаазаар авах нь хүний амийг санаатайгаар, онц хэрцгийгээр бүрэлгэж байгаа хэрэг мөн. Цаазаар авах ялын гүйцэтгэл нууцаар явагддаг. Хэнийг хэзээ яаж хороосныг хэн ч мэддэггүй. Ар гэрийнхэн нь  ядаж цаазлагдах өдөр цагийг нь хэлээд өгөөч зул асаая гэж гуйдаг. Шарилыг нь аваад оршуулья гэдэг. Гэтэл ямар ч тийм боломж байдаггүй ба бүх зүйл хүний ёсноос гадуур явагддаг. Цаазаар авах ялын гүйцэтгэлийг тойрсон нууцлалын асуудал нь харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэж байгаа явдал хэмээн хүний эрхийн олон судлаач шинжээч, бие бүрэлдэхүүн үзсэн байдаг.

7. Цаазаар авах ялыг тогтолцоондоо байлгасаар байх юм бол энэ ялыг улс төрийн зорилгоор ашиглах боломж нь улс төрчдийн гарт орж ирдэг. Төрийн нэрийн өмнөөс гэсэн мөртлөө олны нүд, хараа хяналтаас нууц далд байлгаж хороодог энэ ялыг халах нь туйлын зөв шийдэл юм.  Иргэдээс цаазаар авах ялын талаархи мэдээллээ нуух ньо байж боломгүй дарангуйллын хэлбэр мөн. Улс төрчид

ихэнхдээ энэ дарангуйллаа хадгалах гэсэндээ цаазаар авах ялыг халах эсэх асуудлаар бүх нийтийн асуулга явуулах хэрэгтэй, иргэдийн ихэнх нь дэмжиж байна гэсэн үндэслэлгүй шалтаг хэлдэг.

8. Цаазаар авах ялыг халахын төлөөх дэлхий нийтийн хөдөлгөөнөөс Ардчилсан Монгол улс хоцрох ёсгүй. Өнөөдөр дэлхийн улс орнуудын гуравны хоёроос илүү буюу 139 гаруй улс цаазаар авах ялыг хуульдаа болон практикт халсан ба 58 улс хэрэглэж байгаа ч жил ирэх тусам энэ ялыг халж байгаа улс орнуудын тоо нэмэгдсээр байгаа ба 2009 онд 18 улс оронд л цаазаар авах ялыг гүйцэтгэжээ. Европ ба Төв Ази, Америк тив (АНУ бусад), нь бүхэлдээ шахуу цаазын ялаас татгалзаад байна. Африк Холбооны улсууд цаазаар авах ялыг халах асуудалд нааштай хандаж үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулах замаар цаазаар авх ялыг халах боломжийг бий болгож байна. 2009 онд Бурунди Того улс цаазаар авах ялыг халжээ. АНУ-ын 15 муж улс цаазаар авах ялыг халсан ба хэрэглэж байгаа 35 муж улсын 10 нь сүүлийн 10 жилд нэг ч цаазаар авах ялыг гүйцэтгээгүй байна. Цаашид энэ ялыг бүрэн дүүрэн халах талаар олон муж улсад хэлэлцэж байна.

9. Цаазаар авах ял нь хэрцгий, хүнлэг бус, гутаан доромжилсон ял шийтгэл мөн гэдгийг олон улс хүлээн зөвшөөрч, дэлхий даяар цаазын ялаас татгалзахыг уриалсан тогтоолыг НҮБ-аас 2007, 2008 онд гаргасан байна. НҮБ-ын Тусгай Илтгэгч 2005 онд Монгол улсад айлчлахдаа цаазаар авах ялыг халахыг зөвлөмж болгосон.

10. Цаазаар авах ялыг тухайн улс үндэстний бүх хүмүүсийн нэрийн өмнөөс гүйцэтгэдэг. Тиймээс хүн бүр цаазаар авах ял гэж юу болох, энэ ялыг хэрхэн яаж хэрэглэж байгааг, тэдэнд яаж нөлөөлж болохыг, хүний үндсэн эрхийг хэрхэн зөрчиж байгаа талаар бүгдийг нь мэдэх ёстой.

11. Цаазаар авах ял нь хуулиас гадуур хүний амь хороохтой адил хүний амьдралын үнэ цэнийг үгүйсгэсэн хэрэг бөгөөд амьд явах эрхийг зөрчиж байгаа нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан бүх эрх биелэх үндсийг үгүй хийж буй юм.

**Дүгнэлт**

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулахаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно гэж заасан байдаг ба ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ял нь хүн бүр амьд явах эрхтэй гэх эрхийг зөрчиж буй хүний эрхийн эсрэг үйлдэл болж байна.

Энэ эрхийг олон улсын эрх зүйн хувьд улам баталгаажуулж хүн бүр амьд явах салшгүй эрхтэй, энэ эрхийг хуулиар хамгаалах ба хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй, цаазаар авах ялыг цуцлаагүй улс оронд уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх зориолгоор тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу тухайн этгээдэд оногдуулж байна.

Энэхүү цаазаар авах ял нь хүний эрхэд халдаж буй нэг хэлбэр гэж үзвэл, дараах үндэслэлүүдийг баримтлан цаазаар авах ялыг халална. Үүнд:

- Цаазаар авах ял гэмт хэргийн гаралтыг бууруулдаггүй;
- Цаазаар авах ял нийгмийн эмзэг бүлгийнхэнд илүү оноогддог;
- Шүүхийн алдаатай шийдвэр хэлмэгдүүлэлт авчирдаг;
- Цаазаар авах ял нь хүчирхийллийг зогсоох талаар ямарваа нэг шийдэл санал болгохын оронд харин ч түүнийг бэхжүүлж байгаа хэрэг мөн;
- Цаазаар авах нь хүний амийг санаатайгаар, онц хэрцгийгээр бүрэлгэж байгаа хэрэг мөн;
- Цаазаар авах ял нь хуулиас гадуур хүний амь хороохтой адил хүний амьдралын үнэ цэнийг үгүйсгэсэн хэрэг бөгөөд амьд явах эрхийг зөрчиж байгаа нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан бүх эрх биелэх үндсийг үгүй хийж буй юм гэх мэт өгүүлэлийн үндсэн хэсгүүдэд дурдсан бусад үндэслэлүүд хамаарч байна.

**Санал**

1. Цаазаар авах ял нь хэрцгий, хүнлэг бус, гутаан доромжилсон ял шийтгэл мөн гэдгийг олон улс хүлээн зөвшөөрч, дэлхий даяар цаазын ялаас татгалзахыг санал болгож байгаа тул цаашдын хөгжлийн чиг хандлагадаа энэхүү саналыг үндэслэх;
2. Цаазаар авах нь хүний амийг санаатайгаар, онц хэрцгийгээр бүрэлгэж байгаа хэрэг гэдгийг хүн бүрийн ухамсарын түвшинд суулгаж, цаазаар авах ялыг эргэн сэргээх хүсэлтэй иргэдэд цаазаар авах ял гэмт хэргийн гаралтыг бууруулдаггүй гэдгийг ухуулан тайлбарлаж үүнийг хүний амьдралын үнэ цэнийг үгүйсгэсэн амьд явах эрхийг зөрчиж байгаа хэрэг гэдгийг таниулах үйл ажиллагааг иргэдэд чиглүүлэн явуулах зэрэг ажлуудыг санал болгож байна.

## Ашигласан материалын жагсаалт:


1. Г.Сүхбаатар. Монголын эртний түүх судлал 1 боть. Монголчуудын эртний өвөг. УБ. 2000 он
2. Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал. УБ. 2012 он
3. И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. Тэргүүн боть. УБ. 2005 он
4. Э.Авирмэд, Д.Дашцэдэн. Дурдсан бүтээл. УБ., 1997 он
5. Б.Амарбаясгалан. Цаазаар авах ял: Олон улсын болон Монголын эрүүгийн эрх зүйн уялдаа холбоо. Докторын диссертаци. УБ., 2013 он
6. Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. УБ . 2004 он
7. Ж Вернадский. Чингис хааны их засгийн судалгаа. УБ.. 1992 он
8. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.. 1998 он
9. Плано Карпини. Монголчуудын түүх. УБ.. 1998 он
10. С.Жалан-Аажав. Дурдсан зохиол. УБ., 1958 он
11. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ , 2011 он
12. А.Мөнх-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ялын эрүүгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал /магистрын дипломын ажил/. УБ.. 2008 он
13. Б.Содовсүрэн. Дурдсан зохиол. УБ., 1969 он
14. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
15. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
16. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт - Хүний эрх: Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. НҮБ. УБ.. 1992. 3. 9 дэх тал
17. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2009. 69 дэх тал


## ХАВСРАЛТ

Дэлхий даяар 2016 онд нийт 1032 цаазын ял гүйцэтгэсэн нь өмнөх оныхоосоо 37% -иар буурсан үзүүлэлт юм.

Иран, Саудын Араб, Ирак, Пакистан, Хятад зэрэг улс дэлхийд цаазаар авах ялын гүйцэтгэлээр тэргүүлсэн хэвээр байна.

2006 оноос хойш анх удаа АНУ тэргүүлэх таван улсад багтаагүй бөгөөд цаазаар авах ялын гүйцэтгэл жилбүр буурсаар байна.

Бенин, Науру улс цаазаар авах ялыг бүрэн халсан бол, Гвиней улс ердийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг халчихаад байна.

Хятад улсын цаазаар авах ялын хэрэглээ нь тус улсын нууцын нэг хэвээр байгаа ба жил бүр мянга мянгаар нь цаазалсаар байгаа тухай Эмнести Интернэшнл өнөөдөр хэвлэн гаргаж буй 2016 оны цаазаар авах ялын талаарх дэлхийн тоймдоо өгүүлсэн байна.

Хятадын эрх баригчид шүүхийн ил тод байдалд дэвшил гаргаж байгаа тухайгаа хэд хэдэн удаа мэдэгдэж байсан ч цаазаар авах ялын гүйцэтгэлийн талаарх цочирдом тоо хэмжээгээ далдлахын тулд нууцалсаар байгааг "Эмнести Интернэшнл"-ийн судалгаа харууллаа.

Хятадаас гадна дэлхийн улс орнууд 2016 онд 1032 цаазаар авах ял гүйцэтгэжээ. Хятад улс бусад орнуудын нийлбэр дүнгээс илүү олон цаазаар авах ял гүйцэтгэсэн бол АНУ анх удаа 2016 онд түүхэндээ хамгийн бага цаазаар авах ял гүйцэтгэлээ.

“Хятад дэлхийн тавцанд тэргүүлэгч байхыг хүсдэг ч дэлхийн бусад орнуудаас илүү олон хүнийг цаазалж хамгийн муу замаар тэргүүлж байна. Хятадын засгийн газар шүүхийн ил тод байдал, нээлттэй байх асуудалд хойрго хандаж, бодит үнэнийг нуун далдалсаар байна. Ихэнх улс орнууд өнгөрсөн хугацаанд төрийн нэрийн өмнөөс цаазлахаа зогсоосон. Гэвч цөөн хэдэн улс л цаазаар авах ялыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа ба дөрвөн улс нийт гүйцэтгэлийн 87 хувийг хэрэгжүүлсэн нь цаазаар авах ял нэг их удаан оршин тогтнохгүйг харууллаа.

Хятад улсын шүүх тогтолцоонд нуух зүйл байхгүйн нотолгоо бөгөөд “цаашид нээлттэй байхад чухал алхам” хэмээн сурталчилж байсан үндэсний шүүхийн онлайн мэдээллийн санд нь олон зуун цаазаар авах ялтай хэргүүд ороогүй байгааг Эмнести Интернэшнлийн судалгаа илрүүлсэн. 2014-2016 оны хооронд хамгийн багадаа 931 (нийт гүйцэтгэлийн өчүүхэн хэсэг) хүн цаазлагдсан тухай олон нийтэд мэдээлсэн ч тэдний зөвхөн 85-ийг нь л Хятад улс мэдээллийн сандаа байршуулжээ.

Хамгийн багадаа мансууруулах бодистой холбоотой хэргээр 11 гадаадын иргэн цаазаар авахуулсан тухай мэдээллийн хэрэгслээр цацсан ч үүнийг мэдээллийн санд оруулаагүй байна. Мөн “терроризм” болон мансууруулах бодистой холбоотой олон гэмт хэргийг орхигдуулсан байна.

Хятад улсад сүүлийн хэдэн жил хийгээгүй хэргийнхээ төлөө цаазлуулсан хүмүүсийн тоо нэмэгдсээр байгаа нь түгшүүр төрүүлж байна. 2016 оны 12-р сард Ардын Дээд Шүүхээс шударга бусаар шүүгдэн цаазлуулсан Ни Шүбиний хэргийг цагаатгасан. Түүнийг 21 жилийн өмнө 20 настайд нь цаазалжээ. 2016 онд Хятадын шүүх цаазаар авах ялтай дөрвөн хүнийг гэм зэмгүй болохыг тогтоож ялыг хүчингүй болгосон.

Малайз улс ч мөн цаазаар авах ялыг нууцалсаар байна. 2016 онд парламентаас шахалт үзүүлсний улмаас 1000 гаруй хүн цаазаар авах ялтай байгаа ба 2016 онд есөн хүн цаазлуулсан тухай мэдээллийг ил болгосон нь өмнөх тоо баримтаас хол зөрүүтэй байв.

АНУ 2016 онд 20 цаазаар авах ял гүйцэтгэсэн нь 1991 оноос хойш бүртгэгдсэн хамгийн бага тоо бөгөөд 1996 оныхоос 2 дахин, 1999 оныхоос бараг 5 дахин бага байлаа. 2009 оноос хойш цаазаар авах ял гүйцэтгэх нь жил бүр буурч байна. Гэвч АНУ-д цаазаар авахуулах ялтай 2832 хүн байна.

2016 онд АНУ-ын таван муж цаазаар авах ял гүйцэтгэсэн. Үүнд, Алабама-2, Флорида-1, Жоржиа-9, Миссүри-1, Техас-7 ял гүйцэтгэснээс харвал 2016 онд цаазаар авах ялын нийт гүйцэтгэлийн 80 хувийг Техас болон Жоржиа мужууд хэрэгжүүлсэн байна. Харин Арканзанс болон нийт 12 муж цаазаар авах ялыг халахаар сүүлийн 10 гаруй жилийн турш нэг ч ял гүйцэтгээгүй байна.

**А.Анударь (30 нас), эрх зүйч:**

Цаазаар авах ялыг арга зам гэж харж, дэмжиж, өөгшүүлж байгаа хүмүүст маш их харамсч байна. Энэ бол гол асуудал болох хүчирхийллийн соёл, жендерт суурилсан хүчирхийллийн асуудлаас маш хол, шууд холбоогүй тиймдээ ч хэзээ ч шийдэл болохгүй, харин ч эсрэгээрээ хүчирхийллийн соёлыг бэхжүүлсэн бодлого... Үүн дээр нь дөрөөлөөд, олон нийтийн захиалга мэтээр зарим нь улс төр хийнэ. Гэтэл бид хүчирхийлэлгүй, аюулгүй нийгмийг л хүсэж байгаа болохоос хэрэг гардаг, хийснийг нь алчихдаг тэгээд ханачихдаг нийгмийг хүсэж байгаа биш биз дээ...

**Э.Ананда (26 нас), IT инженер:**

Цаазын ял сэргээлээ гээд ухамсарт нь юм орохгүй байх өө. Харин ч цаазлуулчих вий гээд хэрэгтний хамаатан садан ойр тойрныхон нь хэргүүдийг нууж хав дарах нь ихсэх байх. Харин Япон шиг бүх төрлийн гэмт хэрэгтнүүдийг мэдээ, сонин, сайтаар овог нэр устай нь ӨДӨР ТУТАМ зарлаад сонордуулаад байвал ичиж магадгүй.

**Э.Очхүү (26 нас), Инженер:**

Цаазын ял бол боловсролын хэм хэмжээг илэрхийлж байгаа юм их л харанхуй хүмүүс дэмжээд байна уу гэмээр харагдаж байна. Бүх насаар нь хорих чанга дэглэмтэй гээд харах өнцөг олон шүү дээ яагаад цаазын ял гэж. Цаазын ял дэмжигчид Монголын төрд байна гэдэг тун харамсалтай. Тэд хүчирхийлэгчдээс дутахгүй зэрлэг улсууд байна. Өөр үг алга! Цаазын ял МОНГОЛ төрийн нэрийн өмнөөс хийгддэг!

**Т.Туяажаргал , "Ээлтэй ертөнц" ТББ-ийн тэргүүн:**

Олон хүн яг над шиг "Хүүхэд хүчирхийлэгчдийг цаазлая!!!" гэсэн зургийг нүүр зургаа болгон хэрэглэж байна. Цаазын ял гэдэг хамгийн харгис, хүний эрх талаас яривал байж боломгүй зүйл.

Гэхдээ. . .Хүчирхийлэл үйлдэгч этгээд цочирдоосой. Энэ олон хүн, нийгэм тэдэнтэй эвлэрэхгүй, үзэн ядаж байгааг тэд мэдрэх ёстой гэж ингэж сольсон. Хүчирхийлэл үйлдэгч зэрлэгшсэн адгууснууд өөрсдөө энэ зүйлийг нийгмийн энэ үйлдлийг тархиндаа зүрхэндээ мэдэртэл.

**Б.Билгүүн (27 нас), График дизайнер:**

Би цаазын ялыг сэргээнэ гэсний эсрэг байр суурьтай байгаа. Яагаад гэхээр энэ чинь буцаад хөгжлөөр нэг алхам ухарч алхаж байгаатай адил шүү дээ. Амийг амиар солиод үхсэн хүн эргээд сэрэхгүй, үйлдсэн хэрэг нь буцаад ухрахгүй. Харин ч цаазын ялтай оронд хүнд гэмт хэрэг их байдаг талаар уншиж байсан юм байна. Аль будангүй, гэмт хэрэг гаарсан байх үед цаазын ял байж л байсан шүү дээ, дээрдсэн юм байсан юм уу. Харин ч тэрнээс өдий хүртэл хөгжиж, соёлжиж түүнийг даган гэмт хэргийн тоо буурсаар ирсэн шиг нийгмийн ухамсарт чиглэсэн ямар нэгэн зөв шийдвэр гаргаасай.

**Б.Баясгалан (31 нас), "Тагтаа паблишинг"-ийн үүсгэн байгуулагч:**

Аймшигт алуурчид, жигшүүрт этгээдүүдийг өмөөрч хаацайлсандаа цаазлалгүй хориод байдаг юм биш л дээ. Шүүн таслах процедур өөрөө төгс биш учраас, хилсээр хүнийг цаазалчих явдал өдий төдий гардаг учраас, чухам хүний амийг хилсээр тасалчихвал эргүүлж амьдруулах ямар ч аргагүй учраас л цаазыг цааш нь тавьж, бүх насаар нь хорих, чанга, сул дэглэмтэй хорих зэргээр хийсэн хэрэгт нь тохирсон ял өгдөг. Цаазын ялаас татгалзах явдлын цаад санаа нь аймшигт этгээдүүдийн амийг аврахад бус гэмгүй хүмүүсийн амийг хилсдүүлчихгүйд л байдгийг энэ хүмүүс ойлгоосой.

Түүнээс биш жигшүүрт хэрэг үйлдээд, тэр нь хүн амины, хүчингийн, хүн ёсноос даанч гажууд хэрэг байгаад шоронд орж байгаа этгээдүүд бол амьдралынхаа цаг минут тутмын тарчлалаар ялаа үүрнэ. Гялс хийгээд үрэгдчих үхэл бол харин ч амархан шийтгэл.

**Б.Есүй (23 нас), Хуур Мюзик Групп ХХК Менежер:**

Би хүний эрхийн төлөө ажиллана гэж багаасаа боддог байсан. Намайг эмзэг бүлгийн хүүхдүүдийн зусланд сайн дураараа 10 жил багшлах хугацаанд 5, 10тай эгч дүү хоёрыг төрсөн аав өвөө нь хүчиндсэн хэрэг, мөн ОБЕГ-ын ажилтан эргүүлд гарч байхдаа цасан шуурганаар овоо даваад хот орж зах дээр ажиллахаар явж байсан 11-тэй охиныг хүчиндсэн гэх мэт аймшигтай хэргүүдийн тухай сонсож байсан. Тэр хүүхдүүдийг би бүгдийг нь харж, уулзаж байсан. Шөнө орондоо ороод тэднийг бүр өрөвдөөд уйлдаг байсан.

Үнэхээр харахаас өр өвдөж нүд халтирам хүүхдийн гэнэн хөөрхөн ааш, нүдний гал цог юу байдаг юм бүгд байхгүй аль хэдийн хамгийн аймар бүхнийг үзээд туулсан царай байр байдлыг нь хараад ёстой болдог бол хэрэгтнүүдийг нь өөрийн гараар алчихмаар санагддаг байсан. Багаасаа тиймэрхүү нөхцөл байдал хэргүүдийн хохирогчдыг олон удаа харсан болохоор би хүүхдийн эрхийн төлөө ажиллана гэж бодож бас цаазын ялыг дэмжиж хэт их сэтгэлийн хөөрөл уур хилэндээ цаазлах ёстой муусайн юмнуудыг л гэж боддог. Гэхдээ өнөө өглөө Энхжаргал эгчийн постноос нээрээ цаазлуулахаас айж эмээх хирээр гэмт хэргийн нуулт ихэснэ, хээл хахуулиар өөрийгөө өмгөөлөх арга

заль буруу шүүлт ихэсэх юм биш үү гэж бодож эхэллээ л дээ. Цаазын ял сэргээхийн үр дагавар бүрийг сайн судлаасай. Гэм хэргийн эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэлтээ сайжруулаасай гэж хүсч байна.

**Д.Дэлгэрсайхан (18 нас), Оюутан:**

Энэ асуудлаар мэдээлэл, мэдэгдэхүүн их дутмаг. Гэхдээ өнгөцхөн харвал цаазын ялыг аль аль талаас нь л харж байна. Илүү их мэдээлэлтэй болж байж л аль нэг талыг барьж, үзэл бодлоо хэлж чадах байх. Зарим тохиолдолд хэрэгтэй, гэхдээ тэрийг буруугаар ашиглавал яах бол гэсэн айдас бага зэрэг байна.

**Х.Номингэрэл (32 нас), Эрх зүйч, судлаач:**

Хохирогч хамгааллын цогц тогтолцоо, хүчирхийллийг өөгшүүлж буй соёлыг өөрчлөх, урьдчилан сэргийлэх тухай мартагдав, цаазын ялын тухай яриа болоод хувирчхав. Цаазын ял ба хүчирхийлэл хоёрын харилцаа нь нөгөө тэмээ гэхээр ямаа гэв гэдэг шиг л зүйл.

**Ц.Анужин (22 нас), Сурвалжлагч:**

Саяхан гарсан 5 настай охиныг хойд эцэг нь хүчиндсэн хэргээс сэдэлжиж цаазын ялыг сэргээх хүсэлтэй хүмүүс олон байгааг олон нийтийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлсэн байдлаас харж болохоор байна. Би хувьдаа цаазын ялыг сэргээхийг дэмжиж байна. Манайх цаазын ялыг халсан 97 дахь орон болж байсан бол удахгүй нийгмийг цочроосон онц хүнд гэмт хэрэг, бага насны хүүхдийн хүчирхийллээр дээгүүр байр суурь эзэлж явах вий дээ... (Бага насны охид хүчирхийлэлд өртсөн маш олон хэрэг мэдэгдээгүй, мэдэгдсэн ч дарагдаж, дарамтад орж олон нийтэд мэдэгдэхгүй өнгөрч л байна). Шулуухан хэлэхэд гэмшиж, эсвэл тарчилж, өөрөө амиа хорлохыг нь хараад суух хэнд хэрэгтэй юм бэ. Адгийн алуурчны гэмшил, зовлон тэр шорондоо, тэр хүнтэйгээ дуусна. Нийгэм цэвэрлэгдэхийг хүсээд байна шүү дээ. Дээрээс нь яах аргагүй хохирогч хамгааллын цогц тогтолцоо, урьдчилан сэргийлэх ажлууд, ёс суртахууны асуудал яригдах байх л даа.

Бас нэг зүйл, санаанд оромгүй аймшигтай гэмт хэргүүд гарч, яасан ийснийг нь бараг дүрслээд (5 настай охины хэрэг дээр ч гэсэн ялгаагүй) олон нийтийн сүлжээгээр цацаж байна. Гэтэл түүнийг чинь биелүүлэх, туршиж үзэх бодол сэдэлтэй, адгийн хүмүүс маш олон байгааг бас бодолцоосой.

**Э.Энхцацрал (24 нас), Сургалтын менежер:**

Цаазын ял оноолоо гээд тэр хүн араатан зан, хүнээс гарамгүй зүйл хийснээ ойлгохын завдалгүй хорвоог орхиж, харин энд хохирсон хүмүүс сэтгэлзүйн гүн шархтай, цаашлаад бүр эмгэгтэй болоод үлдэж байгаа юм. Тэгэхээр насан туршид  хорьж, хамгийн хэцүү хүнд хүчир ажил хийлгэсэн нь дээр юм шиг. Гэхдээ бид хийснийх нь дараа биш хийхээс нь өмнө урьдчилан сэргийлж, ийм байдалтай одоог үдэж, ирээдүйг угтмааргүй байна. Бид дорвитой хөдлөх хэрэгтэй.

**Б.Баттогтох (23 нас), Зураач:**

Миний бодлоор цаазын ял хэтэрхий энэрэнгүй ял юм шиг санагддаг. Үүний оронд тэнд хүнд хийсэн бүх гэм бурууг нь мэдрүүлж ойлгуулж албадан хөдөлмөрлүүлж, хүмүүс айгаад хийдэггүй хортой, хүнд нөхцөлд ажил хөдөлмөрийг хийлгэх хэрэгтэй. Хүнд маш хүндээр сэв суулгачхаад шууд цаазлуулах нь хэрэггүй гэж бодож байна. Гэхдээ Монгол Улс чинь ардчилсан, хүнлэг орон биш гэж үү. Сараасаа сайхан нь их шүү дээ. Саяхан болсон гэмт хэрэг дээр яг яагаад ийм байдалд хүрснийг маш сайн судалж үзэх хэрэгтэй байх. Хойд эцэг, хойд эх гээд л... Маш олон талаас нь харах хэрэгтэй байх.

**З.Батхуяг (25 нас), Сэтгүүлч:**

Асуудлын гол нь ЦААЗААР аваад бүх асуудал шийдэгдчихгүйд, эргээд хэвэндээ орохгүйд л байна. Нийгэм тэр аяараа ЦААЗЫН ЯЛЫГ СЭРГЭЭ гэж шаардаж байна. Үүнийг сэргээгээд хэдэн хүнд гэмт хэрэгтнүүд л Монгол улсын нэрийн өмнөөс үхнэ. Өөр юу ч өөрчлөгдөхгүй. Хүмүүсийн ийм хүслийг дэмжээд тус ялыг сэргээх гэж байгаа бол Ерөнхийлөгч, Монголын төр жинхэнэ буруу юм хийх гэж байна. Нийгмийн туйлширсан хүслийг хангахын тулд сэтгэл хөдлөл уур уцаарыг өөр учгаар тайлж, тайтгаруулах ёстой. Төр нь иргэнээ хийсэн алдааных нь төлөө алдаг байж хэрхэвч болохгүй. Алахын оронд чанд хатуугаар шийтгэдэг байх ёстой. Бүх насаар нь чанга дэглэмтэй хорих ангид

хорих, иргэний харьяатаас бүх насаар нь хасч хүнд хөдөлмөр эрхлүүлэх гэх мэтээр гэмт этгээдийг шийтгэх арга олон бий.

**С.Долгио (30 нас), Хувиараа бизнес эрхлэгч:**

Цаазын ял бол шийдэл биш. Тэр статистик харж байхад гэр бүл, ойр дотнын хүмүүс их хувийг эзэлж байна лээ. Тийм болохоор харин ч далд хэлбэр лүү шилжүүлнэ. Тэр хөнгөлдөг арга бол байж болох ч бас төгс шийдэл биш. Гэмт хэрэг зэрлэгшиж байгаа нь амьдралын төвшин доройтож байгаагийн тод илрэл шүү дээ.

Бага насны хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол он гарснаас хойш 298-д хүрч бүртгэгджээ. Насны хувьд 2-7 настай нялх амьтад байгаа юм. Энэ тоо бол Хүний эрхийн үндэсний комисст бүртгэгдсэн тоо. Харин үүний цаана бүртгэгдээгүй хэчнээн хэрэг гарсныг хэлж мэдэхгүй нь. Мөн анхаарал татах өөр нэг тоо бол 12-17 насны 1613 эх амаржсан гэсэн дүн мэдээ юм.

# ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ЗАМ

ДХИС-ийн ЦС-ийн
ЦЭЗТ-ийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн
дэд хурандаа Б.Баянмөнх
*Дотоод хэргийн их сургууль,*
*Монгол Улс Цахим шуудан:*
*bayanmunkh@uia.gov.mn*

**Товчлол.** Цагдаагийн хэсгийн байцаагч нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд онцгой байр суурь эзэлдэг бөгөөд хүн ам, олон түмэнтэй хамгийн ойр дөт байж, дүүрэг, баг, хороо зэрэг засаг захиргааны нэгж, тодорхой объект хариуцан ажилладаг онцлогтой албан тушаал юм.

Энэхүү өгүүлэгт хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны зохион байгуулалтын шинэ хэлбэр болон судлаачийн хувьд үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зарим арга зам, түүнийг хэрэгжүүлэх боломжийн талаар товч дурдсан болно.

**Түлхүүр үг.**
- Цагдаагийн хэсгийн байцаагч;
- Жишиг норматив;
- Багаар ажиллах зохион байгуулалтын хэлбэр;
- Техник хэрэгсэл, эд зүйл;

**Үндсэн хэсэг.** Анх 1975 онд хэсгийн байцаагч хэмээх албан тушаалыг бий болгосон үеэс өнөөг хүртэл хэсгийн байцаагчид нь хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах ажлыг хэрэгжүүлж, оршин суугчид, иргэдийн амгалан тайван байдлыг хангаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх үүргийн хэрэгжүүлсээр иржээ.

Цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүргийн хэрэгжилт нь газар, хэлтэс, тасгийн бие бүрэлдэхүүний хамтын үйл ажиллагаагаар тодорхойлогддог бол тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцан ажиллаж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах ажлыг өдөр тутам ард иргэдийн дунд зохион байгуулж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ард иргэдтэй холбож өгч байдгаараа хэсгийн байцаагчийн ажлын үр дүн тодорхойлогддог.[54]

***Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлыг бие даан зохион байгуулагч гол хүч юм***.

Хамгийн энгийн жишээ хэлэхэд хэсгийн байцаагч нь хариуцсан хэсгийнхээ нутаг дэвсгэрийн хэмжээ, хил зааг, гудамж талбай, цэцэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газар, гэр байшин, хашааны эзэмшигч, орох, гарах үүд хаалга, албан газар, байгууллага, дэлгүүр, ресторан, банкны салбар, касс, үнэт материалын агуулахын байрлал, тэдгээрийн ажиллах цаг, хамгаалалтын байдал, түүнчлэн төр, захиргаа, олон нийтийн байгууллагын хаяг, харилцаа, холбоо

[54] Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2014. №2. Б.Баянмөнх. Цагдаагийн хэсгийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага.

барих арга, гудамж замын нэвтрэх хэсэг, нийтийн тээврийн зорчих хэсэг, зогссол буудал, тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын нягтрал зэргийг урьдчилан судалж нарийн мэдсэн байвал зохино.[55]

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх дараахи 3 боломж байна гэж судлаачийн хувьд үзлээ. Үүнд:

1. *"Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ыг дагаж мөрдөх.*
2. *Хороонд багаар ажиллах зохион байгуулалтын хэлбэрийг нэвтрүүлэх.*

**Нэг. "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ыг боловсронгуй болгон дагаж мөрдөх.**

Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоонд тулгуурлан хэсгийн байцаагчийн тоог тогтоох асуудал олон жил яригдсаар Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 153 дугаар тогтоолоор "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ийг батлан "4000 хүн ам тутамд нэг хэсгийн байцаагч ажиллуулна"[56] гэж жишиг нормативыг тогтоосон. ЦЕГ-ын даргын 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 700 дугаар тушаалаар 2013 оноос эхлэн хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын нягтаршил ихтэй хороодод гурав, бусад хороодод хоёр, бүгд 392 хэсгийн байцаагч, үүнээс Улаанбаатар хотод 271, аймгуудад 121 хэсгийн байцаагч ажиллуулж эхэлжээ.

Гэвч энэ норматив удаан үргэлжлээгүй бөгөөд ЦЕГ-ын даргын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн "Улаанбаатар хотын цагдаагийн газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтцийн зураглал, орон тоо батлах тухай" Б/284 дүгээр тушаалаар нэг хороонд 1 хэсгийн байцаагч ажиллуулах болсон бөгөөд нийслэлийн 152 хороонд 154, орон нутагт 122, нийт улсын хэмжээнд 276 хэсгийн байцаагчийн орон тоо баталж, 116 хэсгийн байцаагчийн орон тоо хасаж, 138 хороо хариуцсан цагдаагийн орон тоо нэмсэн байдаг. Гэтэл томилсон цагдаа нарыг тухайн дүүргийн нөхцөл байдлаас шалтгаалан хороон дээр нь ажлуулахгүй, албадан саатуулах байр, явган болон машинт эргүүл, жижүүрийн албан хаагч өвчтэй, чөлөөтэй, шилжсэн тохиолдолд уг орон тоог нөхөх байдлаар үүрэг гүйцэтгүүлэх нь их байна.

2019 оны 1-р сарын 1-ны байдлаар нийслэлийн 9 дүүргийн 152 хороонд 387453 өрхийн 1444.7 мянган хүн оршин сууж байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 45.3 хувийг эзэлж байна.[57] Нийслэлийн хүн амын 786825 иргэн буюу 54.5 хувь, 212008 өрх буюу 54.7 хувь нь гэр хороололд, 657844 иргэн буюу 45.5 хувь, 175445 өрх буюу 45.3 хувь нь нийтийн орон сууцанд амьдарч байна.

2019 оны нийслэлийн хороодын хүн амын тоог 2014 онтой харьцуулан авч үзвэл:

---

[55] Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 114 дэх тал

[56] https://www.legalinfo.mn. ЗГ-ын 2011 оны "Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 153 дугаар тогтоол.

[57] http://ubstat.mn. Нийслэлийн статистикийн газрын 2019 оны тоо мэдээ.

*Хүснэгт №1*

| № | Хүн амын тоо | Хорооны тоо | | Өсөлт бууралт |
|---|---|---|---|---|
| | | 2014 | 2019 | |
| 1. | 641-2103 хүн амтай | 3 | 4 | +33.3% |
| 2. | 2104-3353 хүн амтай | 2 | 3 | +50% |
| 3. | 3354-4328 хүн амтай | 4 | 10 | +1.5 дах |
| 4. | 4329-5029 хүн амтай | 9 | 9 | 0% |
| 5. | 5030-6025 хүн амтай | 15 | 22 | +46.6% |
| 6. | 6026-7033 хүн амтай | 18 | 22 | +22.2% |
| 7. | 7034-8064 хүн амтай | 20 | 16 | -0.2% |
| 8. | 8065-9010 хүн амтай | 20 | 19 | -0.5% |
| 9. | 9011-10009 хүн амтай | 11 | 14 | +27.2% |
| 10. | 10010-11024 хүн амтай | 8 | 13 | +62.5% |
| 11. | 11025-12209 хүн амтай | 13 | 10 | -23% |
| 12. | 12210-13381 хүн амтай | 8 | 9 | +0.125% |
| 13. | 13382-14042 хүн амтай | 4 | 6 | +50% |
| 14. | 14043-15646 хүн амтай | 4 | 4 | 0% |
| 15. | 15647-16668 хүн амтай | 6 | 2 | -25% |
| 16. | 16669-17125 хүн амтай | 1 | 1 | 0% |
| 17. | 17126-18833 хүн амтай | 4 | 2 | -50% |
| 18. | 18834-20179 хүн амтай | 1 | 1 | 0% |
| 19. | 20180-21299 хүн амтай | - | 1 | +100% |
| 20. | 21300-22449 хүн амтай | - | 2 | +200% |
| 21. | 22450-аас дээш хүн амтай | - | 1 | +100% |

Дээрхи хүснэгтээс үзвэл хороодын хүн амын тоо жил ирэх тусам өсч, хэсгийн байцаагчийн ажлын ачаалал нэмэгдэх нэг хүчин зүйл болж байна. 2019 оны 1-р сарын 1-ны байдлаар нийслэлийн хэмжээнд нэг хэсгийн байцаагч хэдэн өрх, хүн ам хариуцан ажиллаж байсныг дүүрэг бүрээр гаргаж, дунджаар авч үзвэл:

*Хүснэгт №2*

| № | Дүүрэг | Хороо | Өрхийн тоо | Хүн амын Тоо | 1 хэсгийн байцаагч /*дунджаар*/ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өрх | Хүн амын тоо |
| 1. | Хан-Уул дүүрэг | 16 | 48940 | 178919 | 3058 | 11182 |
| 2. | Багануур дүүрэг | 5 | 8569 | 29512 | 1713 | 5902 |
| 3. | Баянзүрх дүүрэг | 28 | 95714 | 343619 | 3418 | 12272 |
| 4. | Налайх дүүрэг | 7 | 10606 | 37608 | 1515 | 5372 |
| 5. | Сүхбаатар дүүрэг | 20 | 38563 | 145335 | 1928 | 7267 |
| 6. | Баянгол дүүрэг | 23 | 59536 | 226869 | 2588 | 9864 |
| 7. | Багахангай дүүрэг | 2 | 1272 | 4399 | 636 | 2199 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8. | Чингэлтэй дүүрэг | 19 | 40017 | 157258 | 2106 | 8276 |
| 9. | Сонгинохайрхан дүүрэг | 32 | 84236 | 321150 | 2632 | 10035 |
| Нийт | | 152 | 387453 | 1444669 | 2549 | 9504 |

Дээрхи тоо мэдээнээс үзвэл нийслэлийн нэг хэсгийн байцаагч дунджаар 2549 өрхийн 9504 хүн амтай хороо хариуцан ажиллаж байна. Хамгийн цөөн өрх, хүн ам хариуцан ажиллаж байгаа нь Багахангай дүүргийн нэг хэсгийн байцаагч дунджаар 636 өрхийн 2199 иргэн, харин хамгийн олон нь Баянзүрх дүүргийн нэг хэсгийн байцаагч дунджаар 3418 өрхийн 12272 иргэнтэй хороо хариуцаж байна. БЗД-ийн 5-р хорооны хэсгийн байцаагч 6458 өрхийн 23536 хүн амтай хороо хариуцаж байна.

Нийслэлийн цагдаагийн газрын төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн нэг хэсгийн байцаагчийн хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоог дунджаар нь авч үзвэл:

*Хүснэгт №3*

| № | Хэлтэс | Нэг хэсгийн байцаагч /дунджаар/ |
|---|---|---|
| 1 | Баянгол дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс | 7335 |
| 2 | Баянгол дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс | 9707 |
| 3 | Баянзүрх дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс | 11138 |
| 4 | Баянзүрх дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс | 9833 |
| 5 | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс | 8736 |
| 6 | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс | 7756 |
| 7 | Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс | 7760 |
| 8 | Чингэлтэй дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс | 8409 |
| 9 | Хан-Уул дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс | 10206 |
| 10 | Хан-Уул дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс | 6950 |
| 11 | Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс | 6168 |
| 12 | Сүхбаатар дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс | 6964 |
| Дунджаар | | 8413 |

2019 оны нийслэлийн хороодын хүн амын тоог Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны жишиг норматив”-оор авч үзвэл өнөөдөр хоёр байцаагч ажиллах 54 хороо, гурван байцаагч ажиллах 18 хороо, дөрвөн байцаагч ажиллах дөрвөн хороо, нийт 129 байцаагчийн орон тоо дутагдалтай гэсэн судалгааны дүн гарч байна.

*Хүснэгт №4*

| № | Дүүрэг | Хорооны тоо | Шинээр нэмэгдэх хэсгийн байцаагчийн тоо | | | | Шаардлагатай орон тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 | |
| 1. | Хан - Уул | 13 | 9 | 4 | - | - | 17 |
| 2. | Багануур | 1 | 1 | - | - | - | 1 |
| 3. | Баянзүрх | 23 | 7 | 8 | 4 | 3 | 47 |
| 4. | Сүхбаатар | 8 | 7 | 1 | - | - | 9 |
| 5. | Баянгол | 13 | 6 | 2 | 3 | 1 | 23 |
| 6. | Чингэлтэй | 8 | 5 | 3 | - | - | 11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Сонгинохайрхан | 19 | 19 | | - | - | 19 |
| Нийт | | 85 | 54 | 18 | 7 | 4 | 129 |

Нийслэлийн нэг хороог нэг хэсгийн байцаагч хариуцан ажиллаж байгаа зохион байгуулалтын хэлбэр амьдралд нийцэмжгүй байгааг өмнө хэлсэн. Гэхдээ “4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч ажиллуулна” гэсэн норматив бас сайн тохирохгүй байна. Хүн амын нягтаршил, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, аж ахуйн нэгж, байгууллагын онцлог зэргийг харгалзан тодорхой нутаг дэвсгэр хариуцан ажиллах хувилбар боломжтой юм. Дүүргийн цагдаагийн газрын саналыг үндэслэн хэсгийн байцаагчид хариуцуулах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтоох эрхийг Нийслэлийн цагдаагийн удирдах газарт өгөх нь зөв гэж үзэж байна.

Тэгвэл хэсгийн байцаагчдын ажлын ачаалал нилээд жигдэрэх боломжтой болно. Хэсгийн байцаагчийг унаа, интернет, дотоод холбоо зэргээр ээлж дараатай хангах, орон сууцны асуудлыг ч янз бүрийн аргаар шийдвэрлэх боломж дээшлэх юм.

Цагдаагийн хэсгийн байцаагч нар хороо бус харин тодорхой нутаг дэвсгэр хариуцахаар зохион байгуулах бидний санал болгож байгаа хувилбарыг дэс дараатай аажмаар хийж болно гэж бодож байна.

**Хоёр. Багаар ажиллах зохион байгуулалтын хэлбэрийг турших.**

Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд хороо хариуцсан мөрдөгч, эрүүгийн мөрдөгч ажилладаг боловч бүгд хэлтсийнхээ төв байранд ажилладаг нь хороо хариуцсан алба хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байх нэг хүчин зүйл болжээ. Тиймээс хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, зөрчлийн хэрэг бүртгэгч нарыг цагдаагийн хэсгийн байранд хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нартай хамтад нь байрлуулах замаар хамтран нэг баг болж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлмээр байна.

Ингэвэл хэсгийн байцаагч нар хариуцсан хорооныхоо эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг мэдэрч ажиллах нь нэмэгдэж, улмаар мэдээлэлд суурилсан, олон нийтэд түшиглэсэн арга барилаар ажиллах боломж нэмэгдэх юм. Нэг хороонд хамтарсан багаар ажиллах энэхүү зохион байгуулалтын хэлбэрийг эхлээд цөөн хороонд турших болох юм.

Цагдаагийн хэсэгт хамтран ажиллах багт дараах алба хаагчид орж байна. Үүнд:

- хэсгийн ахлах байцаагч;
- хэсгийн байцаагч;
- хэсгийн туслах байцаагч;
- эрүүгийн мөрдөгч;
- мөрдөгч;
- зөрчлийн хэрэг бүртгэгч;
- олон нийтийн цагдаа зэргээс бүрдэх юм.

Одоо ажиллаж байгаа хэсгийн цагдаагийн оронд хэсгийн байцаагчийн туслах гэсэн албан тушаалыг шинээр оруулж байгаа бөгөөд бусад алба хаагчид нь өнөөдөр дүүрэгтээ сууж, өөр өөрсдийн үүргээ гүйцэтгэж байна. Хэсгийн ахлах байцаагч нь хэсгийн нийт алба хаагч нарыг удирдан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажил, арга хэмжээг зохион байгуулах, нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажил, арга хэмжээг зохицуулах үүрэгтэй ажиллана. Цагдааг туслах байцаагч болгосноор хэсгийн байцаагчийн туршлагатай нөөц бэлтгэхэд ач холбогдолтой.

Цагдаагийн хэсгийн шинэ байрны бүдүүвч зургийг олон талаас нь бодож төсөл маягаар танилцуулж байна. Энэхүү хэсгийн байр нь ойролцоогоор 119.92 м$^2$ талбай буюу нэг алба хаагч дунджаар 19.98 м$^2$ талбай ногдохоор бодсон.

**Цагдаагийн хэсгийн байрны бүдүүвч зураг** /Төсөл/

**1 давхарт:**

- хэсгийн ахлах байцаагч – 32.21м$^2$
- хэсгийн байцаагч – 29.96 м$^2$
- эрүүгийн мөрдөгч – 30.15 м$^2$
- мөрдөгч – 15.46 м$^2$
- зөрчлийн хэрэг бүртгэгч – 15.4 м$^2$
- хэсгийн туслах байцаагч – 14.04 м$^2$
- олон нийтийн цагдаагийн ажилтан - 15.07 м$^2$
- хурлын заал – 32.21 м$^2$
- амралтын өрөө 14.18 м$^2$
- түр саатуулах байр – 15.27 м$^2$
- 00-ийн өрөө – 14.91 м$^2$
- Угтах хүлээлгийн өрөө буюу вестибюль 69.59 м$^2$

*Бүдүүвч №1*




**Зоорины давхарт:**

- хураасан эд зүйл түр хадгалах өрөө - 62.17 м$^2$
- бичиг баримт хадгалах архивын өрөө - 47.55 м$^2$
- 2 авто машины граш – 133.93 м$^2$

Цагдаагийн хэсгийн шинэ байрны бүдүүвч зураглалын зарим онцлог, давуу талуудыг авч үзвэл:

- иргэдийг хүлээн авч уулзах, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах, хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зориулалт бүхий хурлын бичил танхимтай;
- алба хаагч нартай уулзахаар хүлээж буй иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор төв хэсгийг тохижуулсан байх;
- эрүүгийн мөрдөгчийн ажлын онцлогоос хамаарч өрөөндөө дотор хэсгээс орж болохоос гадна гаднаас орж гарах хаалгатай байх;
- алба хаагчид цайны цагаараа амрах, хоол унд хийх боломжтой амралтын өрөөтэй;
- түр саатуулах байр гаргаж, хэсгийн туслах байцаагчийн хажуу өрөөнд хяналт тавих боломжтой шилэн цонх бүхий өрөөтэй;
- зоорьны давхарт хэсгийн үйл ажиллагаанд ашиглах автомашин байрлах гарааш, хураан авсан эд зүйл хадгалах өрөө, архивын өрөөтэй байвал зүгээр гэж тооцсон.

Хэсгийн байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор цонх нь хамгаалалттай, байр нь дохиоллын хамгаалалттай, галын аюулгүй байдлын дохиоллын систем болон унтраах хэрэгсэлийг өрөө бүрт байршуулж, камераар тоноглогдсон байна.

Хэсгийн байр нь цахилгаан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, сантехникийн шугам сүлжээнд холбогдсон байхаар тооцсон болно.

Мэдээллийн самбар нь цагдаагийн хэсэг үйл ажиллагаагаа сурталчилах, иргэдтэй холбоо тогтоох, нөгөө талаараа ажлын ачааллыг бага боловч бууруулах, шаардлагатай мэдээллийг иргэдэд хүргэхэд нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбарт дараахи агуулга бүхий мэдээллүүдийг багтаасан байна. Үүнд:

- цагдаагийн хэсгийн байранд ажиллаж байгаа алба хаагчдын нэр, цол, албан тушаал, утасны дугаар;
- хэсгийн байцаагчийн ажлын цагийн хуваарь;
- иргэдийг хүлээн авч уулзах өдөр ба цаг;
- иргэдээс өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах журмын мэдээлэл;
- нутаг дэвсгэрийн зураг /нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тэмдэглэсэн карт схем ба зураглал/;
- эрэн сурвалжлагдаж буй этгээд болон эд зүйлийн талаарх мэдээлэл.

Мэдээллийн самбар доторхи мэдээллийн агуулгыг долоо хоног бүр шинэчилж байх шаардлагатай бөгөөд самбарын ашиглалтанд хэсгийн ахлах байцаагч хяналт тавьж ажиллана.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”[58]-т шаардлагатай эд зүйлийн жагсаалт тусгаагүй байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн “Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, байцаагч нарын ажлын нөхцөлийн тухай” 43 дугаар тогтоолд “Цагдаагийн байгууллагын сум, хороо хариуцсан хэсгийн төлөөлөгч, байцаагч нарыг албан ажлаа явуулахад нь шаардагдах ажлын байр, тээврийн хэрэгслээр хангах, цахилгаан, дулааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, хойшлуулшгүй ажилд хэрэглэх шатахууны лимит тогтоож олгох, хариуцсан дэвсгэрт нь байр, сууцаар хангах арга хэмжээ авах”[59]; Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн “Цагдаагийн байгууллагын

[58] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. Уб. 2008. 425-430 дахь тал
[59] https://www.legalinfo.mn/law/details/5518?lawid=5518

талаар авах зарим арга хэмжээний тухай” 94 дүгээр тогтоолд “Сум, хороонд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийн эхнэр (нөхөр)-ийг ажлын шаардлагаар цагдаагийн туслах ажилтнаар хуульд нийцүүлэн томилон ажиллуулбал уг алба хаагчийн сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр сар тутам цалинжуулж байх, цагдаагийн алба хаагчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, уналга, холбоо, техник хэрэгслээр хангах арга хэмжээг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байх”[60]-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгажээ. Гэвч Засгийн газрын тогтоолын дээрхи заалт хэрэгжиж чадаагүй байна.

Нийслэл, аймагт Засаг даргын дэргэдэх цагдаагийн газар, хэлтэс гэж байсныг 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар төвлөрсөн удирдлагатай болгон нийслэл, аймаг дахь цагдаагийн газар, хэлтэс болгосноор цагдаагийн газар, хэлтсийн төсөв аймаг, нийслэлийн төсвөөс ЦЕГ-ын төсөвт шилжиж Засгийн газрын дээрхи заалтууд биелэхэд нэг саад болсон. Өөрөөр хэлбэл төсөвтэй харьцаггүй байгууллагад аймаг төсвөөсөө зарцуулах боломж хязгаарлагдмал байна.

Хэсгийн байцаагчид байвал зохих байр, тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тавилга, эд зүйлийн жагсаалт болон ашиглалтын жишиг нормативыг Засгийн газраар батлуулбал шаардагдах төсөв хөрөнгийг төсөвт тусгах боломж нэмэгдэнэ. Хэсгийн байранд ажиллах нийт алба хаагчдад байвал зохих техник хэрэгсэл нь нэг улсад үйлдвэрлэсэн, ижил үзүүлэлт бүхий хүчин чадалтай байх, эд зүйл нэг ижил загварын байх, мөн ашиглалтын хугацааг болон стандарт тогтоож өгөх замаар шаардлага хангахгүй техник хэрэгсэл, эд зүйлсээр хангахыг таслан зогсоох боломжтой. Бид хэсгийн тээврийн хэрэгсэл, компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж болон тавилга, эд хогшлийн жагсаалтыг шинээр гаргаж, алба хаагч бүрийг хангах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

**Дүгнэлт.** Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд зохион байгуулалтын зарим шинэ хэлбэрийг нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай байна.

Нийслэлийн хороо хариуцсан цагдаагийн хэсгийн байцаагч нарын хариуцаж буй нутаг дэвсгэр, хүн ам, ажлын ачаалал хэт их ялгаатай байна. Эргүүл, шалгалт, урьдчилан сэргийлэх ажил зэрэг олон ажил хорооны хэсгийн байцаагчийн ажлын ачаалал, цаг заваас шалтгаалан олон хороонд жинхэнэ ёсоор хийгдэж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудал болсон байна.

Нийслэл хотод нэг хороог нэг байцаагч хариуцаж байгааг өөрчлөх зайлшгүй шаардлага байна. Мөн цагдаагийн алба хаагчид багаар ажиллах хувилбарыг нэвтрүүлбэл ажлын үр дүн дээшилж, гэмт хэрэг, зөрчил буурна гэж үзэж байна.

Түүнчлэн цагдаагийн хэсгийн байрны шинэ загварыг бий болгох замаар алба хаагчдын багаар ажиллах боломжийг бүрдүүлэх, нөгөө талаараа ажлын нөхцөл сайжрах, иргэдээс цагдаагийн байгууллага, алба хаагчдад хандах нөхцөл боломж ч дээшилэх болно гэж үзэж байна. Мөн байвал зохих техник хэрэгсэл, эд зүйлийн жагсаалтыг гаргаж, жишиг нормативыг тогтоох шаардлагатай байна.

[60] https://www.legalinfo.mn/law/details/5529?lawid=5529

**Санал.**

1. Нийслэл хотод нэг хороог нэг байцаагч хариуцаж байгааг өөрчилж, хороо хариуцсан цагдаагийн бусад төрөл мэргэжлийн алба хаагчдыг багаар ажиллах боломж нөхцлийг бүрдүүлж, нэг хороонд туршиж үзэх;
2. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлийн жагсаалтыг гаргаж, жишиг нормативыг тогтоох өгөх;
3. “Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбар”-ыг шинээр нэвтрүүлж, хорооны иргэдэд нэн шаардлагатай мэдээллийг самбараар дамжуулан хүргэх боломжийг бий болгох;
4. Цагдаагийн хэсгийн байцаагч бүр нэрийн хуудастай болж, өөрийгөө хариуцсан хорооны иргэдэд өөрийгөө таниулах, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлж өгөх;

# ОРГАНИЗАЦИЯ КОНТРОЛЯ ЗА ПОВЕДЕНИЕМ УСЛОВНО ОСУЖДЕННЫХ ОРГАНАМИ ПОЛИЦИИ МОНГОЛИИ

А.Баасанцэрэн
*Полковник полиции*

**Аннотация:** в статье рассматриваются вопросы осуществления контроля за поведением условно-осужденных в Монголии. Автор раскрывает цель контроля, а также функции контролирующих органов, нормы контроля или правила процедуры, обеспечивающие деятельность органов полиции при осуществлении контроля за поведением условно осужденных.

**Ключевые слова:** административного контроля, контролю за поведением условно осужденных, функции контроль, осуществлении контроля.

В Монголии за последние пять лет было осужденно 40069 человек, из них 15483 человека, или 38,6% всех осужденных, применение наказание условно, из них 148 (0,95%) совершили преступление повторно[61]. В 2014 г. из общей численности осужденных (8178 человек) были осуждены условно 3396 (41,5%), из них 88 (2,6%) повторно совершили преступление во время испытательного срока. Статистические показатели свидетельствуют о ежегодном увеличении числа условно осужденных, повторно совершивших преступление.

Эффективность исполнения условного осуждения напрямую зависит от своевременности и целенаправленности деятельности соответствующих государственных органов по контролю за поведением условно осужденных. Осуществление процесса исправления осужденного возможно только на основе реального взаимодействия всех субъектов, участвующих в исправительно-воспитательном процессе.

Монгольский ученый Ж. Долгорсурэн указывает, что основная цель контроля должна быть направлена на обеспечение всеобщего соблюдения общественного порядка, принятие юридической ответственности для лиц, виновных в нарушении законодательства[62].

Сегодня одной из причин повторного совершения новых преступлений условно осужденным во время испытательного срока становится, скорее, не слабая помощь и поддержка со стороны рабочего коллектива и общества, а недостаточность внимания органов полиции и правоохранительных органов к проведению профилактики совершения преступлений. условно осуждеными это связано с большой загруженостью сотрудников полиции. Например, на одного участкового инспектора отдела управления полиции г. Улан-Батора за один месяц в среднем приходится участковие в расследований 4-6 уголовных дел легкой и средней тяжести а более 10 материалов административных расследование. Это и другие обстоятельсва свидетельствуют о нехватке сил, средств и времени для организации профилактических работ с условно осужденными.

Помимо основных работ по контролю соблюдения гражданами общественного порядка, органы полиции выполняют различные функции, установленные законодательством страны, в том числе осуществление административного контроля за поведением и исправлением условно осужденных. Сущность контроль заключается в применении полномочий органов полиции согласно законодательству и отличается от различных видов административного надзоров. Например, полномочия органов полиции ограничиваются вызовом условно осужденных один раз в месяц и регистрацией их явки, участковый инспектор имеет только право регистрации и из-за большой нагрузки фактически не успевает организовать каждый месяц встречи с условно осужденными.

---

[61]По статистическим данным Центра статистики и информации Верховного Суда Монголии в 2010-2014 гг.
[62]*Долгорсурэн Ж.* Монгол улсын Цагдаагийн эрх зуй: учебное пособие. Улан-Батор, 2004. С. 251 (на монгольском языке).

При этом контроль за указанными лицами, ограничивающий в определенной степени права и свободы человека, занимает особое местов административно-профилактических принудительных мерах.

Правовые основы участия работников органов полиции в осуществлении контроля за поведением условно осужденных определены Законом Монголии от 05 июля 2013 г «О полицейской службе»[63], Закон от 16 января 2014 г. «Об исполнении судебных решений Монголии»[64], Законом Монголии от 05 декабря 1997 г «О профилактике преступлений.»[65].

Порядок осуществления контроля за поведением условно осужденных в течение испытательного срока определен Правилами отбывания уголовных наказаний осужденными, которые утверждены приказом начальника Генерального управления полиции Монголии от 19 июня 2012 г. № 352 (Код № 619) «Об осуществлении контроля за условно осужденными и несовершеннолетними, совершившими преступление»[66].

Специфика этой деятельности заключается в том, что контроль осуществляется: 1) за лицами, освобожденными из мест отбывания наказания, 2) лицами, условно осужденными, 3) лицами, приговоренными к отсрочке срока наказания.

На наш взгляд, подобная ситуация не может способствовать повышению эффективности контроля за поведением условно осужденных со стороны органов исполнения судебных решение и органов полиции. Ведь именно на начальном этапе в отношении осужденного необходимо интенсивное воспитательно-профилактическое воздействие, обеспечивающее действенность контроля в последующем.

Деятельность органов полиции по контролю за поведением условно осужденных организуется на основе взаимодействия с администрацией предприятий, учреждений и организаций, в которых работают осужденные, органами местного самоуправления, прокуратуры, судами и общественными объединениями, осуществляемого путем проведения совместных мероприятий, обмена информацией и т.д.

В отношении условно осужденных, на которых судом возложены обязанности, связанные с их работой, учебой или лечением от алкоголизма, наркомании, токсикомании или венерического заболевания, органом полиции направляется сообщение администрации организаций, учебных заведений и соответствующих лечебных учреждений.

После постановки на учет условно осужденный вызывается в орган полиции для проведения беседы, в ходе которой разъясняются его обязанности, последствия их невыполнения и ответственность за нарушение общественного порядка или совершение нового преступления, уточняются и проверяются анкетные данные, выясняются сведения о близких родственниках и лицах, которые могут оказывать влияние на осужденного, а также другие вопросы, имеющие значение для осуществления контроля за его поведением.

Исходя из этого, следует сделать вывод о том, что органам полиции в дальнейшем невозможно осуществить контроль только своими силами, так как потенциал и ресурсы органов полиции остаются недостаточными.

Одним из недостатков деятельности органов полиции по контролю за поведением условно осужденных является отсутствие в контрольных делах планов работы. Зачастую совместная

---

[63]*Закон* Монголии от 05 июля 2013 г. «О полицейской службе» / официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.

[64] Закон от 16 января 2014 г. «Об исполнении судебных решений Монголии» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.

[65]*Закон* Монголии от 05 декабря 1997 г. «О профилактике преступлений» / официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.

[66] Сборник действующие нормативно-правовая акты деятельности органов полиции Монголии 2013 г С.444.

деятельность участкового уполномоченного заключается в организации и проведении первоначальной проверки по месту жительства сразу же после получения приговора из суда.

Несмотря на установление правовых процедур осуществления контроля в статье 15 «Об административном контроле условно осужденных и некоторых категорий осужденных» закона Монголии «О профилактике преступлений», в статье 10 «О некоторых судебных решениях, выполненяемых органами полиции» закона Монголии «Об исполнении судебных решений», контроль органами полиции осуществляется не в полной мере. Она не может самостоятельно организовать общие и индивидуальные меры профилактической работы, организует только меры, запланированные руководством, и выполняет указания, поступившие сверху, что ограничивается мероприятиями по осуществлению контроля, охватывающими общество в целом 3-4 раза в году.

Для совершенствования осуществления административного контроля органами полиции необходимо принять следующие меры:

1. Повысить уровень квалификации участковых инспекторов по осуществлению профилактических работ по отношению к условно осужденным, находящимся под административном контролем.

2. Снизить рабочую нагрузку участковых инспекторов путем уменьшения численности населения на одного участкового за счет увеличения их контингента в зависимости от специфики районов, городов и сельской местности.

3. Организовать разделение труда участковых инспекторов, чтобы некоторые из них только проводили мероприятия профилактической работы с условно осужденными вместо расследования уголовных дел и принятия решений по заявлениям и жалобам граждан.

4. Совершенствовать контроль за поведением условно осужденных, направлять основную деятельность сотрудников правоохранительных органов на индивидуальные консультации и профилактическую работу.

5. Применять современные информационные технологии в концепции осуществления контроля за поведением условно осужденных с привлечением дополнительных сил и средств взаимодействующих сторон, с применением электронного мониторинга условно осужденных, что позволит систематизировать факторы, определяющие повышение эффективности деятельности полиции Монголии в сфере противодействия повторным преступлениям условно осужденных.

Для снижения количества повторных преступлений необходимо совершенстовать законодательную регламентацию контроля за поведением условно осужденных, правовые акты, регулирующие отношения с условно осужденными, совершенствовать контроль за поведением условно осужденных, повысить степень социальной защищенности и уровень профессиональной подготовки работников органов полиции, которые контролируют исполнение условного осуждения.

Литература:

1. Уголовный кодекс Монголии от 03 декабря 2015 г. /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
2. Уголовный кодекс Монголии от 03 января 2002 г. /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
3. Закон Монголии от 05 июля 2013 г. «О полицейской службе» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
4. Закон от 16 января 2014 г. «Об исполнении судебных решений Монголии» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
5. Закон Монголии от 05 декабря 1997 г. «О профилактике преступлений» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
6. Постановление Президиума Верховного Народного Хурала МНР от 18 октября 1968 г. № 216.

7. Указ Совета Министров МНР от 1985 г. № 95.
8. Приказом начальника Генерального управления полиции Монголии от 19 июня 2012 г. № 352 (Код № 619).
9. Уголовно-исполнительное право: учебник и основные нормативные акты / под ред. О. В. Филимонова. М., 2007.
10. Уголовно-исполнительное право: учебник: в 2 т. Т. 2: Особенная часть / под ред. Ю. И. Калинина. Рязань, 2006.
11. Даль В. И. Толковый словарь живого великорусского языка. М., 1999. Т. 2.
12. Долгорсурэн Ж. Монгол улсын Цагдаагийн эрх зүй:учебное пособие.Улан-Батор, 2004 (на монгольском языке).
13. Хурэлбаатар Т. Монгол улсын Цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгүүд: учебное пособие. Улан-Батор, 2011 (на монгольском языке).
14. Большая юридическая энциклопедия. М., 2010. Т. 2.
15. По статистическим данным Центра статистики и информации Верховного Суда Монголии в 2010-2014 гг.

# ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ОБЬЕКТЫН СУДАЛГАА ХИЙЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

**Г.Бямбадорж**
*, Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн хошууч*

**Товч агуулга**. Цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийн обьектын судалгааны түүхэн эх сурвалжийг арван тавны цагдаа үүссэн он цагаас хойш цагдан сэргийлэх байгууллагын дүрэм хэмжээ, гадаад улсууд лугаа зах нийлсэн олон аймаг хошуудаас хил хязгаараар суулгасан цагдаа нарын түр дагаж явах дүрэм, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм хэмжээ зэрэг эрх зүйн актад дүн шинжилгээ хийж обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн үндэс, эх сурвалж, обьектын судалгааны төрөл, тэдгээрийг хийж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалахад хэрхэн ашиглаж байсан талаар авч үзлээ.

**Түлхүүр үгс:** Цагдан сэргийлэх газар, дүрэм хэмжээ, тогтоол, зарлиг, нутаг дэвсгэр

**Оршил.** Цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийн обьектын судалгааг хийж ирсэн явдал нь Монгол Улсын төрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны түүхэнд өөрийн гэсэн өвөрмөц онцлог шинжтэй байж түүний үр нөлөөг үйл ажиллагааны гол чиглэл болгож иржээ.

Цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгаа хийх нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бас нэгэн гол чиглэл гэж практикт үздэг ч түүний обьектын судалгааны талаарх эрдэмтэн судлаач нарын ном бүтээл хомс байгаа нь түүхэн уламжлалыг судлахад хүндрэлтэй байгааг дурьдах нь зүйтэй болов уу.

Мөн Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа явуулж ирсэн уламжлалыг судлан авч үзэхдээ 1865 оноос өмнөх үеийг судлалгүй нээлттэй орхиж 1865-1993 хүртэл шинэ үеийн цагдаагийн байгууллагын эхлэл буюу нэгэн үе болгон судлав.

Цагдаагийн байгууллагын обьектын судалгаа явуулж ирсэн түүхэн баримт материалыг он дараалал, түүхэн цаг хугацааны онцлог, хөгжил, залгамж чанар, уялдаа холбоо, шинэчлэл зэрэгт тулгуурлан судлаа.

Цагдаагийн байгууллагын үе үеийн цагдаагийн ажилтнууд хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд ашиглаж ирсэн түүхэн уламжлалтай. Цагдаагийн байгууллага түүхэн хөгжлийнхөө явцад обьектын судалгаанд тулгуурлан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсныг дараах дүрэм хэмжээ, түүхэн эх сурвалж бичгүүдэд дурьджээ.Үүнд:

XVIII зууны үеэс эхлэн их хүрээнд оршин суугчид олширч худалдааны зах зээл хөгжиж иржээ. Үүнийг дагаж хулгай, худал зэрэг ямар нэгэн хэрэг будлиан гарах болж энд хэрмэл ардыг захирах ёстой цагдаа буюу цэрэг суулгаж ажиллаж байсан байна. Иймд энэ байдалтай уялдуулан Богд Жавзандамба хутагт шавь нарыг захирах Эрдэнэшанзудов, аймгуудын жасаад хүрээний нутаг дэвсгэрийн хошуу тамгын газраас хүрээ харчуулын дунд хэв журам сахиулах “арван жалгын ажиглагч” гэгчийг зохион байгуулж, эдгээр ажигч нар тухайн нутаг дэвсгэрт ажиглалт хийх аргаар ажилладаг байжээ.

Мөн 1865 онд Богдын зарлигаар Түшээт хан, Сэцэн хан аймгуудын чуулган дарга, Богдын Эрдэнэ шанзудовын газраас тусгай тшмэлүүд томилж их хүрээнд хэв журам сахиулах арга хэмжээг авсан ба Их хүрээний нутаг дэвсгэрийг төвөөс нь тал тийш 3 хувааж өөр өөрсдөө тэмдэг тавин тухайн газар нутаг дэвсгэр дээрээ хяналт тавьж, биечилсэн судалгаа хийж ажилдаг байв. Энэ нь тухайн үедээ

нийслэл хүрээнд болж байгаа аливаа хэрэг явдлыг судлах, хяналт тавих, тухайн нутаг дэвсгэрт обьект, субьектын судалгаа явуулж байсны илэрэл юм.

**Үндсэн хэсэг.** Монгол Улсад төрийн цагдаа анх 1911 онд сууриа тавьж Манжийн үед мөрдөгдөж байсан хууль цаазууд өөрчлөгдөж Богдын зарлигаар Арван тавны цагдааг байгуулж эдгээр нь гадаад дотоодын хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэж, хууль зүйд хяналт тавих, оргож зугтагсадыг мөрдөж барих, ариун цэвэр сахиулах, тухайн нутаг дэвсгэрт барьж буй барилга байгууламжинд хяналт тавих, дэн буудлыг хянах, хаягдаж гээгдсэн нялх хүүхдийг асарч тэтгэх, харуул хийх үүргийг гүйцэтгэж байсан нь дэг журмыг сахиулахад чухал үүрэг гүйцэтгэж байжээ.Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх түүхэн эх сурвалж, эрх зүйн зохицуулалтыг дараах хууль тогтоомж, дүрэм хэмжээнд заасан байна. Үүнд:

**А.Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээ**

Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээг 1916 оны 12-р сарын 30-ны өдөр батлаж мөрдүүлсэн бөгөөд уг дүрэм хэмжээний зорилго нь Нийслэл хотыг сайжруулан ариун цэвэр болгож, аливаа олон ард, иргэнийг улсын цааз дүрмийг дагуулах, цагдаж манахыг чухал болгож дүрэм хэмжээг зүйлчлэн тогтоож, хяналт тавих, зөрчсөн тохиолдолд шийтгэл ногдуулах явдал байв.

Уг дүрэм хэмжээнд ... Бидний улс тулгар төрийг нээж нийслэлийн газрын муу самууныг цагдан манаж сэргийлэх морьт явган цагдаа цэргүүдийг томилон гарсан дээр бас тусгайлан харьяат таван яамнаас өдөр бүр жишээлэн осолдон омгодоход хүрсэн нь угаас тусгайлан албан газар байгуулж, дүрэм хэмжээ тогтоосонгүйгээс болсон ...[67] хэмээн тусгаснаас үзвэл нийслэл хүрээнд тухайн үед нийгэмд дэг журам тогтоосон дүрэм хэмжээ батлагдаагүй, хүрээнд дэг журам сахиулах чиг үүрэг бүхий төрөл мэргэжлийн алба байгууллагдаагүйгээс нийслэл хүрээнд хэрэг, зөрчилтэй тэмцэхэд хүндрэл бэрхшээлтэй байжээ.

Дүрэм хэмжээний 1-р зүйлд Нийслэл хүрээний газар суугаа аливаа олон ард иргэн нь улсын засгийн цааз, дүрэм хэмжээг дагуулан нийслэл хотыг сайжруулан ариун цэвэр болгох ба гэмт аюулгүй амар жимэр суулгахын учир, Нийслэл хүрээнд цагдан сэргийлэх албаны газар байгуулж тусгайлан гаргасан цагдан сэргийлэх түшмэл нэгийг Цэргийн яамнаас томилон гаргаж эрхлүүлэх бүхий л хэргийг Цэргийн яам эрхлэн захиран шийтгэмой. Хэмээн заасан нь гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг цэргийн яамд оногдуулж ард иргэдийн аюулгүй байдлыг хангах үүргийг хэрэгжүүлж иржээ.

Дүрэм хэмжээний Тавдугаар зүйл. Нийслэл хүрээний тойрон газрыг найман анги хуваан цагдан сэргийлүүлэх дор хялбар болгож өөр өөрийн хуваарийн газруудад өдөр, шөнө үргэлжид сайтар харгалзан сахиж, цаг мөчийн төдий ч осолдох, хийдүүлэхгүй болгон сайтар цагдан сэргийлье.[68]

Хэмээн заасан бөгөөд дараах найман газруудад хуваан морьт болон явган цагдаа цэрэг нарт даалган хариуцуулж хариуцсан нутаг дэвсгэртээ ард олны дунд ууж согтуурах, танхайрах, хэрүүл маргаан, зодоон, хулгай дээрэм, галын аюул гарахаас урьдчилан сэргийлж хашаа хороо барих, айл нүүх, суух зэрэгт хяналт тавьж ажиллаж байсан нь одоогоогийн засаг захиргааны нэгж хороодтой ижил төстэйгээр хуваан анги бүрийг цагдаа нарт хариуцуулж байсан нь одоогийн хорооны хэсгийн байцаагчтай дүйцэхүүц чиг үүрэг гүйцэтгэж, хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгаа явуулж байсны илрэл хэмээн бид үзэж байна.

[67] //МУҮТА, А-4, Д-1, х/н 564//

[68] //МУҮТА, А-4, Д-1, х/н 564//

Нийслэл хүрээний нутаг дэвсгэрийг хуваасан хүснэгт

*Хүснэгт №2.*

| № | Бүс | Хариуцуулсан газар | Хариуцсан алба хаагчийн тоо |
|---|---|---|---|
| 1 | Нэгдүгээр бүс | Их зээлийн олон худалдааны газар махны захаас хойших морь, тэмээ худалдаалах газар хүртэл | Морьт цагдаа цэрэг хоёр хүн, явган цагдаа цэрэг дөрвөн хүн |
| 2 | Хоёрдугаар бүс | Морь тэмээний зээлээс гандангийн зүүн хойд эргэцэг, мөн худалдааны олон пүүсийн хойд эргэцэг зэрэг газруудад хүртэл | Морьт цагдаа цэрэг дөрвөн хүн, явган цагдаа цэрэг найман хүн |
| 3 | Гуравдугаар бүс | Зүүн дамнуурчны олон худалдааны зэрэг газарт | Морьт цагдаа цэрэг хоёр хүн, явган цагдаа цэрэг хоёр хүн |
| 4 | Дөрөвдүгээр бүс | Түшээт хан аймгийн хооронд | Явган цагдаа цэрэг хүн дөрөв |
| 5 | Тавдугаар бүс | Сэцэн хан аймгийн хооронд | Явган цагдаа цэрэг хүн дөрөв. |
| 6 | Зургаадугаар бүс | Засагт хан аймгийн хооронд | Явган цагдаа цэрэг хүн дөрөв |
| 7 | Долоодугаар бүс | Сайн ноён хан аймгийн хооронд | Явган цагдаа цэрэг хүн дөрөв |
| 8 | Наймдугаар бүс | Их шавийн хорооны харчууд дор | Явган цагдаа цэрэг хүн дөрөв. |

Дүрэм хэмжээний 12-р зүйлд "Цагдан сэргийлэгчид нийслэл хүрээний газар аливаа хүн буудаллан цуглах ба будаа идэх, цай уух зэрэг олон газруудыг цагдан харгалзаж тогтоосон дүрмийн ёсоор дагаж явуулахыг хийчээмой. Хэрэв тэдний цуглагчид дотор цаазласнаас зөрчилдөх, хэрэлдэн цуугилдах ба мөрийцөн наадах, архи уух, хар тамхи татах, мөн дэмий ёс бусчлан үг хэлэлцэх зэрэг муу самуу гэм гаргахад хүрэх аваас зохигчдод ятган ухуулж дарангуйлан зогсоосугай" хэмээн зааснаас үзвэл хариуцсан нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг цэг газар, баар ресторан бусад аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл судалгаа хийж, тэдний үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж байсан нь одоогийн хэсгийн байцаагчийн чиг үүрийг гүйцэтгэж хариуцсан нутаг дэвсгэртээ энэхүү дүрэм хэмжээг сахиулж байсан нь ажиглагдаж байна.

Дүрэм хэмжээний 23-р зүйлд Аливаа цагдан сэргийлэгчид өөр өөрийн эрхэлсэн газрын доторхи аливаа хүний тус тусын аж ахуй, үйлдвэр явдал чухам ямар болох, мөн аль аймаг хошуу шавийн хэн хэн, хэд болохын нэр зэрэг зан суртал байдал, дүрсийг нарийвчлан мэдэж хянан баймой.

Бас ч харьяат газрын дотроо орон хашаа нэмэх хасах, шилжин нүүх ба гадаад, дотоодын олон хүний орох, гарах оршин суух зэрэг аливаа элдэв олон учрыг урьхан сэмхнээр ухан мэдэж харьяат албаны газар мэдүүлж мөнхүү албаны газраас учрыг хянан тодорхойлон гаргах даруй дээд яамнаа уламжлан мэдүүлж хянан байцаахад бэлтгүүлвээс зохимой[69]. Хэмээн заасан нь цагдаагийн алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрийн обьектын судалгааг зохих түвшинд хийж байхаар заасан нь олзуурхууштай.

Дээрх заалтаас үзэхэд цагдаагийн алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл, тухайн обьектын хэлбэр дүрс, тоо, хэмжээ, шинж чанар зэргийг нарийн судлаж байснаас үзэхэд обьектын судалгаа хийхдээ шинжлэх ухааны ажиглах, сурвалжлага хийх, ярилцах, хэмжилт хийх, зурах тэмдэглэх зэрэг аргыг ашиглаж, обьектын судалгааг шинжлэх ухааны түвшинд хийж ашиглаж байсны илрэл хэмээн бид үзэж байна юм.

Мөн обьектын судалгаа хийхээс гадна субьектын судалгаа хийж тухайн сэжиг бүхий субьектын овог нэр, зан байдал, оршин суух газар, орж гардаг газар зэргийг нарийн судлаж байсан нь субьектын судалгаанд судлах зүйл зүйлийг анх удаа тогтоосноороо ач холбогдолтой гэж бид дүгнэж байна.

[69] //МУҮТА, А-4, Д-1, х/н 564//

**Б.Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны хууль дүрэм Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль**

Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийх ажлын эрх зүйн эх сурвалжийн нэг нь 1923 оны 5 дугаар сарын 13 нд баталсан Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны хууль дүрэм Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль юм. Энэ хууль нь 9 бүлэг 35 зүйлтэй.

Уг хуульд цагдан сэргийлэгчид хариуцсан нутаг дэвсгэрт обьектын бүртгэл судалгаа явуулах талаар ямар нэгэн тухайлсан зүйл заалт тусгаагүй бөгөөд обьектын судалгаа хийх эрх зүйн үндэс нь цагдан сэргийлэгчдийн гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотойгоор тусгагдсан хэмээн үзэж болно. Үүнд:

Дүрэм хэмжээний 15-р зүйлд Дүрэм хэмжээ зөрчин жүжгийн ба олон зүйлийн зугаалан үзэх газар нээж байгуулах. Хэмээн зааснаас үзвэл аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийг бүртгэж зөвшөөрөл олгож байсны баталгаа бөгөөд цагдан сэргийлэгч нар өөр өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт нөхцөл байдлыг судлаж аж ахуйг бүртгэх, хяналт тавих үүргийг хэрэгжүүлж байсан харагдаж байна.

Мөн дүрэм хэмжээний 19-р зүйлд Өөрийн гэр хашааны орчинд аливаа олон хүн нэвтрэн явах газар байгаа гуу худаг, нүх зэргийг халхалж бүтээгээгүй. Хэмээн зааснаас үзвэл цагдан сэргийлэгчид осол, хэрэг үйлдэгдэх явдлаас сэргийлж гудамж талбай газар орны нөхцлийг шалгаж хянан магадлан осол хэрэг гарч болзошгүй эмзэг цэг газрыг тогтоож байсан нь одоогийн эмзэг цэг газрын судалгааг хийж байсныг илтгэнэ.

Дүрэм хэмжээний 27-р зүйлд Цагдан сэргийлэх албаны газраас тогтоосон цаг хэмжээнээс гадна хоолны пүүс ба архины пүүс, олон зүйлийн зугаацан наадах газар алгуурлан удах. Хэмээн зааснаас үзхэд аливаа аж ахуйн үйл ажиллагааны цагийн хуваарийг цагдан сэргийлэх газар тогтоож, ямар аж ахуй үйл ажиллагааг хэн, хаана явуулах талаар бүртгэл судалгаа хөтлөж түүнд цагдан сэргийлэгч нар хяналт тавьж ажиллаж байсан нь өнөөгийн захиргааны хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байсныг илтгэж байна.

Дээрх дүрэм хэмжээний агуулагаас үзэхэд цагдан сэргийлэгчид нь эхний үед гудамж хороодыг хариуцаж, гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй газраар явж, ууж согтуурах, танхайрах, хэрүүл маргаан, зодоон, хулгай дээрэм, галын аюул гарахаас урьдчилан сэргийлж илрүүлэх, сэжигтэй этгээд, орон байрны судалгаа хийж хяналт тавих зэргээр ажиллаж байсан нь одоогийн хэсгийн байцаагчийн үүргийг гүйцэтгэж байсан нь ажиглагдаж байна.[70]

**В. Нийслэлийн хүрээний Цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ**

Мөн 1923 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан Нийслэлийн хүрээний Цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ нь 4 бүлэг 42 зүйлтэй. Цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ нь алба хаагчид тогтоосон хууль тогтоомжийг журамлан дагаж ард олныг батлан хамгаалах, амар жимэр аж төрүүлэх зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байв.

Уг дүрэм хэмжээнд цагдан сэргийлэх хорооны алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрт обьектын судалгаа явуулах талаар тухайлсан зүйл заалт тусаагүй бөгөөд хариуцсан нутаг дэвсгэртээ биечилсэн судалгаа явуулах, аливаа хэргийн талаар мэдээ мэдээлэл цуглуулах, шалган шийдвэрлэх, гадаад дотоодын хүн цааз бичиг зарлиг дүрэм хэмжээг зөрчиж байгаа эсэхийг хянах, алдуул мал, гээгдэл эд хөрөнгө бүртгэх, эргүүлэн тушаах, өдөр, шөнийн цагаар сэжигтэй яваа хүнийг бүртгэх шалгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байна.Үүнд:

Дүрэм хэмжээний 6-р зүйлд аливаа чих сонссон, нүд үзсэн явдал нь цагдан сэргийлэх тушаалын хэрэгт холбогдох нь байваас тухай бүр эрхгүй харъяат захирах түшмэлд тодрхойлон мэдүүлвээс зохимой.

---

[70] Думбарай А. Монгол төрийн цагдаагийн түүхэн уламжлал, хөгжилт, УБ. 1999 он 79-р тал

11-р зүйлд Аливаа дотоод, гадаадын хүн иргэн тус улсын цааз, зарлиг дүрэм хэмжээ зэргийг журамлан дагаж буй үгүй явдлыг цаг бүр нарийвчлан цагдан байцааж, хааяа зөрчин явагчид байвал даруй зохих газарт мэдүүлэн нягтлан шийтгүүлбээс зохино.

Хэмээн зааснаас үзхэд цагдан сэргийлэх хорооны алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэртээ субьектын судалгаа хийж хэрэг явдлыг илрүүлэх, гадаад дотоодын иргэд хууль тогтоомжийг хэрхэн сахин биелүүлж байгаад хяналт тавих үүргийг хэрэгжүүлж байжээ. Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гадаад, дотоодын иргэдийн бүртгэл хөтлөж тэдний амьдарч буй газрын ойр орчимд сурвалжлага хийж, тэдний үйл хөдлөлийг хянаж байсны илрэл юм.

Мөн дүрэм хэмжээний 21-р зүйлд Өдөр шөнийн цагт аливаа хүн учир явдал сэжигтэйгээр явах буюу эсвэл буу зэвсэг ба сэжиг бүхий юм зүйлийг авч явахыг сайтар хянан байцааваас зохимой. Хэмээн заасан дээр дурьдсан хариуцсан нутаг дэвсгэртээ ажиглалт, биечилсэн судалгаа хийх зэрэгэр субьектын судалгаа хийж байсныг батлаж байна.

**Г.БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм хэмжээ**

Түүнчлэн 1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Улсын бага хурлын тэргүүлэгчид БНМАУ-ын Цагдан сэргийлэх газрын дүрэм хэмжээг батласан дүрэм хэмжээ нь 9 бүлэг 73 зүйлтэй. Цагдан сэргийлэх газрын дүрэм хэмжээ нь бүх улсын дотор амар амгалан байдлыг сахиж, ард олныг хамгаалахад холдбогдол бүхий цагдан сэргийлэх явдлыг эрхлэн гүйцэтгэхэд оршиж байв.

Уг дүрэм хэмжээнд Цагдан сэргийлэх ерөнхий газар, салбар хороодыг нээх, бэхжүүлэх холбогдох зардлыг улсаас гаргах, тэднийг албаны дүрэм хувцас зэвсгээр бүрэн хангах, орон нутаг хошуудад цагдан сэргийлэх хороодыг байгуулах, албанд шалгаруулан авах, тэднийг зааж сургах зэргээр цагдаагийн байгууллагыг өргөжүүлэн бэхжүүлэх үйл ажиллагааг өрнүүлжээ. Тухайлбал: Цагдан сэргийлэх газрын дүрэм хэмжээний 7-р зүйлд Цагдаа цэргүүдэд улсын суртал ба цэргийн сургууль, цэргийн хүмүүсийн сахиж дагах журам зэргийг ухуулан сургаваас зохимой. Мөн 9-р зүйлд харъяа ерөнхий газарт ерөнхий, бэлтгэл, эрүүгийн хэргийг эрхлэх гэсэн гурван хэлтэс байгуул, хэрэг зүйлийг хуваан шийтгэвээс зохимой.

Цагдан сэргийлэх газрын орон тооны талаар 10-р зүйлд мөнхүү газрын албан хаагчдын орон тоог Дотоод явдлын яамнаас хянан төлөвлөж, Засгийн газраа батлан тогтоолговоос зохимой[71]. хэмээн заасан байна.

Уг дүрэм хэмжээнд цагдан сэргийлэх ерөнхий газар, хорооны алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрт обьектын судалгаа явуулах талаар тухайлсан зүйл заалт тусаагүй бөгөөд дээр дурьдсан 1923 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан Нийслэлийн хүрээний Цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээнд заасантай ижил зааж өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газраас 1928 оны 01-р сарын 06-ны өдөр Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрмийг 10 бүлэг 56 зүйлтэйгээр баталсан. Уг дүрмийн зорилгыг 3-р зүйлд дараах байдлаар томъёолсон. Үүнд:

Харъяат хотын дэвсгэр болох газрын доторх олон ардын амгалан байдлыг сахин хамгаалах ба элдэв зүй бус явдлуудыг ариутгахын учир цаг ямагт санаа тавин нарийн чангаар цагдан сэргийлж дээд газруудаас тогтоосон нийтэлсэн аливаа хууль, цааз зарлал хийгээд дүрэм зааврыг зөрчигсөд ба эрүүгийн хэрэгт холбогдсон хэрэгтэн этгээдийн зэрэг зальхай, самуун хүмүүсийг байцаан бариулж хууль дүрмийн ёсоор цээрлүүлэн шийтгэх буюу зохих газарт шилжүүлбэл зохимой.[72] хэмээн анх удаа дүрэмд эрүүгийн хэргийн холбогдогчийн талаар тусгаж өгсөн бөгөөд эдгээр хүмүүнийг хууль цааз, дүрэм, зааврыг зөрчсөн тохиолдолд барих, байцаан шийтгэх, цээрлүүлэх тухай авч үзсэн нь гэмт хэрэг үйлдэгч нартай тэмцэх, цээрлүүлэх бодлого явуулж ирсныг батлаж байна. Нөгөө талаар хариуцсан

---

[71] Хүрэлбаатар Т. Цагдаагийн ерөнхий газрын төв архивын газар, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. УБ хот 2016 он 143 дахь тал

[72] //МУҮТА засгийн газрын албаны сэтгүүл 38 дугаар дэвтэр 47-58 дахь тал//

нутаг дэвсгэртээ нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтий аюулгүй байдлыг хангах, аливаа хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нарийн чанд хэрэгжүүлж иржээ.

Ийнхүү гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтий аюулгүй байдлыг хангах, аливаа хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ уг дүрмийн 4-р зүйлд зааснаар ...тус хотын дотор олон нийтийн худалдааны ба аливаа хуралдах цэнгэлдэх газруудад буюу зах зээл, зам гүүрийн зэрэг газар олон хүмүүсийн цугларах, сэлгүүцэхийн дотор шударга, самууны байдлыг хянан харгалзуулах ба галын аюул буюу бусад олон зүйлийн хорлолтой явлыг цаггүй сэргийлэн хамгаалж, сайтар сахин харгалз... хэмээн заасан нь худалдаа үйлчилгээ явуулах зах, олон нийтийн бусад газруудад буюу гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмцэг цэг газрын бүртгэл хөтлөх, тэмдэглэх үйл ажиллагаа явуулж тэрхүү газарт хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлж байжээ.

Мөн заалтуудас үзхэд цагдан сэргийлэгч нар хариуцсан нутаг дэвсгэртээ ажиглалт, биечилсэн судалгаа хийж нутаг дэвсгэртээ ямар ямар үйл явдал болж буйг судлан мэдэж хариуцсан нутаг дэвсгэрийн нөхцөл байдлын судалгаа хийж, шинээр хашаа хороо, байшин барих зэрэгт хяналт тавьж, хариуцсан нутаг дэвсгэртээ хүн амын бүцийн судалгаа хийж байсныг илэрхийлнэ. Нөгөө талаар цагдан сэргийлэгчид нь өдөр шөнийн цагаар хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж сэжиг бүхий хүн, ачаа тээш авч яваа этгээдийг саатуулан шалгаж, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн бүргэл судалгаа явуулах ажлын эхлэлийг тавьж байжээ.

**Д. Гадаад улсууд лугаа зах нийлсэн олон аймаг хошуудаас хил хязгаараар суулгасан цагдаа нарын түр дагаж явах дүрэм**

Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 1928 оны 61-р дүгээр хурлын 1-р тогтоолоор Гадаад улсууд лугаа зах нийлсэн олон аймаг хошуудаас хил хязгаараар суулгасан цагдаа нарын түр дагаж явах дүрэм батласан бөгөөд уг дүрэмд цагдан сэргийлэгч нараас хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгаа хийхтэй холбоотой дараах зүйлийг тусгасан байна.

3-р зүйлд “Цагдаа нараар газар орны нутгийн ойр тохиолдох албан газрууд луга эрхбиш үргэлж хэлхээ холбоотой байваас зохих бөгөөд онц түргэн бачим хэрэг гарах аваас хүчин туслалцах зэргээр хавсралцан гүйцэтгэвээс зохимой”[73] хэмээн зааснаас үзхэд нутаг дэвсгэр хариуцсан цагдаа нар өөр өөрийн нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлж, аливаа гэмт хэргийг илрүүлэхдээ мэдээ мэдээлэл харилцан солилцох, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллаж гэмт этгээдийг баривчлан мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлж байжээ.

Мөн 5-р зүйлд “Харьяат цагдаа нар өөр өөрийн ба орон нутгийн хүмүүс лугаа хэлхээ холбоог зузаатган элдэв түргэн мэдээ, чимээ авалцаж аливаа бат баримт бүхий нь улмаар аль ойр нутаг тохиолдох албан газар урьдаар нэвтэлгэн явуулах зэргээр гүйцэтгэвээс зохимой” хэмээн зааснаас үзхэд обьектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болсон цагдаагийн туслах хүчний судалгааг хийж ард иргэдтэй ойр дотно байж, гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах улмаар гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг олон нийтэд түшиглэн хэрэгжүүлж цагдаагийн туслах хүчийг бэхжүүлж байсны жишээ юм.

Энэхүү дүрмийн онцлог нь хил хязгаарыг цагдаа нараар хянан харгалзуулж, гадаад дотоодын иргэдийн орж гаргах, эд бараа нэвтрүүлэх, тоо хэмжээ хязгаар зэргийг хянан шалгаж нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэх, гадаадын иргэн орон байр барих, нутаглах мал адгуулах, ан агнах, ой мод баялагыг зөвшөөрөлгүй ашиглах явдалд цагдаа нар хяналт тавихаар зохицуулж өгсөн явдал юм.

**Е.БНМУА-ын Цагдан сэргийлэх тухай дүрэм**

---

[73] Нийслэлийн архив Х-1, Д-1 х/н 919

Сайд нарын зөвлөлөөс 1934 оны 02-р дугаар сарын 02-ны өдөр БНМУА-ын Цагдан сэргийлэх тухай дүрэм 7 бүлэг 29 зүйлтэйгээр баталсан.

Уг дүрэмд Цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа хийхтэй холбоотой дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

15-р зүйлд Цагдан сэргийлэхээс эрүүгийн хэрэгт холбогдох гэмт явдлуудыг урьдаас сэргийлэн зогсоох ажлыг гүйцэтгэнэ. Хэмээн зааснаас үзэхэд цагдаа нар хариуцсан нутаг дэвсгэртээ нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын ба иргэдийн өмч хөрөнгийг хамгаалах, нийтийг хамарсан арга хэмжээний тухайлбал яармаг худалдаа явуулах газрыг хянаж дэг журам сахиулж байсан нь санамсаргүй хэрэг биш юм. Тухайн үедээ цагдаа нар нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тодорхой судалгаа тооцоонд үндэслэн дээр дурьдсан тодорхой газруудад анхаарал хандуулж байсан нь ажиглагдаж байна.

Түүнчлэн 16.3-т Гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдийн талаар өгүүлж байгаа бөгөөд эдгээр сэжигтэй этгээдүүдийн талаар цагдаа нар ард иргэдээс мэдээлэл цуглуулах, тэдний зан суртал байдлыг ухан мэдэж байсан нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдийн талаар судлаж байсан нь ажиглагдлаа[74].

**Ё. Дотоод явдлын яамны харъяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм**

БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчид, сайд нарийн зөвлөлийн хамтарсан хурлаар 1949 онд Цагдан сэргийлэх газрын дүрмийг 4 бүлэг 13 зүйлтэй баталсан.

Уг дүрмийн 2-р зүйлд Цагдан сэргийлэх газрын бүтэц зохион байгуулалтыг тогтоож дараах хэлтэс тасгийг байгуулжээ. Үүнд:

1. Эрүүгийн гэмт хэргийг эрэн сурвалжлах гүйцэтгэх нэгдүгээр хэлтэс;
2. Улс олон нийтийн өмчид халдсантай тэмцэх гүйцэтгэх хоёрдугаар хэлтэс;
3. Мөрдөн байцаах хэлтэс;
4. Паспортын хэлтэс;
5. Ардын үйл явдлын хөдөлгөөнийг бүртгэх хэлтэс;
6. Улсын авто техникийн хэргийг шалган байцаах хэлтэс;
7. Сэргийлэх хамгаалах хэлтэс;
8. Улс төрийн хэлтэс;
9. Тоо бүртгэлийн хэргийг эрхэлсэн тусгай тасаг;
10. Санхүүгийн тасаг;
11. Аж ахуйн хэлтэс;
12. Нийслэл улаанбаатар хотын цагдан сэргийлэх анги;
13. Аймгуудын цагдан сэргийлэх ангиас бүрдэнэ хэмээн заажээ.

Бидний судалгааны ажлын сэдэв агуулгын хүрээнд авч үзвэл дээрх тасаг хэлтсүүдээс Паспортын хэлтэс нь Ардын Сайд нарын зөвлөлийн батласан дүрмийг баримтлан улсын хэмжээний хүн амын бүртгэл судалгааг хөтлөж явуулах бөгөөд Улсын цагдан сэргийлэх газрын даргад захирагдана хэмэээн заасан нь хүн амын бүртгэл судалгааг хийх үүргийг хэрэгжүүлж байсны тод жишээ юм. Түүнчлэн эрүүгийн хэргийг эрэн сурвалжлах нэгдүгээр хэлтэс, улс олон нийтийн өмчид халдсантай тэмцэх гүйцэтгэх хоёрдугаар хэлтэс, мөрдөн байцаах хэлтсүүд нь Дотоод явдлын яамны сайдын баталсан тусгай зааврын дагуу улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа хэрэгжүүлж иржээ. Энэхүү тусгай заавар нь өнөөгийн Гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад журам, зааварaар зохицуулж байсан нь маш нууцын зэрэглэлд хамаарч байгаа учир цааш дэлгэрүүлэн судлах боломж хомс байгааг дурьдах нь зүйтэй.

[74] Думбурай А. Монгол төрийн цагдаагийн уламжлал түүхэн хөгжилт, УБ хот. 105 дах тал

Дүрмийн 2-р зүйлд Цагдан сэргийлэх газар нь улсаас гаргасан хууль, дүрмийг зөрчиж, гэмт хэрэг өдүүлэгч лүгээ тэмцэхдээ дор дурьдсан үүргийг биелүүлнэ. Үүнд:

2.1.Хулгай дээрэм, хүн амь танхай балмад, залилан мэхлэх зэрэг эрүүгийн гэмт хэргийг эрэн сурвалжилж олж тогтоох;

2.4.Мөрдөн байцаах, шүүн таслах, хорих газруудаас оргон зайлсан этгээдүүдийг бүртгэн тэмдэглэх, эрэн сурвалжилж олж уул байгууллагадаа өгөх

2.5.Хулгайд алдсан эд хөрөнгө малыг бүртгэн тэмдэглэх, эрэн сурвалжилж олох замаар ардын хохирлыг барагдуулах;[75]

Хэмээн зааснаас үзвэл гэмт хэрэгтэй тэмцэх ялангуяа өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлж хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаанаас оргон зайлсан этгүүдийн тоо бүртгэл хөтлөж тэдгээрийн араас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан нь цагдаагийн байгууллага гэмт хэргийн болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн талаар бүртгэл судалгаа хөтлөж санаа тавин шалган шийдвэрлэж байсны илрэл юм.

Дүрэмд зааснаар айл өрхийн агт морь, авто тээврийн хэрэгслийг эзэмшигч нь хэн болох, хаана оршин сууж байгаа, агт морьд, авто тээврийн хэрэгслийн тоо хэд болохыг бүртгэж байсан нь авто машинтай болон малтай иргэдийн бүртгэл судалгааг хийж байсны жишээ юм.

**Ж.Сайд нарын зөвлөлийн БНМАУ-ын Дотоод явдлын яамны харъяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм**

Сайд нарын нарын зөвлөлийн БНМАУ-ын Дотоод явдлын яамны харъяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрмийг 1963 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 4 бүлэг 83 зүйлтэйгээр баталжээ.

Дүрмийн 2-р бүлгийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар гэсэн хэсгийн 1-р зүйлд Хуулийн бусад байгууллагатай хамтарч гэмт хэргийн үүсэн гарч байгаа шалтгаан нөхцөл байдлыг судлан илрүүлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гэмт хэргийг илрүүлэх арга хэмжээ авна, 3-р зүйлд Гэмт хэргийн сэжигтэй хүмүүсийг албадан саатуулж шалгана, 4-р зүйлд оргон зайлсан этгээдүүд болон эд хөрөнгийг эрэн сурвалжилна, 8-р зүйлд Эрүүгийн хэргийн тоо бүртгэл хөтлөнө.[76] Дээрх дүрмийн 1-р зүйлд заасныаас үзвэл цагдан сэргийлэгчид нутаг дэвсгэртээ үйлдэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөж, хариуцсан хороо, сум, багийн нутаг дэвсгэрт криминологийн судалгаа хийж, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрүү хэв журмын нөхцөл байдлыг судлан цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байсан нь цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү хэв журмын нөхцөл байдлын судалгааг хуулийн хүрээнд хийхээр тусгасан нь сайшаалтай.

Цагдаагийн байгууллага дүрмээр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг саатуулан шалгаж сэжигтэй этгээдийг бүртгэх, эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйлийн жагсаалт гарган хянан шалгаж байсан нь обьектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээд, эрэн сурвалжилж байгаа хүн эд зүйлийн талаар бүртгэл судалгаа хөтлөж үйл ажиллагаандаа ашиглах эрх зүйн үндэс нь болжээ.

Мөн энэхүү дүрэмд зааснаар цагдан сэргийлэгч нар нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн байгууллагаас зохион байгуулж байгаа жагсаал, нийтийн зугаалга, биеийн тамирийн тэмцээний үед нийтийн хэв журам сахиулах, нутаг заагдсан хүмүүст хяналт тавих, авто тээврийн болон ердийн хөсөг, явган хүмүүсийн хөдөлгөөнийг зохицуулах, галын аюулаас хамгаалах, паспортын дүрмийг биелүүлэх, иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байв.

Түүнчлэн дүрмийн 2-р бүлгийн 17-р зүйлд зааснаар “Тэсэрч дэлбэрэх материал хордуулах бодис, буу зэвсэг галт хэрэгслийг худалдан авах, тээвэрлэх зөвшөөрөл олгох, тамга тэмдэгийг бүртгэх,

---

[75] Тагнуулын ерөнхий газрын тусгай архив Х-1 Д-1 х/н 99

[76] Хүрэлбаатар Т. Цагдаагийн ерөнхий газрын төв архивын газар, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. УБ хот 2016 он 339 дахь тал

буу зэвсэг худалдан авах, хэрэглэх зөвшөөрлийг зарим иргэдэд олгоно[77]" хэмээн зааснаас үзвэл цагдаагийн байгууллага галт зэвсэг эзэмших, ашиглахад нь хяналт тавьж байсан нь обьектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох галт зэвсэгтэй этгээдүүдийн бүртгэл судалгаа хийх үндэс суурийг тавьжээ.

1970 онд ЗХУ болон социалист бусад орны Цагдан сэргийлэх байгууллагын туршлагаас суралцах, ЗХУ-ын ДЯЯ-ны тогтмол хэвлэлийг ашиглах зорилгоор хэвлэл мэдээллийн групп байгуулж ажиллах, тэдгээр улсын туршлагыг орчуулж социалист орнуудын хэвлмэл тойм гэсэн бичмэл эмхтгэл гаргах зэрэг арга хэмжээнүүд авсан нь эрүүгийн хэрэг эрэн сурвалжлах албаны ур чадвар дээшилж, хариуцсан нутаг дэвсгэрийн обьект, субьектын судалгаа хийх, гэмт хэрэг илрүүлэх, ялангуяа илрээгүй хэргийг нөхөн илрүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байжээ[78].

Үүнээс гадна 1960-1970 онуудад Цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагааны гол анхаарсан зүйл бол гэмт хэргийн гаралт ихсэх мөн үйлдвэржилт ихээр хөгжсөн, Монгол улсын гадаад харилцаа харьцангуйгаар хөгжих болсон зэрэг онцлог явдлуудтай холбоотойгоор обьектын судалгааг сайтар хийх шаардлага гарч байжээ. Энэхүү шаардлагын хүрээнд Цагдан сэргийлэх байгууллагын хэмжээгээр гэмт хэрэг гарч буй шалтгаан нөхцлийг судлах оролдлого хийж, залуу үеийнхний дотор гарч буй гэмт хэрэг зөрчлийн байдлыг дээд шүүх, прокурор, НАХЯ-ны коллеги, МХЗЭ-ийн төв хорооны хамтарсан хурлаар, автомашины аваар ослын талаар 10 жилийн судалгаа хийж, Тээвэр Холбооны яамны саналыг үндэслэн хэлэлцэж Цагдан сэргийлэх байгууллагын үүргийн дотор тусгаж өгсөн байна.

Тухайлбал: Үйлдвэр, албан газар, байгууллага иргэдийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтөлж, тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдалд хяналт тавих, нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэд, аль ч биш улсын харъяат биш хүмүүсийг бүртгэлжүүлэх, ял эдлээд судлагдсан этгээдийг хяналтандаа авч ажил хөдөлмөр эрхлэх боломжид туслах зэрэг нийтэд хандсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор обьектын судалгааг гаргаж байсан байна.

НАХЯ-ны сайд Б.Дэжид 1976 онд 136 тоот тушаал гаргаж хороодын байцаагчдын эрх хэмжээг Цагдан Сэргийлэх байгууллагын сэргийлэн хамгаалах албаны офицерийн зэрэгт хүргэж, тэднийг шууд хариуцсан обьект, нутаг дэвсгэр болон үндсэн үүргээс нь өөр ажилд дур мэдэн татаж ажиллуулахыг хоригложээ. Энэхүү тушаалд зааснаар дараах чиг үүгийг хэрэгжүүлэх үүрэг өгч байжээ.Үүнд:

- Хариуцсан хэсгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хилийн зааг, гудамжталбай, гэрбайшин, хашааны эзэмшигч, орохгарахүүд хаалга, боловсрол, соёл урлаг, эмнэлэг, ариун цэврийн, худалдаа үйлчилгээний цэг салбар, албан байгууллага, үйлдвэр аж ахуйн газар, цэцэрлэг талбай, харуул хамгаалалт, холбоо барих хаягийг урьдчилан судалсан байх;
- Нийгмийн хэв журам сахиулахад туслах төв, Орон сууц гудамжны хороо тэдгээрийн удирдах хүмүүсийн нэр хаягийг мэдэж байх;
- Хүн амын бүрэлдхүүн, зан заншлын онцлогийг мэдэж, хэрэг зөрчилд өртөж болох, захиргааны хяналтанд авагдсан хүмүүсийг таньж судлах;
- Гэмт хэрэг гарч болзошгүй газар, сэжигтэй байр, хэрэг зөрчил үйлдэгч этгээдүүдийн бүгэж цугладаг газрыг тогтоох;
- Хариуцсан хэсэгт байгаа гэмт хэрэг үйлдэгчийн байдал хэргийн өнгө, тоо, түүнд нөлөөлж буй нөхцөл шалтгааныг судалж мэдсэн байх зэрэг 5 төрлийн үүрэг зааврыг өгч байсан нь өнөө цагийн хэсгийн байцаагчийн ажлын зааврын үндсэн суурь болсон байна.

Түүнчлэн нийслэл Улаанбаатар хотын хүн амын нягтрал суурьшил сүүлийн жилүүдэд ихсэж хороодууд нэмэгдэж, Нийслэлийн хороод бүр хэсгийн байцаагч-1, хорооны цагдаа-1 орон тоотой үүрэг гүйцэтгэж иржээ.

---

[77] Хүрэлбаатар Т. Цагдаагийн ерөнхий газрын төв архивын газар, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. УБ хот 2016 он 339 дахь тал

[78] Думбурай А. Монгол төрийн цагдаагийн уламжлал түүхэн хөгжилт, УБ хот. 105 дах тал

### З. БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн 1985 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 96 дугаар зарлигаар БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн эрх, үүрэг

БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн 1985 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 96 дугаар зарлигаар БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг эрхийг тогтоосон зарлиг гаргажээ.

Зарлигт Цагдан сэргийлэх байгууллагын нэн чухал зорилт нь гэмт хэрэг, нийгэмд харш бусад үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, түүнчлэн гэмт хэрэг эрх зүйн бусад зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал мөн гэж Цагдан сэргийлэх байгууллагын зорилгыг тодорхойлжээ.

Зарлигын 7-р зүйлийн:

в-д гэмт хэрэг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохиож, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, үйлдэгдэх бололцоо олгож байгаа нөхцлийг нь олж илрүүлж, тэдгээрийг арилгах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

и. хүүхдийг хараа хяналтгүй байлгах явдлаас урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүй хүмүүсээс эрх зүйн бусад зөрчил гаргах явдалтай тэмцэх ажлыг улс хоршоолол, олон нийтийн байгууллагатай хамтран зохиох;

л.паспортын системийг хэрэгжүүлэх явдлыг хангаж, иргэд албан тушаалтан уг системийн шаардлагыг сахин биелүүлж байгаад хяналт тавих;

м.мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхээс оргон зайлсан ялтан, сураггүй бологсдийг эрэн сурвалжлах;

н.авто тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх зэрэг болно.

Дээр дурьдсан гэмт хэрэг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохиож, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцлийг тогтоон арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, эрэн сурвалжлах, хүн амын бүртгэл судалгаа хөтлөх, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэгт өртөж хохирох бусдад уруу татагдах явдлаас сэргийлж энэ талаар обьектын бүртгэл судалгаа хийж нарийн хөтлөж, дурьдсан заалтыг улс хоршоололын бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж байсан обьектын судалгааг ашиглан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж иржээ.

Мөн зарлигийн 7-р зүйлийн п-т нутаг заах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан болон ялтныг хөдөлмөрт татан оролцуулахаар хорих ялыг тэнссэн, хорих ялаас хугацааны өмнө суллагдсан хүмүүст хяналт тавих[79].

Хэмээн заасан нь цагдаагийн байгууллагын обьектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох субьектын судалгааны төрөл хорихоос суллагдасан хүний бүртгэл судалгаа хийж ашиглах талаар анх удаа эрх зүйн зохиуцуулалтыг зааж өгсөн нь энэ төрлийн судалгааг хийж баяжуулан, хорихоос суллагдсан болон ял тэнссэн этгээдүүдэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтанд байгаа хүний тоо, хаана оршин сууж байгаа, овог нэр, хоч хэн болох, гэр бүлийн байдал, эрхэлсэн ажил зэргийг бүртгэн судлаж байсан нь үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, эзэн холбогдогч тогтоогдоогүй хэргийн газраас бэхжүүлсэн ул мөр, нотлох баримт, мэдээ материалтай харьцуулж гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлжээ.

### И. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс 1985 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн 95 дугаар тогтоолоор баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс 1985 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн 95 дугаар тогтоолоор БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрмийг 6 бүлэг 32 зүйлтэй батлан гаргаж мөрдүүлжээ.

---

[79] Хүрэлбаатар Т. Цагдаагийн ерөнхий газрын төв архивын газар, Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхтгэл. УБ хот 2016 он 339 дахь тал

Дүрмээр Цагдан сэргийлэх байгууллагын чухал зорилт нь гэмт хэрэг, нийгэмд харш бусад бусад үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, түүнчлэн гэмт хэрэг эрх зүйн зөрчлийг үүсгэж байгаа шалтгаан нөхцлийг арилгах бүх талын тус дэмжлэг үзүүлэхэд оршиж байв. Дүрмийн 3-р бүлэг Цагдан сэргийлэх байгуулагын үүрэг гэсэн бүлгийн 18-р зүйлийн дараах заалтад тусгажээ.

в.гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохиож гэмт хэргийг илрүүлэн түүний үүсэж гарч байгаа шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, арилгах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх;

г.бэлтгэж завдаж байгаа буюу үйлдэгдсэн гэмт хэргийн тухай болон нийгмийн хэв журам хамгаалахтай холбоотой асуудлаар үйлдвэр, албан газар, байгууллага, албан тушаалтан, иргэдээс ирүүлсэн санал, гомдол, өргөдөл мэдээллийг тогтоосон журмын дагуу хүлээн авч шалгаж шийдвэрлэх;

п.нутаг заах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан болон ялтныг хөдөлмөрт татан оролцуулахаар хорих ялыг тэнссэн, хорих ялаас хугацааны өмнө суллагдсан хүмүүст хяналт тавих, нийгмийн туст хөдөлмөр эрхлэх, амьдралаа зохиход нь туслалцаа үзүүлэх;

у. үйлдвэр албан газар, иргэдийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөж, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих;

ч.засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах алба хамтран рецидив гэмт хэрэгтэй тэмцэх, илрээгүй гэмт хэргийг нөхөн илрүүлэх ажлыг анги колониудад зохиох зэрэг болно.

Дээрх заалтуудаас үзвэл гэмт хэргийн талаар үйлдвэр, албан газар, байгууллага, албан тушаалтан, иргэдээс ирүүлсэн санал, гомдол, өргөдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн талаар тоо бүртгэл хөтлөж аль дүүрэг хороо сумдад ямар төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа, түүний шалтгаан нөхцөл чухам юунд оршиж байгааг тогтоон хорихоос суллагдсан этгээдүүд хаана хаана, хэн хэн оршин сууж байгаа, галт зэвсэг, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчид байдал зэргийг судлан бүртгэж байсан нь цагдаагийн байгууллагаас обьектын судалгааг өргөн цар хүрээтэйгээр хийж ажиллаж байжээ гэж үзэж болохоор байна.

Мөн нуугдмал гэмт явдлыг илрүүлэх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх зорилгоор ял эдлэж байгаа ялтан, рецидив гэмт хэрэгтнүүдийн судалгаа бүртгэл хийж, тэдний зүгээс үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх үүргийг хорих ангитай хамтран хэрэгжүүлж байсан нь бүртгэл судалгаа нарийн хийж, тэдний дундаас мэдээ мэдээлэл олох шалгах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж байжээ.

Түүнчлэн дүрмийн 4-р бүлгийн 19-р зүйлийн дараах заалтуудад Цагдан сэргийлэх байгууллагын эрхийг заасан бөгөөд цагдаагийн байгууллагаас обьектын судалгаа явуулах талаар эрхийг олгожээ. Үүнд:

е.нийгмийн хэв журмыг удаа дараа зөрчсөн этгээдийг зохих бүртгэлд авч нийгэмд харш зан үйлээ засах албан ёсны сануулга өгөхийн тулд шаардлагатай үед цагдан сэргийлэх байгууллагад дуудан ирүүлэх;

м.яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн, цагдан хоригдож байгаа буюу албадан саатуулагдаж байгаа, захиргааны журмаар баривчлагдсан этгээдүүдийн гэрэл зураг, хурууны хээний дардасыг буулгах;

Дээрх заалтаас үзвэл нийгмийн хэв журмыг удаа дараа зөрчсөн өөрөөр хэлбэл гэр бүл орчиндоо тааламжгүй байдал гаргадаг, ойр орчиндаа түгшүүр төрүүдэг, нийгмийн хэв журмыг зөрчигчдийг субьектын судалгааны хэсэг болох зөрчил үйлдэж болзошгүй болон байнга зөрчил гаргагчдын бүртгэл, судалгаанд авч тэдний зүгээс дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагад дуудан ирүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийг хэргжүүлж байсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой хэрэгжүүлж байсныг илэрхийлэх ажээ.

Яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн, цагдан хоригдож байгаа буюу албадан саатуулагдаж байгаа, захиргааны журмаар баривчлагдсан этгээдүүдийн гэрэл зураг, хурууны хээний дардасыг буулгаж авах нь субьектын судалгааны төрөл болох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүсийн бүртгэл судалгаа болон, зөрчил үйлдэж баривчлагдсан хүмүүсийн бүртгэл судалгааг баяжуулах нэг хөшүүрэг нь болсон. Түүнчлэн цагдаагийн байгууллагын обьект, субьектын судалгаа хийх ажилд криминалистикийн бүртгэлийг нэвтрүүлж, криминалистикийн арга техник, технологийг ашиглан бүртгэл судалгаа явуулах эрх зүйн үндэс суурийг уг дүрэмд анх удаа заажээ.

**Дүгнэлт**

- Богд хаант төрийн үеийн Цагдан сэргийлэх байгууллагын үед 1865 оноос хойш тусгай түшмэлүүд томилж их хүрээнд хэв журам сахиулах арга хэмжээг авсан ба Их хүрээний нутаг дэвсгэрийг төвөөс нь тал тийш 3 хувааж өөр өөрсдөө тэмдэг тавин тухайн газар нутаг дэвсгэр дээрээ хяналт тавьж, биечилсэн судалгаа хийж, аливаа хэрэг явдлыг судлах, хяналт тавьж байсан нь нутаг дэвсгэрт обьектын судалгаа тодорхой хүрээ заагтай, хариуцсан нутаг дэвсгэртээ хийж байсны илрэл хэмээн үзэж болохоор байна.
- Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнө 1923 онд 1 удаа, батлагдснаас хойш 1924-1942 оны хооронд 1926, 1928, 1934, 1942 онуудад 4 удаа цагдаагийн байгууллагын дүрэм хэмжээг улс орны нийгэм, эдийн засаг, хүн ам, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн хувиарлалтад нийцүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор өөрчлөн шинэчилж цагдан сэргийлэх байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэртээ обьектын судалгаа хийх эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлж, цар хүрээг нь өргөтгөж байсан нь обьектын судалгаа хийх үндэс суурь болжээ гэж үзэж болохоор байна.
- Цагдаагийн эрх зүй, криминологийн ном бүтээлүүдэд “цагдаагийн байгууллагын обьектын бүртгэл, судалгаа”, “нутаг дэвсгэрийн бүртгэл, судалгаа” гэсэн нэр томьёолоолоор дурьдагдсан түүхэн эх сурвалж баримт, бичгүүдийг обьектын судалгааны эх сурвалж хэмээн авч үзэх нь онол, практикийн хувьд ач холбогдолтой байна.
- Цагдаагийн байгууллага, алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэрийн обьектын аж ахуйн нэгж, үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл, тухайн обьектын хэлбэр дүрс, тоо, хэмжээ, шинж чанар зэргийг нарийн судлаж байснаас үзэхэд обьектын судалгаа хийхдээ шинжлэх ухааны ажиглах, сурвалжлага хийх, ярилцах, хэмжилт хийх, зурах тэмдэглэх зэрэг аргыг ашиглаж байсан нь обьектын судалгаанд шинжлэх ухаанчаар хандаж, хийж ашиглаж байсны илрэл хэмээн бид үзэж байна.

# ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ОЛОН НИЙТИЙГ ОРОЛЦУУЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

*ДХИС-ийн магистрант,*
*цагдаагийн ахмад Н.Амартүвшин*

**Товчлол.** Цагдаагийн байгууллага гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дан ганц өөрсдийн алба хаагчдын хүчээр ажиллах бус энэ үүргээ хурдан шуурхай, чанартай гүйцэтгэхийн тулд иргэд оршин суугчид, аж ахуй нэгж байгууллагын хүчийг ашиглах явдал чухал юм.

Энэхүү өгүүлэлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, олон нийтийн хэрхэн ямар хэлбэрээр оролцуулж ирсэн түүхэн уламжлал, түүнээс авч болох зарим туршлагын талаар товч авч үзсэн болно.

**Түлхүүр үг.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригад, нийтийн эргүүл, нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөл

**Үндсэн хэсэг.** Чингис хаан гэмт явдлыг тайван цагийн, цэрэг дайны үеийн гэж ангилалд тус бүрт нь түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байжээ. Гэмт хэрэг гарч байгаа гол шалтгааныг ч нээн олж, түүнийг шийдвэрлэх нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх гол нөхцөл болно гэсэн философийг дэвшүүлжээ[80].

Тухайн үед хүн амын дотор гэмт хэрэг гаргахгүйн тулд гар урчууд, эрдэм билэгтэй хүмүүс, шашны санваартан нарыг хүндэтгэн үзэж, хамгаалалтанд авч, тэднээр дамжуулан, заргачаар тавьж тайван байдлыг тотоодог байлаа. Хэд хэдэн улсын хэл мэдэх уйгур буюу перс хүмүүс Чингис хаанд үйлчилж, нутаг, нутгийн хүн амыг ёс заншлын нь дагуу, шүтдэг шашныг нь хүндэтгэн, уян хатан аргаар удирдан гэмт явдлаас урьдчилан сэргийлж байсан юм. Чингис хаан гэмт явдлыг тайван цагийн, цэрэг дайны үеийн гэж ангилалд тус бүрт нь түүхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байжээ. Гэмт хэрэг гарч байгаа гол шалтгааныг ч нээн олж, түүнийг шийдвэрлэх нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх гол нөхцөл болно гэсэн философийг дэвшүүлжээ[81]

Энэ үед иргэний хэрэг шүүн сахиулж хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг төрийн уламжлалт бодлого болгон хааны зарлиг, хууль, "Их Засаг" хуулиар зохицуулж явуулахдаа улам боловсронгуй болгосоор байсан бөгөөд "Их Засаг" хууль нь урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх хүртэл хэм хэмжээг тогтоосон ерөнхий хэсэгтэй байжээ.

1865 онд Богд Жавзандамба хутагтын зарлигаар "Арван тавны цагдаа" гэдэг газрыг байгуулах шийдийг гаргаж байсан, дээрхи бичгүүдийг 1866 онд үйлдэж байсан байна. 1916 онд Богд хааны зарлигаар "Хүрээний цагдан сэргийлэх алба"-ны газрыг анх байгуулж, мөрдөн ажиллах дүрмийг батлан мөрдүүлснээр өрх гэрийн байдлаар олон жил ажиллаж ирсэн арван тавны цагдааг өөрчилж, тусгай хувцас, ялгах тэмдэгтэй болжээ.

---

[80] С.Бадарчи. Чингис хаан ба Монгол Улсын сахилга, дэг журам тогтоосон үйл ажиллагааны онцлог. УБ. 2013. 7 дах тал
[81] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн түүхэн замнал. УБ. 2005.

Ингээд улс орон хөгжихийн хирээр гэмт хэрэг зөрчлийн хэмжээ нэмэгдэж, цагдаагийн байгууллагаас нийгэмд үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ өсч байсан нь Цагдаагийн байгуулага үүргээ гүйцэтгэхдээ ард иргэдийн оролцоо, дэмжлэгийг авах зайлшгүй шаардлагын үндсийг тавьж байсан юм. Улс орон хөгжихийн хирээр гэмт хэрэг зөрчлийн хэмжээ нэмэгдэж, цагдаагийн байгууллагаас нийгэмд үзүүлж буй үйлчилгэний цар хүрээ өсч байсан нь цагдаагийн байгууллага үүргээ гүйцэтгэхдээ ард иргэдийн оролцоо, дэмжлэгийг авах, зайлшгүй шаардлагын үндсийг тавьж байсан юм.

1928 онд Улаанбаатар хотын захиргаа, цагдан сэргийлэх газар, хороодын дарга нар, шашны хурлын хэрэг эрхлэх түшмэл нарын хамтарсан шийдвэрээр нийслэл хотын доторх муу самууныг таслан ариутгаж, ард түмнийг амгалан тайван байлгахын учир хотын 10 хашаа бүрээс шөнө тутам манаа гаргаж, лам нарыг ээлжлэн эргүүлд гаргаж байхаар болсон нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах ажлын эхлэл байсан байна. Энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг амжилттай явуулж байсан үндсэн нөхцөл нь олон түмний хүчийг түшиглэх ажлыг өргөжүүлж байсантай холбоотой юм.

1928 онд хуралдсан Улсын 56 дугаар их хурлаас Ардын цагдан сэргийлэхэд нийгмийн хэв журам сахиулах, сэргийлэн хамгаалах ажлыг эрхлүүлэхээр болсон байна. Энэ үеэр хуулийн төв, орон нутгийн байгууллагууд хууль ёсыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаа ухуулга, сурталчилгааны олон хэлбэрээр явуулах, ард олны дунд орж ажиллах явдлыг эрхэмлэж байсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ач холбогдлыг ухаарч байсны баримт юм[82].

Мөн 1945 оны 7 дугаар сард Улсын бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас Цагдан сэргийлэх байгууллагын ажлыг шалгаад, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрс сайжруулах, ард олны дэмжлэг авах, идэвхитэн нараар бүрдсэн туслах бригадыг олноор байгуулах, иргэдийн амгаланг хангах, эргүүл шалгалтыг өргөн зохиох зэрэг чиглэлтэй үүрэг өгч, түүний мөрөөр олон ажил зохион байгуулсан байна. Цагдаагийн байгууллага 1941-1946 онд улсын хэмжээнд хүний амины 3-39 хэрэг гарсны 66.6-72,2 хувийг, хулгайн 505-2046 хэргийн 50,3-61,3 хувийг, танхайн 25-347 хэргийг 100 хувь тус тус илрүүлж байсан[83] баримт бий.

1940-өөд оноос төрийн үйл хэрэгт цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагаанд иргэд өргөнөөр оролцох эхлэл тавигдаж, 1942 онд МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 41, 43-р хурлаар цагдан сэргийлэх хөдөлмөрчдийн холбоог бэхжүүлж, хөдөлмөрчдөөс төрийн хэрэгт оролцох, сайн дурын бригадыг олноор нь байгуулсан байна.

1941 оны 8-р сарын 15-ны өдөр Намын төв хороо, СНЗ-ийн 43\41-р тогтоолоор “Цагдан сэргийлэхийн ажилд туслах сайн дурын бригад”-ыг байгуулахаар шийдвэрлэн, дүрмийг нь баталжээ. Энэхүү дүрэмд “Цагдан сэргийлэхийн ажил хэрэгт туслах сайн дурын бригадыг хот суурин буюу олны цугларан оршдог газруудад байгуулахыг заахын хамт энэ бригад нь олон нийтийн хэв журмыг эвдэх явдалтай тэмцэж, хөдөлмөрчдийг хүмүүжүүлэх үүрэгтэй. Өөрсдөө боловсон байж үлгэрлэх үүрэгтэй” гэсэн байна. Сайн дурын бригадууд нь гол төлөв хот суурин газруудад байгуулагдан ажиллаж байсан бөгөөд 196О-аад оныг хүртэлх хугацаанд туршлага дутагдалтайгаас үйл ажиллагаа нь тогтмолжиж чадаагүй, зөвхөн баяр ёслолын үед

[82] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн түүхэн замнал, УБ. 2005. 13 дах тал
[83] А.Думбурай, Улсын Цагдан сэргийлэх байгууллагын түүх /1921-1980/. УБ.1995.

хэв журам сахиулах, энгийн харуул, манаа болон ариун цэврийн үзлэг шалгалтад үе үе оролцох, хууль дүрэм зөрчсөн, зохисгүй үзэгдлийн талаар цагдан сэргийлэх байгууллагад мэдэгдэх зэргээр ажиллаж байжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг өргөнөөр татан оролцуулсанаар 1949 онд ЦСБ-д туслах бригад 95, гишүүд 1280 байсан бол 1951 онд бригад 107, гишүүд 1421 болж олширчээ. Төр, засгаас дэс дараатай олон арга хэмжээ авсны үр дүнд Цагдаагийн байгууллага жилээс жилд бэхжин, 1947 онд улсын хэмжээнд гарсан гэмт хэргийн дөнгөж 50 хувийг илрүүлж байсан бол 1951 онд 74 хувь, 1954 онд 83 хувь, 1958 онд 92 хувийг нь илрүүлдэг болжээ.[84] Энэ бол улс орны хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажил жилээс жилд эрчимжиж байсны илрэл юм.

ЦСБ-д туслах олон нийтийн хүч нь 1932 онд галын аюулаас хамгаалах сайн дурын бүлгэм, 1941 оноос ЦСБ-д туслах сайн дурын бригад, 1950 оноос УАТХШБ хэлтэст орон тооны биш олон нийтийн байцаагч анх бий болж цааш өргөжин хөгжсөн түүхтэй билээ.[85]

Цагдан сэргийлэх байгууллагад туслах сайн дурын бригад нь байгуулагдсан үеэсээ эхлэн ерөнхий зорилго, чиглэл нэгтэй байсан боловч 1960 он хүртэл Сэргийлэхэд туслах сайн дурын бригад залуучуудын тавт, аравт зэрэг янз бүрийн нэртэй, бүтэц бүрэлдэхүүн нь харилцан адилгүй байжээ. МАХН-ын ТХ-оос үүнийг анхаарч үзэн, нийгмийн хэв журам сахиулах ажилд олон нийтийн хүчийг төвлөрүүлж, идэвхижүүлэн оролцуулах зорилгоор 1960 онд “Гэмт хэрэгтэй тэмцэхэд намын байгууллагуудын зорилтын тухай” гаргасан тогтоолдоо “Залуучуудын тавт аравтын ба сэргийлэхэд туслах сайн дурын бригадуудыг нэгтгэн, үйлдвэр, албан газар, сум, нэгдлийн бригадад тасгуудаас сонгогдож, сонгогчидынхоо өмнө тайлагнадаг, Цагдан сэргийлэх байгууллагад туслах хамт олны бригад болгон өөрчилсөн байна.

Бригадын гишүүдийн хүчээр цагийн эргүүл хийж, хэв журам, ариун цэврийн зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл илрүүлж, оргодол барьж, олон арван мянган хүнд хуулийн суртал, ухуулгын ажил зохиосон байжээ.

МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын СНЗөвлөл 1961 онд “Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригад байгуулах тухай” 189, 253-р тогтоол гаргаж, олон нийтийн бригадуудын ажиллах чиглэлийг тодорхойлсон дүрмийг баталсан байна.

Энэ үеэс бригадууд өөрсдийн хүчээр хөдөлмөрчдөд хууль, дүрэм сурталчлах булан байгуулж, жилийн дараа бригадын гишүүдийн тоо өмнөх оноос 30% нэмэгдсэний дээр социалист хөдөлмөрийн бригад, сэхээтний социалист нөхөрлөл, орон тооны пионерийн пост, өрхийн аж ахуйн нөхөрлөл, ахмад настан, залуу охидын зөвлөлүүд цагдан сэргийлэх байгууллагатай ажил хэргийн холбоо тогтоож, хамтран ажиллах болжээ.

МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлөөс 1961 онд "Цагдан сэргийлэх байгууллагын ажилд туслах олон нийтийн бригад байгуулах тухай" чухал тогтоол гаргаж олон нийтийн бригадын ажлын үндсэн чиглэлийг тодорхойлж дүрмийг нь шинэчлэн баталсан нь Цагдан сэргийлэх байгууллагын сэргийлэн хамгаалах албаны нэгэн чухал үүрэг нь эдгээр туслах хүчний ажлыг удирдан зохион байгуулах явдал болсон байна.[86]

---

[84] А.Думбурай. . Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. /II дэвтэр/ Уб. 1999. 32 дахь тал
[85] Мөн бүтээл. 180 дахь тал
[86] А.Думбурай. . Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. /II дэвтэр/ Уб. 1999. 41 дэх тал

1974 оны байдлаар манай улсын хэмжээгээр Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн байгууллагад 838, штаб 65, бригадын гишүүд 16000 гаруй болсон байна.

Энэ үеийн онцлог нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил зөвхөн цагдаагийн үүргийн хүрээнд явагдаж байсан байна. Үүнийг засах зорилгоор 1960 онд Намын Төв Хорооны 170 дугаар тогтоол гаргаж, хөдөлмөрчдийн дунд хууль сурталчлах олон хэлбэрийн ажил зохиох, гэмт хэрэг зөрчил гаргаж болзошгүй хүмүүстэй нэг бүрчлэн уулзаж, хүмүүжлийн ажил хийх, эргүүл шалгалтыг хүчтэй болгож, гэмт хэрэг гарч болох байдлуудыг урьдчилан илрүүлж, арилгах ажлыг нам, улс, олон нийтийн байгууулага, хөдөлмөрчдийн олон түмний тусламцаатайгаар зохион байгуулж эхэлсэн байна. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын  эрчим нээгдэж, иргэн хүний үүрэг, оролцоог,  өндөрт тавьж байсан тухайн үеийн бодлогын илэрхийлэл байв[87].

1966 оны 10-р сарын 27-ны өдөр улсын цагдан сэргийлэх байгууллагад 25-42 жилийн турш цагдаа, бага дарга, байцаагч, төлөөлөгч, анги, хэлтэс, газрын орлогч дарга зэрэг тушаалыг алба хаашиж байгаад чөлөөнд гарсан бэлтгэл хурандаа Б.Сэнгэдорж, В.Адъяа, бэлтгэл ахмад Ч.Дугарсүрэн, бэлтгэл ахлагч Ж.Данзан нарын зэрэг нэр бүхий 7 хүн харилцан зөвлөлдөж байгаад "Ахмад сэргийлэгчдийн зөвлөл" нэртэй цагдан сэргийлэх байгууллагад туслах сайн дурын байгууллагыг байгуулсан байна.[88]

Уг зөвлөл нь цагдан сэргийлэх байгууллагын залуу ажилтан офицер, сэргийлэгч, гал сөнөөгчдийг хүмүүжүүлэхэд туслах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэж, түүнээс урьдчилан сэргийлэхэд оролцох, цагдан сэргийлэх байгууллагад туслах хөдөлмөрчдийн сайн дурын байгууллагын ажилд мэргэжлийн зөвлөгөө өгөх, хүн хүчний нэмэгдэл шаардлага гарсан үед харуул хамгаалалт, хэв журам сахиулах ажлуудад биечлэн оролцох зэрэг тодорхой ажлуудыг хийж байжээ.

Цагдан сэргийлэх байгууллагаас төрийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа олон арга хэлбэрээр хэрэгжүүлж иржээ. Тухайлбал:

- Гэмт хэрэг эрх зүйн зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх; /гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүмүүсийн судалгаа гарган, нэг бүрчилсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байсан/
- Хуулийн суртал нэвтрүүлгийг өргөнөөр явуулах; /1973 оноос эхлэн хот, аймгуудад Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн үүр болон хороодын сар бүрийн хурлын дараа хууль, эрхийн сэдвүүдээр суртал нэвтрүүлгийг явуулж байсан бөгөөд 1978 оноос өргөжиж, ЦБ бусад олон нийтийн байгууллагуудтай хамтран хууль сурталчлах бригад гаргаж, сум, бригад, ферм зэрэг газруудаар явж сурталчилж байжээ/
- Хууль, эрхийн чиглэлээр радио нэвтрүүлэг явуулах; /радио болон хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслийн тусламжтайгаар хууль, эрхийн актыг сурталчлах, цуврал мэдээлэл гаргах, асуулт хариултын булан ажиллуулах, хууль эрхийн мэдээлэл хийх г.м./
- Семинар уулзалт, хичээл сургалт явуулах; /гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарсан байгууллага, хамт олонд болон бусад байгууллага хамт олны хүсэлтээр тухайн байгууллага, орон нутгийн ард иргэдийн дунд хууль сурталчлах сургалт семинарыг

[87] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн түүхэн замнал, УБ. хот, 2005 он. 14-15 дах тал
[88] А.Думбурай, Улсын Цагдан сэргийлэх байгууллагын түүх /1921-1980/. УБ.1995.

олон нийтийн байгууллагууд дангаараа болон цагдан сэргийлэх байгууллагын ажилтнуудтай хамтран явуулж байсан/

- Хуулийн самбар үзүүлэн ажиллуулж, сурталчлах; /"Иргэн-хууль зүй" самбарыг ажиллуулж, хууль тогтоомжийн эвхмэл, самбар, альбом, зурагт хуудас болон ухуулах хуудас хийж, хууль эрх зүйн бодлого таавар бодуулах зэргээр ажиллуулдаг байса/
- Гэмт хэрэг эрх зүйн зөрчилд холбогдож болзошгүй хүмүүсийг батлан дааж зөвлөгөө өгч ажиллах; /судалгаа гаргаж Үйлдвэрчний Эвлэл, Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн гишүүдээс дааж ажиллах, олон нийтийн ажилд идэвхитэй оролцуулах зэргээр ажиллаж байсан байна/
- Бахархан дуурайх үзэл төлөвшүүлэх; /Хувьсгалт тэмцлийн гавъяат зүтгэлтэн болон урлаг, спортын алдартнуудыг алдаршуулах, хүүхэд багачуудыг тэднээр бахархан, дуурайх үзэл төлөвшүүлэх зорилгоор нэрэмжит хамт олон болох, нэрэмжит сургууль болох зэргээр зорилт дэвшүүлэн ажиллаж иржээ/
- Тодорхой сэдвээр хугацаат аян зохион байгуулах; /Түүхт ой, баяр ёслолын өдрүүдийг угтаж тодорхой сэдвээр угтах аян зохион байгуулж байсан байна/
- Уриалга гаргах;
- Тусгайлсан клуб байгуулах; /сургалт сурталчилгаа явуулах, согтуурагчдыг батлан дааж ажиллах/ зэрэг үйл ажиллагаануудыг явуулж байжээ.

Цагдаагийн байгууллагаас олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж ирсэн дээрх түүхэн баримтаас үзвэл МҮЭ, МХЗЭ зэрэг хөдөлмөрчин олны байгууллага нь ЦБ-ын тогтолцооны дагуу алба, тасаг, хэлтэс, газар тус бүр дээр ажиллаж ирсний зэрэгцээ ЦБ-д туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор, сайн дурын үндсэн дээр үүсгэн байгуулагдсан олон нийтийн сайн дурын байгууллагууд ихээхэн ажиллаж байжээ. Гэхдээ олон нийтийн байгууллагууд нь иргэний нийгмийн эрх ашгийг төлөөлөх бус зөвхөн нам төрийн үзэл суртал, нийгмийн нийтлэг эрх ашгийн үүднээс үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа төрийн зохицуулалтын дор хэрэгжүүлж ирсэн.

1967 оноос бригадуудыг тэдгээрийн гишүүдийн үндсэн мэргэжлийн чиглэлээр нь төрөлжүүлсэн байна. тухайлбал:

- Хэв журам сахиулах бригад;
- Социалист өмч хамгаалах бригад;
- Эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бригад;
- Хүүхдийг хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх бригад;
- Автотээврийн хэрэгслийг арчилж хамгаалах бригад;
- Хот суурингийн гудамж, замын хөдөлгөөний дүрмийн биелэлтэд хяналт тавих бригад г.м.

Цагдан сэргийлэх болон хууль хамгаалах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт явдалтай тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд олон нийтийг өргөнөөр татан оролцуулахын тулд МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын СНЗөвлөл 1981 онд "Эрх зүйн зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд олон нийтийн оролцоог улам өргөтгөх зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргажээ. Уг тогтоолоор Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадыг НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ АРДЫН НӨХӨРЛӨЛ болгон өөрчлөн байгуулжээ.

1974 онд туслах гишүүдийн хууль сурталчлах булан 1256 ажиллаж байв. Нийслэл хотод туслах хүчний гишүүд 500-600 хүн тогтмол эргүүл шалгалтын нэгдсэн байршилтанд оролцон

ажиллаж байв. Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүд нь зан төрхийн хувьд тогтворжиж чадаагүй залуучуудыг даан авч хүмүүжүүлэх, тэд бригадаараа гавшгайч болох 5 жилийн хугацаатай үүрэг авч ажиллах зэрэг дэвшилттэй ажлын хөдөлгөөн өрнүүлж байжээ. Сүүлийн хагас жилийн дотор илрүүлсэн зөрчлийн 51,3 %-ийг бригадын гишүүдийн оролцоотой илрүүлсэн байна.

1974 онд туслах хүчнүүдээс хууль суртачлах булан кабенит 1256-г байгуулж суртчилсаны дээр хууль эрхийн сэдвээр семинар, зурагт хуудас, альбом 2000 гаруйг хийж, үдэшлэг уулзалт, гэгээрлийн хурал 1300 гаруй удаа, 131000 хүнд зохион байгуулсаны гадна хууль суртачлах баригад 80 гаруй удаа гаргаж, ажиллуулан хэвлэл, радиод олон тооны мэдээ хэвлэл бичиж, сурталчилсан нь нилээд үр дүнтэй болжээ.

1981 онд нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөл болон өргөжиж, олон нийтийн шүүх, хэв журам хамгаалах олон нийтийн төв, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн хамт олны зөвлөл, өсвөрийн сэргийлэгчдийн бүлэг, хуулийн мэргэжлээр дагнасан орон тооны бус ажилтан гэх мэт үүсэл санаачлагын байгууллага, туслах ажилтан бий болж. 1990 –ээд оны үед манай улсад 90 мянган гаруй иргэн эрх зүйн зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалахад оролцож байсан байна.

Цагдан сэргийлэх байгууллагын туслах олон нийтийн бригадын үйл ажиллагаа нь нийгмийн амьдралын олон талыг хамрах боловч доорхи үндсэн чиглэлүүдээр ажлаа явуулж байжээ. Үүнд:

1. Нийгмийн хэв журам сахиулах
2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх
3. Хүүхэд залуучуудыг хэрэг зөрчлөөс хамгаалж, тэднийг хүмүүжүүлэх
4. Гудамжны хөдөлгөөний аюулгүй байдлыг сахиулах
5. Галын аюулаас хамгаалах
6. Паспортын журмыг сахиулах
7. Нийгмийн харилцаанд хор хохирол учруулж байгаа эрхийн бусад зөрчилтэй тэмцэх зэрэг

Цагдан сэргийлэх байгууллагын туслах олон нийтийн бригадын дүрэмд зааснаар бригад, түүний гишүүд нь олон нийтийн хэв журмыг сахиулахдаа эргүүл, жижүүр хийх замуудаар гүйцэтгэнэ гэж заасан байжээ.

Цагдан сэргийлэх байгууллагын туслах олон нийтийн бригадын үйл ажиллагааны дотор хамгийн өргөн дэлгэрсэн хэлбэр бол эргүүлийн алба юм. Эргүүлийн албыг туслах бригадын гишүүдийн дотроос урьдаас төлөвлөсөн чиглэлүүдээр хэсэгчилэн явуулах бөгөөд эргүүлийг явган, морь, дугуй, мотоцикл, машин зэргийн аль нэгээр хийж болохоор тусгаж байсан байна.

Эргүүлд гарах хүмүүсийн тоо нь уул газар орон, районы нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн хүчний байдлаас шалтгаална. Тэдний явж эргэн ажилах, газрын урт нь 1-2 км-ээс ихгүй буюу 30-40 минутад эргэх боломжтой байх нь зүйтэй бөгөөд газар, районы эргүүлийн хувиарт өдөрт оруулах нь тохиромжгүй бөгөөд ашиггүй байна[89] гэж үзсэн байна.

Тухайн үед "албан үйлдвэрийн газар, цагдан сэргийлэх байгууллагын хамтран ажиллах журманд олон нийтийн байгууллагын гишүүд 7 хоногт 6-8 цагаас дээш хугацаагаар эргүүл, жижүүрийн үүргийг ажлын биш цагаар гүйцэтгэх бөгөөд түүнд цалин хөлс үл олгоно. Харин

---
[89] С.Бадарч. Цагдан сэргийлэх байгууллагад туслах хөдөлмөрчдийн сайн дурын байгууллагын гишүүдэд тусламж. УБ., 1977

зарим үед бригадын гишүүдийг ажлын цагаар ажиллуулах зайлшгүй шаардлага гарвал албан газар, байгууллагын эрх баригчидтай урьдчилан ярилцаж, ажлаас нь чөлөөлөх бөгөөд энэ хугацааны цалин хөлсийг цагдан сэргийлэх байгуулагаас гаргасан тодорхойлолтын үндсэн дээр ажлын газраас олгож байна[90] гэж заасан байна.

1921-1990 оны хооронд гэмт хэрэгтэй тэмцэх ажилд иргэд, олон нийтийн оролцоо өндөр байсан нь тухайн цаг үед нийгмийн тогтолцоо, тэр дундаа иргэдийн нийгмийн гэмт явдалтай тэмцэх сэтгэхүйн хандлага төлөвшил сайн байсантай салшгүй холбоотой байна.

Би энэхүү өгүүлэлд Өвөрхангай аймгийн цагдаагийн газраас иргэд, олон нийтийн оролцоотой ажил, арга хэмжээний талаар авч үзлээ. Тухайлбал, аймгийн хэмжээнд Хүүхдийн гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангахад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/116 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд цагдаагийн байгууллагын ахмад ажилтнуудыг татан оролцуулж ажиллуулж байгаа нь өмнөх тогтолцооны үеийн “Ахмад сэргийлэгчдийн зөвлөл” нэртэй цагдан сэргийлэх байгууллагад туслах сайн дурын байгууллагын үйл ажиллагаатай төстэй байна.

Цагдаагийн ахмад ажилтнуудыг Цагдаагийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/66 дугаартай тушаалаар томилон, хамтран ажиллах 4 талт гэрээ байгуулан, үнэмлэх, хантаазыг хүлээлгэн өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж эхэлсэн нь зохих үр дүнгээ өгч эхэлсэн байна.

Ахмад ажилтнууд Арвайхээр хүнс барааны зах, тоглоомын талбай болон хүн олноор цугларсан газруудаар хүүхэд хамгаалагчийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, амны хаалт зүүхийг 215 иргэнд, олон нийтийн газар бага насны хүүхэд дагуулж явахгүй байх талаар сануулга, сэрэмжлүүлгийг 189 иргэнд өгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион явуулсан “Хайр өвтгөддөггүй” аяны 80 ширхэг боршур, “Ковид-19” халдварт вирусээс урьдчилан сэргийлэх 80 ширхэг зурагт постер, “Сүүдэр бүү тусга” аяны 300 ширхэг зурган постер, “Яг одоо” аяны 600 ширхэг зурган постерийг иргэд, олон нийтэд ил харагдах газруудад байрлуулж, 216 иргэнд тараан ажиллажээ. Хүүхэд хамгаалагч ажилласнаар сургуулийн орчинд үйлдэгдсэн 4 гэмт хэрэг, 9 зөрчил таслан зогсоогдож, хүүхэд холбогдсон гэмт хэрэг 36.4 хувиар буурсан нь үр дүнгээ өгсөн ажил болсон нь харагдаж байна.

Аймгийн олон нийтийн цагдаа нар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын төрийн төрийн бус нийт 866 байгууллагын 9620 иргэдэд төрийн болон терийн бус 12 байгууллагатай хамтарсан уулзалт, өдөрлөг, сургалтыг зохион байгуулж, "School police”-ийн эргүүлээр ажилласан 960 эцэг, эхчүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, ерөнхий боловсролын 15 сургууль орчмын авто зам, уулзвар, гарц хэсгүүдэд тодорхой цагт давхардсан тоогоор авто эргүүлийн 152, явган эргүүллийн 214 чиглэлд цагдаагийн алба хаагчтай хамтран хяналт тавьж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд 813 ширхэг, аж ахуйн нэгж, байгууллагад 490 ширхэг санамж, сэрэмжүүлэг тараажээ. Мөн цагдаагийн алба хаагчтай хамтран 2 гэмт хэрэг илрүүлж шилжүүлэн 180 аж ахуй нэгж байгууллагад 215 албан мэдэгдэл, зөвлөмж хүргэж, 20 хэргийн газрын хамгаалалтад ажиллаж давхардсан тоогоор цагдаагийн 35 алба хаагч, 17 сууц өмчлөгчдийн холбооны гишүүд, 54 хэсгийн ахлагч, хороодын идэвхтэн, цагдаагийн 2 ахмад ажилтануудтай хамтарсан эргүүлд гарч, 13759 иргэнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулжээ.[91]

Түүнчлэн цагдаагийн байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр өдөр тутамын үйл ажиллагаа, иргэд, олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа, ажил, үйлчилгээний ил тод байдлыг хангах, албаны үйл ажиллагааг сурталчилах чиглэлээр улсын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн 5 байгууллагатай хамтран ажиллаж, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл 17, гэмт хэргээс урьдчилан

[90] Б.Шагдархорлоо, Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүд, бусад туслах хүчний гарын авлага. УБ.,1969

[91] Өвөрхангай аймгийн цагдаагийн газрын 2020 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

сэргийлэх нэвтрүүлэг 2, ярилцлага 2 сэрэмжлүүлэг 6, шторк 5, постер, контент 7 мэдээллүүдийг бэлтгэн иргэдэд давхардсан тоогоор 126 удаа хүргэж ажилласан байна.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын болон аймгийн онцгой комиссоос гарсан шийдвэр, захирамж алба хаагчдын үүрэг гүйцэтгэлт, гаргасан шийдвэрийн хэрэгжилт, илэрч буй зөрчил дутагдлыг иргэд, олон нийтэд түгээж, зөрчил дутагдалыг дахин гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр байгуулагын цахим хуудас болон орон нутгийн "GM", "Соёмбо", "Арвайхээр" телевиз, "uv.news.mn", "Өвөрхангайн мэдээ" сонин, сайтад 14 төрлийн цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, ярилцлага, тодруулга, сурвалжлага мэдээ, "Торгууль нөхөн төлөлтийн мөнгө хаана төвлөрдөг вэ?", "Онцлох алба хаагч", "Огтолсон мод орлогын эх үүсвэр биш", "Энэ миний амьдрал", "Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье", "Дараа нь золгоё доо", "Таны сонголт аль вэ?", "Яараад яахав дээ", "Ирлээ, явлаа, цэвэр" видео шторк зэргийг шууд болон эфирийн орчинд бэлтгэн түгээсэн.[92]

Аймгийн хэмжээнд иргэд, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилласан байдлыг авч үзвэл 1990 оноос өмнө гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байсан туршлагуудаас харьцангуй бага ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна.

**Дүгнэлт.** Хүн ам, олон нийтийн нэгдлийн сайн дурын нэгдлүүдийг бий болгох, тэднийг хуулиар хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлэх боломжийг бүрдүүлж өгөх нь хууль сахиулах байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцлийг арилгах, гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох ажлын зайлшгүй, үр нөлөөтэй нэгэн нөхцөл мөн.

Гэтэл өнөөдөр гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд олон нийтийн оролцоо чухал ач холбогдолтой болохыг мэддэг ч түүнийг зохион байгуулах идэвхи санаачлага дутмаг байгааг харуулж байна.

Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд зохион байгуулж буй олон нийтийн оролцоонд тулгуурласан ажил, арга хэмжээнүүдийг харвал дийлэнхи нь хуучин хэвшмэл явуулж ирсэн хэлбэрээсээ өөрчлөгдөхгүй байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

**Санал.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, 1990 оноос өмнө хэрэгжүүлж байсан зарим туршлагуудыг сэргээн нэвтрүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. "Цагдаагийн байгууллагад туслах сайн дурын нэгдэл"-үүдийг байгуулж, тодорхой баг, хороо, гудамж, талбайг хариуцуулан ажиллуулж, сар бүр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;
2. Цагдаагийн хэв журмын албанаас тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудыг /ажил эрхлээгүй байгаа/ цуглуулан "Ахмад сэргийлэгчдийн зөвлөл" нэртэй сайн дурын байгууллагыг бий болгож, хамгийн их гэмт хэрэг, зөрчил гарч байгаа газар, нутаг дэвсгэрт нийтийн эргүүл хэлбэрээр ажиллуулж, урамшуулал олгож байх;
3. Цагдаагийн эрүү болон мөрдөн байцаах албанаас тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудыг /ажил эрхлээгүй байгаа/ цуглуулан илрээгүй гэмт хэргүүд дээр ажиллуулж, зөвлөгөө өгөх, хамтарч ажиллуулах боломжийг бүрдүүлэх;
4. 100-аас дээш ажилтантай байгууллагууд дээр "Цагдаагийн байгууллагад туслах сайн дурын нэгдэл"-үүдийг байгуулж, ахлагчийг нь цалингийн 10%-ийн урамшуулалтайгаар ажиллуулах боломжийг удирдлагатай нь ярьж шийдвэрлүүлэх;

[92] Өвөрхангай аймгийн цагдаагийн газрын 2020 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

# ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Б.Бямбазаяа
*Цагдаа судлалын магистрант,*
*цагдаагийн ахмад*

**Товчлол.** Нийгмийн харилцаанд хүн бүр, өдөр тутамдаа оролцдог бөгөөд эдгээр харилцааг Улсын Их хурлаас тогтоосон хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг. Энэхүү хууль, дүрэм журмаар зохицуулж буй харилцаанд иргэн, хуулийн этгээдийг зохих хэмжээний хууль, эрх зүйн мэдлэгтэй байхыг шаарддаг. Хууль, тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог урьд авч үзэхдээ эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага гэж ерөнхийд нь ангилж гэмт хэрэгт ял оногдуулж, захиргааны зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэж байсан[93].

Цагдаагийн байгууллага 2020 онд улсын хэмжээнд 2276868 зөрчил бүртгэжээ. Энэ нь өмнөх оныхоос 101043 зөрчлөөр өссөн үзүүлэлт байгаа нь статистик тоо баримтаас харагдаж байгаа бөгөөд 2065296 зөрчлийн хэрэг нээж, 48539550.5 төгрөгийн торгууль ногдуулсан нь байна. Энэхүү өгүүллэгээр зөрчлийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэлийг харьцуулан судалж, өнөөгийн байдлыг тодруулан үзнэ.

**Түлхүүр үг.** Захиргааны зөрчил, зөрчил, шийтгэл, санкц

**Үндсэн хэсэг.** “Захиргааны хариуцлагын Монгол Улсын тухай хууль”-ийг УИХ 1992 онд батлан гаргаж, хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд уг хууль нь захиргааны зөрчил гаргасан этгээдэд нь захиргааны шийтгэл ногдуулах зарим талаар нэгтгэгдсэн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Захиргааны хариуцлагын тухай хуулийн гол ач холбогдол нь захиргааны зөрчил ба хариуцлагын талаарх нийтлэг үндэслэл, журам, захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг тогтоон, захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх ажлыг боловсронгуй болгон журамласан, түүнчлэн захиргааны эрх зүйн олон төрлийн акт үйлчилж байсныг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн эхний нэгтгэл хийгдсэн гэж зарим судлаачид дүгнэсэн нь ч бий .

Захиргааны зөрчлийн талаар эрдэмтэд судлаачид өөрийн бүтээлдээ бичиж тусгасан нь цөөнгүй бий. Тухайлбал Б.Чимид “БНМАУ-ын захиргааны эрх зүй”[94], Ж.Долгорсүрэн “Монгол Улсын захиргааны эрх зүй”[95], Д.Дашцэдэн[96], Ж.Сүхбаатар[97] нарын “Монгол Улсын Захиргааны эрх зүй”, П.Одгэрэл “Захиргааны эрх зүй”[98] гэсэн ном зохиолд тусгалаа олжээ. А.Ганбадрал, Б.Ганчулуун, Ж.Долгорсүрэн, Ш.Нарантуяа нарын “Захиргааны зөрчил” гэсэн хамтын бэсрэгхэн бүтээл дагнан гарчээ.

---

[93] Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь. Сургалтын гарын авлага
[94] Б.Чимид БНМАУ-ын захиргааны эрх зүй. Ерөнхий анги. –УБ, 1988, 285-289 дахь тал
[95] Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. –УБ, 2008
[9696] Д.Дашцэдэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. 1.-УБ, 2002, 218-236 дахь тал
[97] Ж.Сүхбаатар. Монгол Улсын захиргааны эрх зүй. –УБ, 2009, 303 дахь тал
[98] П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. –УБ, 2008, 303-308 дахь тал

Захиргааны зөрчил гэх нэр томьёоны хувьд ихэнх эрдэмтэн судлаачдын хувьд “захиргааны зөрчил” гэж нэрэлж заншсан бөгөөд харин П.Одгэрэл “захиргааны журмын зөрчил” гэж томьёолсон нь харагдана.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Захиргааны хариуцлагын тухай хууль Зөрчлийн тухай хууль болон өөрчлөгдөн, батлагдсан бөгөөд үүнтэй холбоотойгоор захиргааны зөрчил гэсэн нэр томьёо хэрэглэгдэхгүй байна. Энэхүү хоёр хуульд захиргааны зөрчил, зөрчлийг хэрхэн тодорхойлсонг харьцуулан үзье.

1. “Захиргааны хариуцлагын тухай хууль” -ийн 3 дугаар зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил гэж үзнэ[99].
2. “Зөрчлийн тухай хууль”-ийн 2 дугаар бүлгийн 2.1 дүгээр зүйлд “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” [100] гэж тодорхойлсон.

Энэхүү заалтуудыг харьцуулан үзэхэд зөрчил /захиргааны/ гэдэг нь захиргааны журам болон захиргааны хэм хэмжээ зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байна гэж заасан нь захиргааны зөрчлийн талаарх үндсэн утга санааг илэрхийлж байна. Энэ нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа биш болохыг тодотгон харуулсан байна.

Зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа чухам ямар салбарт хамаарах талаар Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотой онолын нилээдгүй маргаан гарч захиргааны процесс, эсхүл эрүүгийн эрх зүйн харилцаанд хамаарах талаар эрдэмтэн, судлаачид харилцан адилгүй байр сууртай байдаг. Цаашид зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэлбэрийн эрх зүйн ямар зөрчлийн хүрээнд авч үзэх, түүнд хүлээлгэх хариуцлагыг хууль зүйн ямар хариуцлага гэж нэрлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Судлаач би эрх зүйн зөрчлийн талаарх онолын зарим маргаантай асуудлыг хөндөж, практикт тулгамдаж буй асуудлыг тодруулах, “захиргааны хариуцлагын тухай хууль”, “зөрчлийн тухай хууль”-д заасан захиргааны зөрчлийг харьцуулан судалж хууль тогтоомжийн зарим нэр томьёоны талаар санал дэвшүүлэн хэлэлцүүлэхээр илтгэлээ бичлээ.

**Нэг.** Зөрчлийн тухай товчхон. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь чухам ямар салбарт хамаарах талаар судлаачид хоёр өөр үзэл баримтлалыг илэрхийлдэг. Энэ нь онолын хувьд нэлээдгүй маргаантай байгаа бөгөөд захиргааны процесс, эсхүл эрүүгийн эрх зүйн харилцаанд хамаарах талаар судлаачид байр сууриа илэрхийлж байсан. Тухайлбал “зөрчлийн тухай хуулийн төсөл” нь гэмт хэргийн тухай хуультай нэгтгэхээр үзэл баримтлалтай байсан боловч дангаар батлагдсан.

Эрх зүйн зөрчлийг гэмт хэрэг, захиргааны зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил, олон улсын эрх зүйн зөрчил гэж ангилсан байх бөгөөд энэ ангилалтыг нь хууль зүйн судлаачдын бүтээлүүдээс харж болно. Энэ нь эрх зүйн салбарын шинжээр нь ангилсан бөгөөд мөн нийгмийн хор аюулын шинжээс нь хамаарч гэмт хэрэг ба гэмт хэргийн бус эрх зүйн зөрчил гэж тус тус ангилсан нь бий .

---

[99] Төрийн мэдээлэл. 1992. №26. Захиргааны хариуцлагын тухай хууль. он.
[100] Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль.

Эрх зүйн зөрчлийн үндсэн шинж нь бүрэлдэхүүний тухай асуудал юм. Эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүн гэж эрх зүйн зөрчлийн гадаад, дотоод шинж тэмдгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тухайн субъектын үйл ажилгаа эрх зүйн зөрчил болохыг тогтоож буй зайлашгүй шаардлагатай шинжүүдийн нийлбэр юм .Эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүн бол тухайн зөрчлийн зайлшгүй байх шинж, нөхцлийг тодорхойлж буй үндсэн шалгуур болдог.

Эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүнийг

- органик бүрэлдэхүүн
- Функцианал бүрэлдэхүүн гэж ангилдаг .

Функцианал бүрэлдэхүүнд эрх зүйн зөрчлийн эхэлсэн, өрнөсөн, дууссан үйл явц, цаг хугацаа, орон зай, үйлдлийн зайлшгүй харгалзах процессын бусад нахцөл байдлыг оруулж тооцно. Органик бүрэлдэхүүнд объект, субъект, объектив тал, субъектив тал гэж ангилна .

Эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүний талаар судлаачдын дунд эргэлзээтэй, онолын маргаантай асуудал өрнөсөөр байна. Тухайлбал, “Эрүүгийн хууль”-ийн үзэл баримтлалд “гэмт хэргийн бүрэлдэхүүн гэсэн ойлголтыг гэмт хэргийн шинж гэж томъёолон хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх, гэмт хэргийн шинжийг тодорхойлох, тайлбарлахад энэ хууль, бусад хуулиар тогтоосон нэр томъёо, зүйл, хэсэг, заалтыг хэрэглэх, шаардлагатай тохиолдолд хуулиар тусгайлан эрх олгож хэм хэмжээ тогтоосон актыг үнэлж, хэрэглэж болох талаар тусгана” гэж тодорхойлсон талаар судлаачид гэмт хэргийн бүрэлдэхүүн талаарх ойлголт байхгүй мэтээр тайлбарлаж байна.

Зөрчлийн талаарх тодорхойлолтоос ч зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг харж болно. Тухайлбал “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн” гэсэн нь зөрчил үйлдсэн этгээдийн субьектив санаа бодлыг шууд илэрхийлж байгаа бөгөөд “...үйлдэл эс үйлдэхүй” нь захиргааны зөрчлийн объектив болон субъектив шинжүүдийн нийлбэр юм. Ийнхүү судлаачид эрх зүйн зөрчлийг гэмт хэргийн болон гэмт хэргийн бус гэж ангилсан ч захиргааны зөрчил нь “эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ”-гээр бус захиргааны эрх зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой үйлдэл эс үйлдэхүй юм.

**Хоёр.** Зөрчилд хариуцлага хүлээлгэж буй хууль тогтоомжийн өнөөгийн байдал. Зөрчлийн тухай хууль батлагдахаас өмнө 1992 онд батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хууль, хууль тогтоомжийн актаар захиргааны зөрчлийг зохицуулж ирсэн билээ.

Монгол Улсын “Захиргааны хариуцлагын тухай хууль” нь 2 бүлэг, 54 зүйлээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл бүхий заалтууд, хоёрдугаар бүлэгт захиргааны зарим зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг нэгтгэх байдлаар тусгажээ. Мөн энэ хуулиас гадна 220 гаруй хуулиар шийтгэл /захиргааны/ ногдуулж байсан байна.

Монгол Улсад зөрчилтэй холбоотой асуудлыг энэхүү Захиргааны хариуцлагын тухай хуулиар бүрэн зохицуулж чадаагүй, хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал бий болгосон зэрэг нь иргэдийн дунд хууль сахиулагч, шүүгчийн гаргасан шийдвэрийг хууль бус гэж хардах, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх, гэмт хэрэгтэнд ял завшуулдаг гэж дүгнэгдсэн тул Зөрчлийн тухай хуулийг Гэмт хэргийн тухай хуультай уялдуулан гаргах гол үндэслэл болсон.

“Захиргааны хариуцлагын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийг харьцуулан судалж зарим зарчмийн шинжтэй өөрчлөлтийг дурьдая. Тухайлбал, захиргааны шийтгэлийн

хувьд торгох, эрх хасах, баривчлах, хууль бусаар олсон эд зүйл хураах гэсэн төрөлтэй байсан бол зөрчлийн тухай хууль нь торгох , эрх хасах, баривчлах гэсэн 3 шийтгэлтэй болсон байна.

Мөн захиргааны хариуцлагын тухай хуульд тусгайлан олгосон эрх хасах шийтгэлийг зургаан сараас хоёр жилийн хугцаатайгаар хасах байсан бол, зөрчлийн тухай хуульд эрх хасах шийтгэлийг гурван сараас хоёр жил хүртэл хугцаагаар хасна гэж заасан байна.

Захиргааны хариуцлагийн тухай хуульд иргэнийг 100-50000, албан тушаалтныг 1000 бол зөрчлийн тухай хуульд торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.байна.

Энд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Түүнчлэн эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох шийтгэлийг хоёр жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж өгсөн байна. Захиргааны хариуцлагийн тухай хуульд зөрчил гаргасан этгээдэд 11 төрлийн субъект хариуцлага хүлээлгэж байсан бол Зөрчил шалан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар тодорхой дурьдаж заасан байна.

**Гурав.** Тодорхой зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь. Зөрчлийн тухай хуульд 13 төрлийн зөрчил, 208 зөрчлийг тусгасан бөгөөд нилээдгүй өргөн зохицуулалт бүхий хууль болон батлагдсан.

| Зөрчлийн тухай хууль | Захиргааны хариуцлагын тухай |
|---|---|
| 1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго 1. Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино. | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. |

Гэмт хэрэг, зөрчлийг ялгаж заагласан үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь хоорондоо уялдаагүйгээс нэг бол эрүүгийн хариуцлага хэмээн ял шийтгэх нэг бол захиргааны хариуцлага хэмээн батлагдсан хууль болгонд торгох шийтгэл тусгаж ирсэнийг хууль зүйн нэгдсэн бодлогоор цэгцэлж Зөрчлийн тухай хуулийг хууль тогтоогчоос батлан гаргажээ. Түүнчлэн урьд нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан зарим гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хуульд заасан захиргааны зарим зөрчил нь ижил, төстэй байсан бөгөөд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх бэрхшээлийг шийдвэрлэсэн.

Өөрөөр хэлбэл, бусдын өмч хөрөнгөнд халдсан нийгмийн хор аюул багатай үйлдэл, нийгмийн хэв журам зөрчсөн, нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан үйлдэл, түүнчлэн дүрэм, журам, норм, стандарт зөрчсөн, эсхүл тодорхой нэрлэн заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үзэхээр зохицуулалт хийсэн.

Энэхүү хэсэгт “замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил”-ийн талаар “Захиргааны хариуцлагын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийн холбогдох зүйл, заалтыг харьцуулан судлана.

Монгол Улсын “Захиргааны хариуцлагын тухай хууль” -ийн 25 дугаар зүйлд “замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил”-ийн талаар заасан бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор өөрчлөгдөн мөрдөгдөж байсан бөгөөд Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн нэг-д согтууруулах ундааны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан, эсхүл согтууруулах ундааны зүйл уусан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл хугцаагаар хасах шийтгэл ноогдуулна гэж заасан байдаг.

ЗХТХ-н 25дугаар зүйлийн хоёр-д тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон бол 25000-50000төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

Эдгээр зөрчлийг хор уршиг учраагүй байсан ч хууль тогтоомжинд заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан байсан. Харин мөн хуулийн 25.5-д дурьдсан жолооч тээврийн байгууллагын ажилтан хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэл ногдуулахаар тус тус заасан.

Дээрхи “Захиргааны хариуцлагын тухай хууль”-д заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчилд торгох, баривчлах, тээврийн хэрэгсэл хасах шийтгэл ногдуулж байв.

“Зөрчлийн тухай хууль”-ийн арван дөрөвдүгээр бүлэгт “тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил” -ийн талаар заагаад 8 хэсэгт хуваан зохицуулсан байна. Үүний 14.1 дүгээр зүйлд “авто замын тухай хууль зөрчих”, 14.2 дугаар зүйл “авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах”, 14.3 дугаар зүйл “автотээврийн тухай хууль зөрчих”, 14.4 дүгээр зүйл “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих”, 14.5 дугаар зүйл “жолоочийн даатгалын тухай хууль зөрчих”, 14.6 дугаар зүйл “улсын нисэхийн тухай”, “иргэний нисэхийн тухай хууль зөрчих”, 14.7 дугаар зүйл “агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль зөрчих”, 14.8 дугаар зүйл “төмөр замын тээврийн тухай хууль зөрчих” гэж тус тус зохицуулсан. Уг хуулийн 14.4-т “замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил”-ийн талаар заасан бөгөөд 56 зүйл бүхий зөрчлүүдийг тусгасан байна. Үүнээс 14.4.3-т “жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, мөн зүйлийн 5-т “тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол хүнийг таван зуун нэгжтэй нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” [101] гэж тус тус заасан. Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл:

1. Торгох шийтгэлийн санкц нэмэгдсэн байна. Тухайлбал согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон үед “Захиргааны хариуцлагын тухай хууль”-аар бол 250000 төгрөг, “замын

[101] Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-аар нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, “зөрчлийн тухай хууль”-аар бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан нь торгуулийн хэмжээг нэмэгдсэнг харуулж байна.

2. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5-д “тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна” гэж заасан нь дээрх зөрчлөөс хөнгөдсөн гэж үзэхээр байна.

3. “Зөрчлийн тухай хууль”-д заасан нэр томьёоны хувьд жишээлбэл уг хуулийн 3.3-т “Шийтгэл хүлээх хүн...”, 3.4.2-т “Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна” гэснээс харахад “хүн”, “нэгж” гэсэн нэр томьёо шинээр гарч байна. Хууль зүйн шинжлэх ухаанд иргэний эрх зүйн чадвар, чадамжийн тухай ойлголтыг “иргэний эрх зүй”-д голчлон тайлбарласан нь бий. Тухайлбал иргэнийг “Монгол Улсын иргэн”, “гадаадын иргэн”, “харьяалалгүй хүн” гэж хуваан авч үздэг . Хүн гэдэг нь бодгаль ойлголт юм.

**Дүгнэлт.** Захиргааны зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад 220 гаруй хууль тогтоомжид заасан байсан зөрчлүүдийг нэгтгэж, Зөрчлийн тухай хуулиар зохицуулсан бөгөөд шинээр зарим төрлийн зөрчлүүдийг нэмж тусгасан нь ажиглагдлаа. Мөн Захиргааны хариуцлагын тухай хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтад гэмт хэрэг, захиргааны зөрчлийг ялгааг “...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол...” гэсэн шинжээр зааглаж ирсэн уламжлалыг хэвээр авч үлдсэн. Иймд дээр дурдсан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэсэн нь гэмт хэрэг, зөрчлийг обьектив, субьектив шинжээр, эсхүл тодорхой хохирол, хор уршиг учруулсан мөнгөн дүнгээр ялган зааглсан нь зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдтэй зарим төрлийн маргаан гарах боломжгүй нь харагдаж байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулиар материаллаг болон процессын хэлбэртэй хуульчлан зохицуулсан байсныг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болгон салгаж зохицуулсан нь зүйтэй байна.

**Санал.**

1. Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангид "захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдэл”-д хамаарах Захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг нэг бүрчлэн заах;
2. Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулахаар заасан буюу захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдэлд хамаарах тухайн актуудыг "Зөрчлийн тухай хуулийн эх сурвалж”-д зааж өгөх

Эх сурвалжийн жагсаалт


1. Захиргааны хариуцлагын тухай хууль. 1992 он.
2. Зөрчлийн тухай хууль 2017 он.
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 он.
4. Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь. Сургалтын гарын авлага
5. Б.Чимид БНМАУ-ын захиргааны эрх зүй. Ерөнхий анги. –УБ, 1988.
6. Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. –УБ, 2008
7. Д.Дашцэдэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. 1.-УБ, 2002.
8. Ж.Сүхбаатар. Монгол Улсын захиргааны эрх зүй. –УБ, 2009.
9. П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. –УБ, 2008.
10. Д.Булган. Захиргааны шийтгэлийн онол, практикийн үндсэн асуудал. УБ., 2011.

# ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ТААМАГЛАЛ АШИГЛАХ НЬ

М.Хүрэлбаатар
*Цагдаа судлалын магистрант,*
*цагдаагийн ахмад*

**Удиртгал.** Урьдчилан таамаглах гэдэг нь дүн шинжилгээ хийх, ялангуяа тоон арга техникийг ашиглах явдал юм. Гэмт хэргийн түвшинг урьдчилан таамаглахын тулд статистик, газарзүйн анализыг ашиглах нь хэдэн арван жилийн туршид хэрэгжиж ирсэн. Сүүлийн жилүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг урьдчилан таамаглах маш том мэдээллийн багц дээр тулгуурласан шинжилгээний хэрэгслийг ашиглах нь эрс нэмэгдсэн.

Хууль сахиулах байгууллагын ижил төстэй олон харилцааг цагдаа урьдчилан таамаглахаар судалж болно. Цагдаагийн байгууллага нь урьд өмнө үйлдэгдсэн гэмт хэрэг, орон нутгийн орчин, бусад холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийж урьдчилан таамаглал гаргах бөгөөд түүнийгээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг. Үүний зорилго нь тактикийн болон стратегийн түвшинд нөхцөл байдлын мэдлэгийг дээшлүүлэх, цагдаа нарын ажлыг илүү оновчтой, үр дүнтэй болгох стратеги боловсруулах явдал юм.[102]

Нөхцөл байдлын талаарх мэдлэг, хүний зан авирыг урьдчилан таамаглахад цагдаа нар давтан хохирогчдын эсрэг давтан гэмт хэрэг үйлдэх гэмт хэргийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх стратеги тодорхойлох, боловсруулах боломжтой. Эдгээр аргууд нь цагдаагийн хэлтсүүдийн алба хаагчдыг илүү санаачлагатай ажиллах боломжийг олгодог бөгөөд цагдаагийн стратегийг үр дүнтэй гэж үзэхийн тулд бодит үр дүнд хүргэх ёстой. Жишээлбэл; Гэмт хэргийн гаралт буурч, ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг баривчлах арга хэмжээ нэмэгдэж үүний үр дүнд ажиглагдахуйц эерэг нөлөө нийгэмд үзүүлэх ёстой.

**Түлхүүр үг.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, таамаглал, гэмт хэрэг

**Үндсэн хэсэг.** Цагдаагийн байгууллагын урьдчилан таамаглах криминологийн үндэслэл: Гэмт хэргийг яагаад "урьдчилан таамаглах" боломжтой вэ?

Гэмт хэрэгтнүүд өөрсдийн таатай бүсэд гэмт хэрэг үйлддэг учраас гэмт хэргийг урьдчилан таамаглах боломжтой гэсэн онолыг батлах нотолгоо байдаг. Өөрөөр хэлбэл, тэд урьд өмнө нь амжилттай үйлдсэн гэмт хэрэгтэй ерөнхийдөө ижил цаг хугацаа, байршилд ойрхон гэмт хэрэг үйлдэх хандлагатай байдаг. Хэдийгээр энэ нь түгээмэл биш боловч эдгээр аргуудыг боломжийн ажиллуулах хангалттай давтамжтайгаар тохиолддог.[103]

- Гэмт хэрэгтнүүд, хохирогчид нийтлэг амьдралын хэв маягийг дагаж мөрддөг;
- Газарзүйн болон цаг хугацааны онцлог шинж чанарууд нь эдгээр загвар хаана, хэзээ болоход нөлөөлдөг;
- Эдгээр хэв маягийн хүрээнд шилжихдээ гэмт хэрэгтнүүд газар нутаг, зорилтот байдал, баригдах эрсдэл зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэж гэмт хэрэг үйлдэх эсэх талаар "оновчтой" шийдвэр гаргадаг.

Цагдаагийн байгууллагын урьдчилсан таамаглалын онолын үндэс нь олон зүй тогтол, хүчин зүйлийг аналитик аргаар тодорхойлж, дараа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тактикийн оролцоотойгоор гэмт хэрэгтнүүдийн шийдвэрийг урьдчилан таамаглахад оршино.

[102] “What Is Predictive Policing?” WP’s Police Tech, March 16, 2012.
[103] Barocas, S. and Selbst, A.D., 2016. Big Data’s disparate impact. California law review, 104, 671

Цагдаагийн байгууллагын урьдчилан таамаглах шинж чанар нь гэмт хэрэг үйлдсэний дараа зөвхөн гэмт хэрэгтнүүдийг баривчлахаас гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой байх нь тодорхой юм.

Хууль сахиулах байгууллагуудын хувьд гэмт хэргийг урьдчилан таамаглах, түүнийг үйлдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нь үндсэн чиг үүрэгт хамааралтай.[104] Урьдчилан таамаглах аргууд нь өөрсдөө сэжиглэгдэж буй гэмт этгээдийг баривчлах хангалттай магадлалтай шалтгааныг ил гаргахгүй байж магадгүй юм.[105] "Урьдчилан таамаглал" нь хамгийн сайн тооцоог гаргадаг статистик тооцоогоор илэрхийлэгдэнэ. Ингэхдээ өнгөрсөн дээр үндэслэн ирээдүйг экстраполяц хийдэг.

Урьдчилан таамаглах аргуудын ангилал зүйн хувьд авч үзвэл цагдаагийн байгууллагын урьдчилсан таамаглалд үнэлгээ өгөхдөө урьдчилан таамаглах аргыг дөрвөн өргөн ангилалд хуваадаг.

1. Гэмт хэргийг урьдчилан таамаглах аргууд: Эдгээр нь гэмт хэргийн эрсдэл ихэссэн газар, цаг хугацааг урьдчилан таамаглахад ашигладаг хандлага юм.

2. Гэмт хэрэгтнийг урьдчилан таамаглах аргууд: Эдгээр хандлага нь ирээдүйд гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлдог.

3. Гэмт хэрэгтнүүдийн хэн болохыг урьдчилан таамаглах аргууд: Эдгээр аргыг урьд өмнө үйлдсэн тодорхой гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэмт хэрэгтнүүдтэй нарийвчлан тохируулсан профайл үүсгэхэд ашигладаг.

4. Гэмт хэргийн хохирогчийг урьдчилан таамаглах аргууд: Гэмт хэрэгтнүүд, гэмт хэрэг үйлдэгдсэн газар, эрсдлийн өндөр үе зэрэгт анхаарлаа хандуулдаг аргуудын нэгэн адил эдгээр хандлагыг гэмт хэргийн хохирогч болж болзошгүй бүлэг эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүсийг тодорхойлоход ашигладаг.

*Цагдаагийн байгууллагын таамаглал дэвшүүлэх үйл явц:*




Эхний хоёр алхам бол урьдчилан таамаглахын тулд гэмт хэрэг, хэрэг, зөрчлийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх явдал юм. Олон нийтийн янз бүрийн эх сурвалжаас авсан өгөгдөл нь зарим төрлийн мэдээллийг нэгтгэхийг шаарддаг. Эдгээр өгөгдлийг нэгтгэхэд амар, хялбар байдаг. Сүүлийн хоёр алхам нь таамаглалд хариу өгөхөд анхаарлаа төвлөрүүлдэг. Цагдаагийн албан хаагчид урьдчилсан таамаглалыг ашиглан хариуг нь мэдээлж, дараа нь нотолгоонд суурилсан хандлагыг

[104] Ditchley Foundation. Conference on intelligence, security and privacy, 14–16 May 2015, Ditchley Park, UK. Available from: http://www.ditchley.co.uk/conferences/past-programme/2010-2019/2015/intelligence [Accessed 8 February 2016].
[105] We take up the issues of privacy and civil rights in Chapter Three.

ашиглан хариу өгдөг.[106] Гэмт хэрэгтнүүд өөрчлөгдсөн орчинд хариу үйлдэл үзүүлдэг. Зарим нь хүрээлэн буй орчноо орхиж, гэмт хэрэг үйлдэх дадал зуршлаа өөрчилж эсвэл өөр газар руу шилждэг. Хариуцлагаас үл хамааран хүрээлэн буй орчныг өөрчилөх бөгөөд анхны өгөгдөл хуучирсан тохиолдолд шинэ өгөгдөл цуглуулж дүн шинжилгээ хийх шаардлагатай болно.

Өгөгдөл цуглуулахад урьдчилан таамаглах бүх арга техник нь өгөгдлөөс хамаарна. Эдгээр өгөгдлийн хэмжээ, чанар хоёулаа ач холбогдолтой мэдээллийг дөхүүлэн тодорхойлдог. Өгөгдөл үнэн зөв, бүрэн дүүрэн байхын тулд нягт, нямбай, нарийн гаргах хэрэгтэй.

Мэдээллийн багцыг одоогийн байдал, интервенцийн үр нөлөөг тусгасан эсэхийг баталгаажуулахын тулд үе үе шинэчлэх шаардлага үүсдэг. Мэргэжлийн шинжээч, судлаачид урьдчилан таамаглах цагдаагийн ажилд маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хуучин өгөгдөлтэй байсан ч хүчтэй аналитик хийхгүй бол хүсээгүй үр дүнд хүргэж болзошгүй юм. Мэдээлэл нэгтгэхэд ихэнх гэмт хэргийн мэдээллийг цагдаагийн хэлтсүүдийн хэвийн үйл ажиллагааны явцад цуглуулах магадлалтай боловч хүрээлэн буй орчныг дүрсэлсэн мэдээллийг бусад олон эх сурвалжаас олж авах боломжтой. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явцын хүрээнд шинжээчид харилцан адилгүй мэдээллийн эх сурвалжуудыг нэгтгэх чадвартай байх ёстой.

Мэдээллийг нэгтгэх хэд хэдэн арга байдаг бөгөөд ойролцоо зургийг санал болгодог маш энгийн аргуудаас авахуулаад (заримдаа эвристик шийдэл гэж нэрлэдэг) мэдээллийг нэгтгэх боломжийг олгодог илүү боловсронгуй аргууд байдаг. Ерөнхийдөө хэлтэсүүд нь хоорондоо ялгаатай эх сурвалжаас авсан өгөгдлийг нэгтгэн өндөр эрсдэлтэй газар, хувь хүмүүс, бүлгүүдийн эв нэгдэлтэй дүр төрхийг бүрдүүлэх албан ёсны дүрмийг боловсруулсан байдаг талаар судлан үзэхэд мэдээллүүд төдийлөн сайн олдоогүй юм.

Шинжилгээ хийхэд гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан таамаглах анализын янз бүрийн аргуудыг онцолж тухайн аргуудыг харилцан хамааралгүй гэж үзэж болохгүй. Үнэн хэрэгтээ олон арга техникийн хэсгүүдийг тэдгээрийн нийлбэрээс илүү ихийг хангахын тулд ашиглаж болно.

Боломжит өгөгдлийн багцыг судлахын тулд регресс ба өгөгдөл олборлох арга техникийг ашигласнаар тухайн бүс нутгийн онцлог шинжтэй гэмт хэргийн хэв шинжийг олж мэдэх боломжтой. Энэхүү хайгуулын дүн шинжилгээнд тодорхойлсон чиг хандлага нь дараа нь халуун цэгүүдийг тодорхойлох аргын загварыг мэдээлнэ.[107] Жишээлбэл; Эдгээр аргууд нь гэмт хэргийн хэлбэрийг хайхаас хэр хол эсэх эсвэл дүн шинжилгээнд хамрагдах ёстой улирлын, долоо хоногийн чиг хандлага байгаа эсэхийг хэлж өгдөг. Бүлэглэх техникээс үндэслэсэн газарзүйн профайл нь цуврал гэмт хэрэгтнийг харуулсан хэв шинжийг илрүүлж чаддаг.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамгийн сайн дүн шинжилгээ хийсэн ч нөлөөлөхгүй бол гэмт хэргийн гаралтад нөлөөлөх зүйлгүй. Халуун цэг гэж тогтоогдсон байршилд эргүүлд нэмэлт анхаарал хандуулах, цохиулсан алба хаагчдыг үе үе очиж уулзах, эсвэл гарч буй гэмт хэргийн төрөлд тохирсон бусад хариу арга хэмжээ авах шаардлагатай.[108]

*Ерөнхий хөндлөнгийн оролцоо:* Эрсдэл нэмэгдсэнтэй холбогдуулан илүү их нөөцийг хуваарилах. Халуун цэгүүдийн хувьд энэ нь илүү олон албан хаагч хуваарилж болно гэсэн үг юм; "халуухан хүмүүсийн" хувьд энэ нь тэнсэн харгалзах, тэнсэн харгалзах ажилтнуудтай илүү холбоо тогтооно гэсэн үг юм.

*Гэмт хэргийн талаархи хөндлөнгийн оролцоо:* Хүлээгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэхэд тохирсон нөөцийг хуваарилах. Нөөц ба хөндлөнгийн оролцоо нь тухайн халуун цэг эсвэл гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй тодорхой хүн дээр төвлөрч болно.

---

[106] Friend, Z., 2013. Predictive policing: Using technology to reduce crime [online]. FBI Law Enforcement Bulletin. Available from: https://leb.fbi.gov/2013/april/predictive-policing-using-technology-to-reduce-crime [Accessed 2 February 2016].
[107] Braga et al.(2012, pp. 655–656)
[108] See Perry et al. (2013, p. 121, fn 5) quoting Ridgeway (2013).

*Асуудлын онцлог арга хэмжээ*: Гэмт хэргийн эрсдэлийг үүсгэж буй байршил, хүн ам, эсвэл хүний онцлог шинж чанарыг тодорхойлох, тэдгээрийг арилгах. Энэ түвшинд бараг тодорхойлолтын дагуу тодорхой гэмт хэргийг мөрдөн байцаах, шийдвэрлэх арга хэмжээ багтана.

*Интервенцийн арга*




*Хамгийн энгийнээс хамгийн төвөгтэй болгон зохион байгуулалттай (дээрээс доош) гурван төрлийн хөндлөнгийн оролцоог харуулав. Ерөнхийдөө бид илүү төвөгтэй арга хэмжээ авахад илүү их нөөц шаардагдах болович бодит гэмт хэргийн асуудалд илүү сайн нийцүүлж, илүү сайн үр дүнд хүрэх болно гэж таамаглаж байна.*

Хариу арга хэмжээг цагдаа нар интервенц хийсний дараа зарим гэмт хэрэгтнүүдийг баривчилж гудамжнаас зайлуулж магадгүй юм. Бусад нь цагдаа нарын оролцоотойгоор гэмт хэрэг үйлдэхээ зогсоох, гэмт хэрэг үйлдсэн газраа өөрчлөх, гэмт хэрэг үйлдэх арга барилаа өөрчлөхийг сонгож болно. Тиймээс халуун цэгийн аюулын зэрэг буурч зарим гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа өөр газар, байрлалд шилжих болно. Эдгээр өөрчлөлтүүд нь анхны өгөгдлийн багцыг хуучирсанд шилжүүлдэг. Ийнхүү мөчлөг дахин шинэ өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хөндлөнгөөс оролцохоос эхлэнэ.

Гэмт хэргийн эрсдлийг урьдчилан таамаглах арга техникийг халуун цэгийн шинжилгээ, регрессийн арга, өгөгдөл олборлох арга техник, давтагдах шахсан аргууд, орон зайн цаг үеийн шинжилгээ, газар нутгийн эрсдлийн шинжилгээ гэсэн зургаан ангиллын дагуу зохион байгуулдаг бөгөөд эдгээр ангилалд багтсан бүх техник нь ерөнхийдөө харьцуулж үзэх юм бол ирээдүйн гэмт хэргүүдийн цаг хугацаа, газрыг урьдчилан таамаглахад бүгдийг нь ямар нэгэн байдлаар ашиглахад ашигладаг бөгөөд бүгд түүхэн гэмт хэргийн мэдээллээс хамаардаг. Техникийг дараах байдлаар ангилна.[109] Тухайлбал;

- Сонгодог статистикийн аргууд: Энэ ангид регрессийн ихэнх хэлбэр, өгөгдөл олборлолт, цаг хугацааны цуврал дүн шинжилгээ, улирлын тохируулга зэрэг стандарт статистик процессууд орно.
- Энгийн аргууд: Энгийн аргууд нь нарийн тооцоолох, их хэмжээний мэдээлэл авахад тийм ч их шаарддаггүй. Жишээлбэл, ихэнх эвристик аргууд нь энгийн аргууд бөгөөд том мэдээллийн багцад дүн шинжилгээ хийхээс илүүтэйгээр шалгах хуудас, индекс дээр тулгуурладаг.
- Цогцолбор програмууд: Эдгээр програмууд нь тооцооллын нарийн төвөгтэй хэрэгслүүдээс гадна нэлээд их хэмжээний мэдээлэл шаарддаг шинэ, шинэлэг арга буюу аргуудыг агуулдаг. Олон шинэ өгөгдөл олборлох аргууд болон бараг давтагдах аргууд энэ ангид багтдаг.
- Зориулалтын аргууд: Энд судлагдсан хэд хэдэн тохиолдолд одоо байгаа техникийг урьдчилан таамаглах цагдааг дэмжихэд дасан зохицсон болно. Жишээлбэл, дулааны газрын зургийг гаргахдаа статистикийн сонгодог аргыг ашиглаж тухайн газар нутагт гэмт хэргийн үйл ажиллагааны эрч хүчийг харуулсан энгийн, өнгөөр ялгасан торыг гаргаж болно.

[109] Weisburd, D., et al., 2016. Do stop, question, and frisk practices deter crime? Evidence at microunits of space and time. Criminology & public policy, 15 (1), 31–56.

Ямар төрлийн хөндлөнгийн оролцоог сонгосон нь хамаагүй урьдчилан таамаглал, урьдчилсан мэдээг дэмжсэн өгөгдлийн аль ч талаар хууль сахиулах байгууллагын ажилтнуудад тохирсон мэдээлэл өгөх шаардлагатай. Үүний сүүлийн жишээ нь сүүлийн үед гарсан гэмт хэргийн байршил, тодорхойлолт, томоохон дуудлагын байршил, тодорхойлолт, гэмт хэрэг сонирхогчдын байршил, тухайн газар сонирхож буй хүмүүсийн тайлан, сүүлийн үеийн газар дээр хийсэн ярилцлагын тайлангууд байж болно. Албан хаагчдад асуудалд хариу өгөхөд энэ мэдээлэл хэрэгтэй болдог. Гэсэн хэдий ч нотолгоонд суурилсан хөндлөнгийн оролцооны талаар ярилцаж, идэвхтэй арга хэмжээ авах үндэс суурийг нь тавьж өгдөг.

**Дүгнэлт.** Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ тухайн гэмт хэргийг урьдчилан таамаглах тухай ойлголт, төрөл, түүнийг ангилах арга зүй болон техникийн байдал, хөндлөнгийн оролцооны талаар судаллаа. Энэхүү өгүүллийн зорилго бол цагдаагийн байгууллага гэмт хэргийг урьдчилан таамаглах хийж түүнийгээ үйл ажиллагаандаа ашиглах нь зөв, буруугийн талаар биш юм. Харин урьдчилан таамаглах тухай ойлгох, түүнийг хэрхэн хийж байгааг талаар мэдлэг, мэдээлэл солилцох, улмаар хийх боломжийг эрэлхийллээ.

Урьдчилан таамагласан цагдаа нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор өгөгдлийн шинжлэх ухааны хөгжлийн хөгжилтийг хөшүүрэг болгох боломжтой хэрэгслээр хангадаг. Гэхдээ энэ нь эцсийн эцэст хүмүүс програм хангамжид суулгасан хязгаарлалт, таамаглалыг ойлгож, үр ашиггүй, шударга бус үр дүн гарахаас зайлсхийхээс хамаарна.

Нийгмийн хувьд бид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн албан хаагчдыг үр дүнтэй ажиллуулах сонирхолтой боловч хууль сахиулах стратеги, түүний дотор хэрхэн үр дүнтэй, оновчтой нэвтрүүлэх, ашиглахад анхаарч ажиллах нь зүйтэйг илэрхийлэхийн тулд ойлголцол, туршилт, засаглал шаардагдана.

**Санал**

1. Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглах талаар өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;
2. Цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа таамаглал дэвшүүлэн ашиглах нөхцөл байдлыг судалж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд таамаглал ашиглах нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

**Ашигласан эх сурвалжийн жагсаалт:**


1. “What Is Predictive Policing?” WP’s Police Tech, March 16, 2012.
2. Barocas, S. and Selbst, A.D., 2016. Big Data’s disparate impact. California law review, 104, 671
3. Ditchley Foundation. Conference on intelligence, security and privacy, 14–16 May 2015, Ditchley Park, UK. Available from: http://www.ditchley.co.uk/conferences/past-programme/2010-2019/2015/intelligence [Accessed 8 February 2016].
4. We take up the issues of privacy and civil rights in Chapter Three.
5. Friend, Z., 2013. Predictive policing: Using technology to reduce crime [online]. FBI Law Enforcement Bulletin. Available from: https://leb.fbi.gov/2013/april/predictive-policing-using-technology-to-reduce-crime [Accessed 2 February 2016].
6. Braga et al.(2012, pp. 655–656)
7. See Perry et al. (2013, p. 121, fn 5) quoting Ridgeway (2013).
8. Weisburd, D., et al., 2016. Do stop, question, and frisk practices deter crime? Evidence at microunits of space and time. Criminology & public policy, 15 (1), 31–56.

# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Батбаяр
*ДХИС-ийн магистрант,*
*цагдаагийн ахмад*

**Товчлол.** Гэр бүлийн хүчирхийлэл нь хэн нэгэн хүний ганц нэгэн удаагийн, санамсаргүй, тохиолдлын зан үйл бус тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл төдийгүй бусдыг зовоон тарчлаах нэг хэлбэр юм.

Энэхүү өгүүлэлд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал, түүний шийдвэрлэлт, хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйл, дахин гарахаас урьдчилан сэргийлэх зарим арга замын талаар товч авч өгүүлсэн болно.

**Түлхүүр.** Гэр бүлийн хүчирхийлэл, бие сэтгэлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт

**Үндсэн хэсэг.** Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй үүний хохирогч нь дийлэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд болдог. НҮБын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр дэлхий дээр 2019 онд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.

Энэ талын мэдээлэл дутмаг, далд хэлбэртэй байдгаас гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авахад бэрхшээлтэй тулгардаг, тухайлбал, хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн 40 хүрэхгүй хувь нь аливаа төрлийн тусламж хүсдэгээс 10 хүрэхгүй хувь нь цагдаад ханддаг байна.[110]

Монгол Улс Үндсэн хуулинд "Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, иргэдийнхээ амар тайван аж төрөх нөхцөл бололцоог хангах явдал нь төрийн үүрэг мөн" гэж тунхагласан. Мөн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт " ..., гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална"[111] гэж тус тус заасан.

Нийгэмд эхнэрээ зодох, хүүхдийнхээ бие мах бодид гэмтэл учруулах зэргийг л хүчирхийлэл хэмээн үздэг, бусдыг нь тоодоггүй хэвшмэл ойлголт саяхныг хүртэл байсан. Гэр бүлийн хүчирхийлэл үнэн хэрэгтээ олон хэлбэрээр үйлдэгддэг аж. Тухайлбал, бие мах бодийн, эдийн засгийн, оюун санааны болон бэлгийн хүчирхийлэл зэрэг хэлбэрүүд байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн талаар манай орны эрдэмтэн, судлаачид багагүй судалсан байдаг. Тухайлбал, доктор (Ph.D) Г.Ганбаатар: "Ахуйн хүрээний гэх тодотголтой гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэмд шинээр гарч буй үзэгдэл биш ч, түүнийг "гэмт хэрэг" хэмээн үзэх хандлага ... харин шинэ тутам билээ"[112] хэмээн тэмдэглэсэн байдаг.

---

[110] Гэр бүлийн хүчирхийлэл. Үндэсний статистикийн хороо, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан судалгааны тайлан. 2020. 2 дахь тал

[111] Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

[112] Доктор (Ph.D) Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016.

Монгол Улс 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль баталж, 2017 оноос хэрэгжүүлж эхэлснээр энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл ихсэж, илрүүлэлт, шийдвэрлэлт өсжээ. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дахин ийм зүйл болохгүй хэмээн найдаж, гэр бүлийн харилцаагаа бүтэн авч үлдэхийг хүсэх, үр хүүхдээ өнчрүүлэхгүй байх зэрэг шалтгаанаар ихэнх тохиолдолд хүчирхийлэлд өртөж буйгаа нууцалдаг.

Хүчирхийлэлд өртсөнөө нууж, тэвчсээр цаг хугацаа өнгөрөх тусам энэ төрлийн хэрэг улам бүр ноцтой болж, улмаар хохирогч амиа алдахад хүргэдэг нь тулгамдсан асуудал болоод байна.

Монгол Улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, мөрдөж байгаагаас гадна Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган өгч, хэрэгжүүлж байна. Түүнчлэн хүчирхийлэлд өртсөн иргэдэд тусламж, зөвлөгөө өгөх, хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлж байна. Тухайлбал, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулсан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх 15 нэг цэгийн үйлчилгээний төвөөс гадна дэмжлэг үзүүлэн хамгаалах 2 байр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн алба нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, улс орны хийгээд дэлхий нийтийн өөрчлөлт шинэчлэлттэй уялдуулан эрх хэмжээ, ач холбогдлыг зөв тодорхойлох, эрэлт хэрэгцээг судлан тогтоох нь тулгамдсан асуудлын нэг юм. ЦЕГ-ын даргын 2019 оны А301 дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийг шинээр байгуулсан. Хэлтсийн үндсэн зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгддэг.

Хууль хэрэгжиж эхэлснээр хүчирхийлэл нь гэмт хэрэг, зөрчил юм гэдэг зөв ойлголт нийгэмд бий болж байна. Мөн гэр бүлийн хүчирхийллийг цагдаагийн байгууллагад мэдээлэх ёстой, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага ногдуулах ёстой юм байна гэдгийг мэддэг болсон. Өөрөөр хэлбэл, хохирогчид “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас миний амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй” гэдгийг маш сайн ойлгодог болоод байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллага холбогдох байгууллагуудтай хамтарч, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж байна. Үүний үр дүнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилт сайн байгаа гэж хэлж болно. Цоожтой хаалганы цаана үйлдэгддэг гэр бүлийн хүчирхийлэл даамжирч, хугацаа өнгөрөх тусам ноцтой болж байдаг. Тухайлбал, хүчирхийлэл үйлдэгч эцсийн аргаа хэрэглэх буюу хохирогчийн амь нас, эрүүл мэндэд халдах тохиолдол цөөнгүй гарсан байдаг.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын алба хаагчид гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу очиж, аюулын зэргийн үнэлгээ хийж, улмаар хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг таслан зогсоох, зөрчлийг шалган шийдвэрлэх, шүүхэд материалыг шилжүүлэх гэх мэт хуульд заасан шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага хүчирхийлэлд өртсөн хохирогчийг ар гэр, хамаатан садных нь асран хамгаалалтад өгөхөөс гадна түр хамгаалах байраар үйлчлэх зэргээр аюулгүй байдлыг нь хангах зэргээр үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн

амын сан, Жендерийн үндэсний хороо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Статистикийн үндэсний хороо зэрэг олон төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг.

Мөн сүүлийн жилүүдэд иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн ажил хийж байна. Тодруулбал, Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтэд зориулан “Хайрлая, хамгаалъя”, “Нэг хором” зэрэг аян зохион байгууллаа. Эдгээр арга хэмжээ нь ард иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн талаарх буруу хандлагыг өөрчлөх, хүчирхийлэлгүй нийгмийг төлөвшүүлэхэд нөлөөлж байна.

Нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2019 онд 130 гарч байсан бол 2020 онд 65 гарч, 50 хувиар буурсан тоо мэдээ байна. Харин улсын хэмжээнд 2019 онд 207 гарсан бол 2020 онд 111 гарч, өмнөх оны мөн үеэс 96 буюу 46.4 хувиар буурчээ.[113]

*График №1*




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурсан хэдий ч үүний улмаас гарсан хохирол нэмэгдсэн, нөгөө талаас энэ төрлийн зөрчлийн тоо нэмэгдэж байгаа нь анхаарал хандуулах асуудал болохыг харуулж байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагдахын зэрэгцээ, давтагддаг, давтагдах бүрдээ шинж чанарын хувьд улам ноцтой болдог өвөрмөц шинж бүхий үйл явц юм. Нөгөөтээгүүр нийтийг хамарсан цар тахал дэгдсэн энэ цаг үед олон нийтийн дунд бухимдал стрессийн түвшин нэмэгдсэний улмаас гэр бүлийн хүчирхийлэл өсөх зүй тогтол манай улсад ч мөн илэрч байна.

2019 онд улсын хэмжээнд 31524 гэмт хэрэг бүртгэгдсэн. Үүнээс 985 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь 2018 оны мөн үетэй харьцуулахад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 7.9 хувиар буурсан үзүүлэлттэй гарч байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 93.6 хувь нь хөнгөн, 6.4 хувь нь хүнд хэлбэрээр үйлдэгдсэн байна. Харин 50.2 хувь нь Улаанбаатарт, 49.8 хувь нь орон нутагт бүрдтгэгдсэн. Мөн цагдаагийн байгууллагын хэмжээнд өнгөрсөн онд 2.1 сая орчим зөрчил бүртгэгдсэний 8962 буюу 0.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байдаг. Энэ хүрээнд зөрчил гаргасан 6400 хүнд баривчлах, шийтгэл ногдуулсан[114] байна.

БЗД-ийн цагдаагийн 3-р хэлтсийн харъяалах нутаг дэвсгэрт 2020 онд иргэн, хуулийн этгээдээс нийт 23427 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 2973 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, үүнээс 4022-г гомдол мэдээллийн бүртгэлд авч,

[113]https://police.gov.mn/. ЦЕГ-ын газрын 2020 оны статистик тоо мэдээ.
[114] https://police.gov.mn/a/5013

эрх бүхий алба хаагчид зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж, зөрчил үйлдсэн нь тогтоогдсон 679 иргэнд баривчлах шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэгдсэн нь тогтоогдоогүй 2589 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Мөн иргэдээс дуудлага, мэдээллээ буцаасан, хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад худал дуудлага мэдээлэл өгсөн болох нь тогтоогдсон 648 иргэнд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 15.9 дэх хэсэгт заасны дагуу торгуулийн арга хэмжээ оногдуулсан байна.

*График №2*




Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын гуравдугаар хэлтэст ирүүлсэн сүүлийн 3 жилийн дуудлага, мэдээлэл болон хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй өргөдөл гомдлын судалгаанаас харахад хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй нийт 11285 өргөдөл, гомдолд эрх бүхий албан тушаалтнууд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас зөрчил үйлдэгдээгүй үндэслэлээр 6931 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад зөрчил үйлдэгдсэн нь тогтоогдсон 2045 иргэнд харьяа дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Харин 2351 иргэнийг цагдаагийн байгууллагад худал дуудлага мэдээлэл ирүүлсэн гэх үндэслэлээр Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ оногдуулж байна.

*Хүснэгт №1*

| № | Огноо | ГБХ-н шинжтэй өргөдөл гомдол | Татгалзаж шийдвэрлэсэн | Баривчлуулсан | ЗТХ-н 15.9-р зүйлээр торгосон /худал дуудлага мэдээлэл өгсөн/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2018 он | 3192 | 1918 | 606 | 830 |
| 2 | 2019 он | 3448 | 2020 | 622 | 761 |
| 3 | 2020 он | 4022 | 2589 | 679 | 648 |
| 4 | 2021 оны эхний 3 сар | 623 | 404 | 138 | 112 |
| Нийт | | 11285 | 6931 | 2045 | 2351 |

Дээрхи харьцуулсан судалгаанаас харахад хамгийн анхаарал татаж байгаа бидний анхаарлаа хандуулах зүйл бол худал дуудлага мэдээлэл өгсөн нэрийдлээр хүчирхийлэлд

өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд ахуй амьдралаа бодсон, цаашид гэр бүлийн харилцаанд үүсэх сөрөг үр дагавараас үүсэхээс эмээж ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллээ нуун дарагдуулж байж болзошгүй гэх хардалтыг төрүүлж байна.

Цагдаагийн байгууллагад дуудлага мэдээлэл өгсөн хүүхэд эмэгтэйчүүд архи согтууруулах ундаа хэрэглэж хүчирхийлэл үйлдсэн нөхөр болон бусад гэр бүлийн гишүүдийнхээ гаргасан үйлдлийг нуун дарагдуулж, хүчирхийлэл үйлдсэн гэж мэдүүлснийхээ төлөө нөхөр нь болон хүчирхийлэл үйлдсэн этгээдийг шүүхээр 7-30 хоног баривчилгаанд явуулахаас айж түгших, эргээд хэсэг хугацааны дараа гарч ирээд улам хэрцгий догшин авирлах, чи намайг цагдаад барьж өгсөндөө гэж дарамт үүсэхээс айх зэрэг ирээдүйд үүсэх эрсдлээ тооцож, хүчирхийллийг нуун дарагдуулж, худал дуудлага мэдээлэл өгсөн болж, цагдаагийн алба хаагчдад өөрсдөө 50 нэгж буюу 50.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авхуулж байгаа вий гэдэгт хардалт төрж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл гэдэгт оюун санааны, эдийн засгийн, бие мах бодийн болон бэлгийн гэсэн дөрвөн төрлийн хүчирхийлэл багтдаг. Үүнээс бие мах бодийн хүчирхийлэл манай улсад түгээмэл байдаг. Тодруулбал, 2019 оны байдлаар энэ төрлийн гэмт хэргийн 80 гаруй хувь нь бие мах бодийн хүчирхийлэлтэй холбоотойгоор үйлдэгдсэн байдаг. Мөн гэр бүлийн хүчирхийллийн 50 гаруй хувь нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ үйлдсэн байдаг нь архи, согтууруулах ундаа нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйл гэж үзэж болохоор байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үүсэх суурь шалтгаан нь гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн хоорондын харилцаа. Тодруулбал, харилцаагаа буюу маргаанаа эерэг аргаар шийдэж чадаагүйгээс даамжирдаг. Улмаар үүнийгээ зохицуулж байгаа арга барил нь нэгнийгээ зодох, хохирол учруулах зэрэг байдаг. Тэгэхээр архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа байдал, ядуурал, ажилгүйдэл зэрэг нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйл болохоос шалтгаан биш юм.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өөрөө онцлог шинжтэй байдаг. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 5.4[115]-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулж, албадан сургалтад суулгахаар заасан байдаг. Үүнээс өөр торгох болон бусад шийтгэл байхгүй. Өөрөөр хэлбэл, зөвхөн баривчлах шийтгэлтэй учир нэлээн хатуу шийтгэлтэйд тооцогддог.

Цагдаагийн байгууллага Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн амын сан зэрэг байгууллагатай хамтран 2020 оны 3 сарын 9-27-ныг хүртэл “Хайр өвтгөдөггүй” аян зохион байгуулсан байдаг. Тус арга хэмжээ нь гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх зорилготой явагдсан нь зохих үр дүнгээ өгсөн. Мөн энэхүү аяны хүрээнд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхээр онцгой анхаарч ажилласан байна.

[115] Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хохирогчдын 90 орчим хувь нь өөрийн ах дүү, хамаатан садныхаа асрамж, халамжид үлддэг. Үлдсэн 10 гаруй хувь нь түр хамгаалах байр буюу нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлдэг. Өөрөөр хэлбэл, хохирогчийг түр хамгаалах байранд байлгана гэдэг нь хүчирхийлэгчээс хамгаалах арга хэмжээ авч байна гэсэн үг.

Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг хамгийн багадаа тухайн өдөрт нь, удлаа гэхэд 3-5 хоногт шүүхэд шилжүүлж, зохих шийтгэлийг ногдуулдаг. Аюулгүй байдлын хамгаалалтыг ямар хугацаанд үргэлжлүүлэхийг аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээг харгалзан үзэж шийддэг. Мөн хохирогчийг зөвхөн цагдаагийн байгууллага хамгаалдаггүй. Тухайлбал, хорооны хамтарсан баг гэж байдаг. Энэ мэт цөөнгүй байгууллагатай хамтарч, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зэргээр цогцоор нь шийдэхийг хичээдэг. Цагдаагийн байгууллага дангаараа гэр бүлийн хүчирхийллийн эсрэг ажиллана гэвэл хүн хүчээс эхлээд боломж боломцоо төдийлөн байхгүй, хүссэн үр дүнд хүрэхгүй бөгөөд үүнд төрийн болон төрийн бус байгууллагаас эхлээд бүх нийтийн хүчин оролцоо чухал үүрэгтэй байдаг.

Дэлхий даяар тархаад буй COVID 19 шинэ халдвараас сэргийлэхийн тулд улс орнууд тусгаарлах, хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай зэрэгцэн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх нь өсөж, тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгджээ. Учир нь хүчирхийлэл үйлдэгчтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг тусгаарлах байдлыг нэмэгдүүлж, тэдэнд тусалж чадах хүмүүс, боломжоос нь мөн холдуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас тусламжийн утасны үйлчилгээ, хоргодох байраар хангах хэрэгцээ нэмэгдэж байгаа талаар Аргентин, Канад, Франц, Герман, Испани, Нэгдсэн Вант Улс, АНУ-ын засгийн газрын эрх баригчид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, иргэний нийгмийн байгууллагууд тайландаа тэмдэглэсэн байна.

Хөл хорио, тусгаарлалт нь аюулгүй байдал, эрүүл мэнд, мөнгөний түгшүүрээс үүдэлтэй хурцадмал байдлыг өдөөдөг. Тиймээс энэ арга нь хаалттай хаалганы цаадах хүчирхийлэгчдийг хянах боломжийг сулруулж байна.

Үүнээс гадна COVID халдварын тархалтын улмаас эрүүл мэндийн байгууллагын яаралтай бэлэн байдлыг хангахад түр хоргодуулах байрыг нэмэлтээр ашиглах нь энэ чиглэлийн үйлчилгээ авах боломж, хүртээмжийг бууруулж байна.

Нөгөө талаараа өндөржүүлсэн байдлын үед ажил хийгээгүй иргэд ахуйн хүрээнд архидан согтуурах явдал нэмэгдэж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх нэг хүчин зүйл болж байна.

**Дүгнэлт.** Дээрх нөхцөл байдлыг үндэслэн дүгнэхэд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргасан иргэн баривчлах шийтгэл хүлээгээд гарч ирээд дахин хүчирхийлэл үйлдэх явдал улам бүр нэмэгдэх хандлагатай болж байгаа нь тулгамдсан асуудал болжээ. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн талаар иргэдийн мэдээлэл өгөх явдал учир дутагдалтай, сэтгэлгээний зөв хандлага төлөвшиж чадахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлж байна.

Манай улсын гэр бүлүүд эдийн засгийн боломж, боломцоо таагүй учраас ихэвчлэн өөрийн гэр оронгүй, тусалж дэмжих хүнгүй байдал нь  хүчирхийлэлтэй эвлэрэхээс өөр аргагүй байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн золиос болдог байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд нь ихэнх нь боловсрол мэдлэггүйн улмаас ажилгүй гэртээ суудаг эмэгтэйчүүд өртөж байгаа учир ажилгүй эмэгтэйчүүдийг сургалтад хамруулж мэргэжил эзэмшүүлэх, цалинтай дадлагажуулах зэрэг үйл ажиллагаанд санаачлага гаргах нь зүйтэй байна.

Хохирогч эмэгтэйчүүдийн хувьд сургууль төгсөөд хүүхэд төрүүлээд гэртээ суудаг учир мэргэжлээрээ ажиллаагүй, ажлын туршлагагүй зэрэг нь сөргөөр нөлөөлдөг.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргасан тохиолдлыг дахин давтагдуулахгүй байх талаас нь үе шаттай, уялдаатай, олон талын оролцоог хангах, богино хугацаанд үр ашигтай байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

**Санал.** Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлбэл тодорхой үр дүнд хүрнэ гэж үзэж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг цагдаагийн болон бусад холбогдох байгууллагад түргэн шуурхай хүргэх сэтгэлтгээний хандлагыг бий болгоход онцгой анхаарч, бага, хорооны нийгмийн ажилтнуудыг энэ ажилд дайчлан оролцуулах;
2. Олон нийтийн цахим мэдээллийн эх үүсвэр ашиглан өрх эр бүлийн халуун дулаан уур амьсгал, харилцааг дэмжих, стресс бууруулах арга замуудыг сурталчлах, ерэг хандлага нэмэгдүүлэх сургалтыг явуулж тогтмолжуулах;
3. Эрэгтэйчүүдийн зан үйл, амьдралын зөв хэв маягийг таниулах, сурталчлах, зан үйлд нөлөөлөх сургалтыг хорооны хэсэг тус бүрээр нь ээлж дараалан зохион байгуулж, эрчүүдийг бүрэн хамруулах;
4. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэж шийтгэгдээд давтан үйлдэж байгаа иргэдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлого боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх.

# ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ, ТҮҮНИЙ МӨН ЧАНАР

***Э.Батболд.***
*ДХИС-ийн Магистрант,*
*цагдаагийн хошууч*

**Товчлол.** Гэмт хэрэг, зөрчлийг багасахад нөлөөллийн аргууд чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, нөлөөллийн ажлаар дамжуулж иргэдийн сэтгэл зүйд хүрснээр урьдчилан сэргийлэх ажил маань үр дүнд хүрдэг. Энэхүү өгүүлэлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нөлөөллийн арга хэмжээний тухай ойлголт, гэмт хэрэг, зөрчлийн гаралтад хэрхэн нөлөөлж байгаа талаар товч авч үзсэн болно.

**Түлхүүр үг.** Урьдчилан сэргийлэх ажил, нөлөөлөл, нөлөөллийн үйл ажиллагаа, нөлөөллийн арга хэмжээ

**Үндсэн хэсэг.** Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалах ,хууль зөрчигчдөд хариуцлага тооцох, хэрэг маргааныг таслан шүүх замаар нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтооход оршдог. Тиймээс зөвхөн хууль, шүүх эрх мэдлийн байгууллагууд төдийгүй төрийн институтийн ямар ч байгууллагын үйл ажиллагааны багагүй хэсгийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эзэлдэг.

Нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт, шинэчлэлтийн энэ цаг үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бодлого, чиглэл тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж, иргэд, олон нийтийн сэтгэл зүйд хүрч ажиллах боломж нөхцөлийг тодорхойлох, гадаад улс орнуудын туршлагыг нэвтрүүлэх, түүнтэй холбоотой судалгааны ажлыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага өнөөдрийг хүртэл байсаар байна.

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 1997 онд анх батлагдсанаас хойш 22 жилийн дараа “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”[116] 8 бүлэг, 48 зүйлтэй батлагдсан бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, бодлогын нэгдмэл байдлыг тодорхойлж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Хүн, хуулийн этгээдийг гэмт халдлагаас хамгаалах, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох эрсдэлийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн цогц арга хэмжээг соён гэгээрүүлэх чиглэл гэнэ.”[117] гэж тусгасан. Энэ заалтаас харахад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нөлөөллийн үйл ажиллагаатай уялдуулж, иргэд, олон нийтийг нөлөөллийн арга хэмжээгээр дамжуулж сэтгэл зүйн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад чиглэсэн байна. Тиймээс нөлөөллийн арга хэмжээгээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар онолын судалгааг хөгжүүлэх, практикт хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Энэхүү өгүүллийн агуулгад:

1. Нөлөөллийн үйл ажиллагааны тухай ойлголт
2. Гэмт хэргийн гаралт, түүнд хийсэн дүн шинжилгээ

[116] Төрийн мэдээлэл. 2019. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
[117]Төрийн мэдээлэл. 2019. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

3. Монгол орны хэмжээнд зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар товч бичлээ.

Америкийн Нэгдсэн Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагад суух Элчин сайд асан Саманта Повер "All advocacy is, at its core, an exercise of empathy" буюу "Нөлөөллийн ажил гэдэг нь угтаа бусдын оронд өөрийгөө тавьж ойлгох чадвар юм."[118] хэмээн хэлсэн байна.

Нөлөөлөл гэдэг нь төсөл, хөтөлбөрт суурилан хүний эрхийг зөрчсөн, тэгш бус байдлыг бий болгосон бодлого, систем, хандлагыг өөрчлөх замаар ядуурлыг бий болгож байгаа бүтцийн болон системт шалтгааныг арилгахад чиглэсэн арга зам юм.

Иргэнийхээ үүрэг, эрхийг нь ухамсарлуулах, өөрийгөө өмгөөлөх чадамжтай болоход нь туслах, дэмжих, мэдлэг мэдээллээр хангах, идэвхжүүлэх, чадваржуулах, хэрэгцээ шаардлагыг нь дэмжих замаар иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг ролийг дээшлүүлж бодлогын өөрчлөлт хийхийг нөлөөлөл гэдэг байна.

**Нөлөөллийн үйл ажиллагаа.** Нөлөөллийн үйл ажиллагааны талаар *судалгаа хийх, төлөвлөх, үйл ажиллагаа явуулах, хянах, үнэлгээ өгөх* зэргийг багтаасан урт хугацааны үйл ажиллагаа юм. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, дарамттай тэмцэх, шударга бус байдлыг арилгах, иргэдийн сэтгэл зүйг соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжих зэрэг нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа юм.

Нөлөөллийн үйл ажиллагааг дараах аргачлалаар зохион байгуулдаг байна. Үүнд:

1. Иргэд олон нийтэд хууль эрх зүйн орчинд тэдний эрх үүргийг хэрхэн томьёолсон байдаг, эрхээ хэрхэн бүрэн эдлэх боломжтойг таниулах, мэдээлэх;
2. Иргэд олон нийтийг өөрсдийн сайн сайхны төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулах хүсэл эрмэлзэлтэй болгох, санаачилсан үйл ажиллагааг дэмжиж идэвхжүүлэх;
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санаачилсан нөлөөллийн үйл ажиллагаанд шийдвэрлэх эрх мэдэлтэнүүдтэй хамтран ажиллахыг, тодорхойлсон асуудал нь нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд хуулийн хэрэгжихгүй орон зайд нөлөөлөхүйц асуудал байхыг зөвлөх;
4. Иргэд олон нийтэд хууль, бодлого, журам үнэн зөв хэрэгжиж байгааг хянах, үнэн бодит хэрэгжихгүй байгаа тохиолдолд шаардлага тавин эрхээ хамгаалахад нь туслах дэмжих.

Нөлөөллийн ажлыг дараах 5 үе шатанд хуваан авч үздэг. Тухайлбал:

*Бүдүүвч №1*

[118] https://thepsychologist.bps.org.uk/volume-32/may-2019/how-can-we-embed-psychology-public-policy - нийтлэл, Kathryn Scott, 2019 он




***Нөлөөллийн загвар үйл ажиллагаа:***

*Хүснэгт №1*

| | | |
|---|---|---|
| Хэлэлцүүлэг | Өргөдөл бичих | Хэвлэлээр тараах |
| Бодлого судлах | Тохиролцох | Ярианы шоу |
| Лоббидох | Захиа бичих | Дугуй ширээний яриа |
| Цуглаан хийх | Хэвлэлийн бага хурал хийх | Семинар |
| Хяналт тавих | Цохилт өгөх | Сургалт |
| Плакат хийх | Яруу найргийн тэмцээн хийх | ТВ болон радио жүжиг |
| Вэб сайт ажиллуулах | Марш зохион байгуулах | Айлаас айлд |
| Сүлжээ зохион байгуулах | Танилцуулга хэвлэх | Бүх нийтийн чуулган |
| Уулзалт | Судалгаа хийх | |
| Сонин гаргах | | |

Дээрх үйл ажиллагаануудаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавих, плакат хийх, уулзалт сургалт зохион байгуулах, танилцуулга материал бэлтгэн сонин, сэтгүүл, телевизээр сурталчлах зэрэг ажлыг цагдаагийн байгууллага нь ихэвчлэн зохион байгуулдаг.

Нөлөөллийн ажлаар дамжуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй нөхцөл байдлыг сүүлийн жилүүдийн гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлтүүдийг харьцуулан, дүн шинжилгээ хийн иргэд олон нийтэд мэдээлэх, урт хугацааны туршид үе шаттай, үр дүнд хүрэхүйц нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй байна.

Цагдаагийн байгууллага 2020 онд иргэн, аж ахуйн нэгжээс 550.254 дуудлага мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 260.357 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 1178 буюу 0.5 хувиар өсөж, гэмт хэргийн шинжтэй 65.187 /25.0%/, зөрчлийн шинжтэй 192.053 /73.8%/ гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 23064, Улаанбаатар хотод 14633 /63.4.%/, орон нутагт 8420 /36.5%/, бусад газар /*хилийн чанадад үйлдэгдсэн*/ 11 /0.1%/ гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 8460 хэрэг буюу 26.8 хувиар;
- Нийслэлийн хэмжээнд 5628 хэрэг буюу 27.8 хувиар;
- Орон нутгийн хэмжээнд 2784 хэрэг буюу 24.8 хувиар;
- Бусад газар /хилийн чанадад/-т 48 хэрэг буюу 81.4 хувиар тус тус буурсан байна.

*График №1*




Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл гэмт хэргийн бууралт 2.4 хувьтай байна.

2020 онд бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг нийслэлийн дүүрэг тус бүрээр нь авч үзвэл харилцан адилгүй байна. Энэ нь нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, дүүргийн байршил, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

*Зураг №1*

<u>Нийслэлд:</u>



Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд нөлөөллийн арга хэмжээнүүдийг олон нийтийн цахим сүлжээ болон бусад арга хэрэгслүүдийг ашиглан идэвхитэй явуулсан.




Тухайлбал, 2020 онд иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор ЦЕГ-аас “Нэг хором”, “Яараад яахав дээ”, “Дураараа биш ээ, дүрмээрээ”, “ОйлГОЁ-ХҮНдэлье” зэрэг олон аян, нэгдсэн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байдаг.

Дээрхи нөлөөллийн арга хэмжээний үр дүнд зам тээврийн осол, гэмт хэрэг 11.4 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

Тодруулбал “Яараад яахав дээ” аяны хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 50.8, гэмтсэн хүн 49.7, нас барсан хүн 11.7 хувиар тус тус буурч, үүнээс орон нутагт үйлдэгдсэн хэрэг 63.9, гэмтсэн хүн 59.5, нас барсан хүн 21.7 хувиар буурсан статистик тоо мэдээ байна.

2020 оны эхний 11 сарын байдлаар улсын хэмжээнд 30011 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3869 хэргээр буюу 11.4 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтүүд гарчээ.

Түүнчлэн “Нэг хором” аян Эстони Улсын Таллин хотод зохион байгуулсан JCI байгууллагын 2019 оны дэлхийн чуулганд 200 гаруй орны шилдгийн шилдэг төсөл хөтөлбөрүүдээс шилдэг гуравт, “Яараад яахав дээ” аян “Unread Awards 2019” шалгаруулалтын “Шилдэг санаачилга” номинацид шалгарсан нь энэхүү нөлөөллийн арга хэмжээний ач холбогдол, үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрсөн явдал юм.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай асуудлыг нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэр, хүн ам, зан заншил, соёл иргэншилд тулгуурлаж зохион байгуулдаг байсан бол нөлөөллийн арга хэмжээг урьдчилан сэргийлэх асуудалд илүү анхаарал хандуулан авч үзсэн нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, нөлөөллийн аргаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголтод тулгуурлаж, энэхүү арга хэмжээг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой болох нь 2019, 2020 онд зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээнүүдийн үр дүнд гэмт хэрэг, зөрчил өмнөх онуудынхаас 11.4 хувиар буурсан нь нотолж байна.

**Дүгнэлт.** Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг орчин үеийн хөгжил, дэвшил, нийгмийн онцлогтой уялдуулан цоо шинэ арга барилаар зохион байгуулах шаардлагатай болжээ. Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн нөлөөллийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь зөвхөн ухуулга, сурталчилгаа хийх, телевиз, радиогоор нэвтрүүлэг хийх зэргээр л хийгдсэн байна. Мөн гэмт хэргийн нөхцөл байдал ихээхэн хувьсал, өөрчлөлт гарч байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтолцоогоор нь шинэчлэх, практикт хэрэгжүүлэх, хангах арга замыг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг нь хууль эрх зүйн оновчтой тогтолцоо, төрийн бодлогын бодит дэмжлэгээр дамжин сайжруулах, өргөн хүрээний нэгдсэн бодлого боловсруулах, улмаар түүнд нийцсэн нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна.

**Санал.** Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нөлөөллийн аргаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гарын авлага боловсруулах.

2. Нөлөөллийн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга нартай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэх;

3. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч нарт орчин үеийн шинэ арга хэлбэр, дэвшилтэт техник, технологи ололт, амжилт, удирдлагын менежмент, нөлөөллийн шинэ санааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэрхэн ашиглах талаар сургалт семинар зохион байгуулах;

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

# АЙМАГ ДАХЬ ЭКОЛОГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЛБА ХААГЧДЫН АЖИЛ АЧААЛАЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

**Б.Зоригт**
*Дотоод хэргийн их сургуулийн*
*“магистрант, цагдаагийн ахмад*

**Товчлол.** Монгол Улсад 2020 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар шиглалтын болон хайгуулын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 2,745[119] байна. 2020 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нийт 622 бүртгэгдсэн нь энэ төрлийн гэмт хэрэг улам нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Өнөөдөр Экологийн цагдаагийн алба байгуулагдаад удаагүй байгаа болович орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэст экологийн асуудал хариуцсан алба хаагч нарын ажлын ачаалал харилцан адилгүй байна.

Энэхүү өгүүлэлд аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын ажил, ачаалалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тус албаны орон тоог нэмэгдүүлэх, боломжгүй тохиолдолд алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

**Түлхүүр үгс**: Экологийн цагдаагийн алба, экологийн асуудал хариуцсан алба хаагч, ажлын ачаалал

**Үндсэн хэсэг.** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны А/09 дүгээр тушаалаар цагдаагийн төв байгууллагын бүтцэд Захиргааны удирдлагын, Эрүүгийн цагдаагийн, Зөрчил шалган шийдвэрлэх, Урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны гэсэн 4 хэлтэс, 21 аймаг, 64 суманд экологийн асуудал хариуцсан алба хаагчтайгаар хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр байгуулагдсан билээ.

[119] https://mrpam.gov.mn/public/pages/165/2020-04-mon.pdf

Мөн ЦЕГ-ын даргын 2020 оны А/173 болон 2021 оны А/52 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг бүтэц, орон тооны хамт тус албанд шилжүүлж, Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийг шинээр байгуулсан.

Өнөөдөр Экологийн цагдаагийн алба нь Удирдлага, Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс, Захиргааны удирдлагын хэлтэс, Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтэс, Эрүүгийн цагдаагийн хэлтэс, Зөрчил шалган шийдвэрлэх хэлтэс, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс, нийт 77, 21 аймагт экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, мөрдөгч, 64 суманд экологийн асуудал хариуцсан байцаагч, нийт 101, бүгд 178 алба хаагч, ажилтны орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

**Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн нөхцөл байдлын талаар**:

Улсын хэмжээнд 2020 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1828 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 1001 буюу 1.2 дахин өссөн байна.

<u>Гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар:</u>



Гэмт хэргийн шинжтэй 1250, зөрчлийн шинжтэй 544 гомдол, мэдээллийг буюу 98.1 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 34 буюу 1.9 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд байна. Үүнээс 28 буюу 82.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 6 буюу 17.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.

Улсын хэмжээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ онд нийт 622 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 133 хэрэг буюу 27.2 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 23064 хэргийн 2.7 хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн 622 хэргийн 570 буюу 91.6 хувь нь орон нутагт, 52 буюу 8.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутагт бүртгэгдсэн хэрэг 121 буюу 26.9 хувиар, нийслэлд бүртгэгдсэн хэрэг 12 буюу 30.0 хувиар тус тус өсчээ.

*График №1*




| | 2019 он | 2020 он | Өсөлт бууралт | Нийт хэрэгт эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Орон нутагт | 449 | 570 | 26.9 | 2.5% |
| Нийслэлд | 40 | 52 | 30.0 | 0.2% |
| Улсын хэмжээнд | 489 | 622 | 27.2 | 2.7% |

Дээрхи графикаас үзвэл орон нутаг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нэмэгдэх хандлагатай байгаа нь экологийн асуудал хариуцсан алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, шаардлагатай автомашин, техник хэрэгслээр хангах асуудал чухлаар тавигдах болсон байна.

Бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийг бүртгэгдсэн нутаг дэвсгэрээр харуулбал:



*ураг №1*



12 57 5 67 15

16 47 52

33 26 40 32 20

37

53 45 11 3 14

10

11 16

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн зүйлээр нь авч үзвэл, 262 буюу 42.1 хувийг хууль бусаар мод бэлтгэх, 223 буюу 35.9 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 84 буюу 13.5 хувийг хууль бусаар ан агнах, 28 буюу 4.5 хувийг байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, 19 буюу 3.1 хувийг химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах, 4 буюу 0.6 хувийг байгаль орчныг бохирдуулах, 1 буюу 0.2 хувийг ой хээрийн түймэр тавих, 1 буюу 0.2 хувь нь байгалийн тэнцэл алдагдуулах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

*График №2*




1

Аймаг дахь цагдаагийн газар хэлтэст сүүлийн 3 жилд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн болон ашигт малтмалын хайгуулын, ашиглалтын тусгай зөвшөөрлийн судалгаа.

*Хүснэгт №1*

| д/д | Аймаг | Тусгай зөвшөөрөл | | Бүртгэгдсэн гэмт хэрэг | | | Экологийн асуудал хариуцсан алба хаагчдын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хайг | Ашиг | 2018 | 2019 | 2020 | |
| 1 | Архангай | 6 | 15 | 18 | 20 | 26 | 8 |
| 2 | Баян-Өлгий | 39 | 29 | 6 | 19 | 16 | 1 |
| 3 | Баянхонгор | 72 | 88 | 11 | 20 | 53 | 10 |
| 4 | Булган | 40 | 74 | 40 | 46 | 47 | 6 |
| 5 | Говь-Алтай | 103 | 52 | 3 | 4 | 10 | 1 |
| 6 | Говьсүмбэр | 10 | 15 | 1 | | 3 | 1 |
| 7 | Дархан-Уул | 15 | 67 | 27 | 9 | 15 | 5 |
| 8 | Дорноговь | 163 | 191 | 5 | 18 | 16 | 3 |
| 9 | Дорнод | 88 | 76 | 9 | 17 | 20 | 8 |
| 10 | Дундговь | 126 | 105 | | 5 | 11 | 1 |
| 11 | Завхан | 42 | 9 | 12 | 17 | 33 | 2 |
| 12 | Орхон | 3 | 8 | 1 | 3 | 5 | 1 |
| 13 | Өвөрхангай | 40 | 23 | 33 | 26 | 45 | 8 |
| 14 | Өмнөговь | 138 | 101 | 6 | 12 | 11 | 7 |
| 15 | Сүхбаатар | 32 | 67 | 2 | 1 | 14 | 1 |
| 16 | Сэлэнгэ | 128 | 131 | 78 | 111 | 67 | 8 |
| 17 | Төв | 114 | 283 | 21 | 26 | 40 | 10 |
| 18 | Увс | 84 | 47 | 6 | 6 | 12 | 1 |
| 19 | Ховд | 61 | 35 | 13 | 36 | 37 | 2 |
| 20 | Хөвсгөл | 11 | 21 | 44 | 40 | 57 | 9 |
| 21 | Хэнтий | 103 | 117 | 10 | 13 | 32 | 8 |

Сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг бага бүртгэгдсэн, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл цөөн, экологийн асуудал хариуцсан байцаагийн орон тоотой сумдыг харуулав.

*Хүснэг*
*т №2*

| д/д | Аймаг | Сум | Тусгай зөвшөөрөл | | Бүртгэгдсэн гэмт хэрэг | | | Зөрчлийн гомдол 2021.02 сар | ЭАХБ-гч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хайг | Ашиг | 2018 | 2019 | 2020 | | |
| 1 | Архангай | Чулуут | 1 | 1 | 1 | | | | 1 |
| 2 | | Эрдэнэмандал | | | | | | | 1 |
| 3 | Баянхонгор | Богд | | 1 | | 1 | | | 1 |
| 4 | | Эрдэнэцогт | | 1 | 1 | 1 | 1 | | 1 |
| 5 | Дархан-Уул | Орхон | 2 | 4 | 2 | | | 1 | 1 |
| 6 | Дорнод | Дашбалбар | 17 | 8 | 2 | | | | 1 |
| 7 | | Матад | 4 | 8 | 1 | 1 | | | 1 |
| 8 | | Хөлөнбуйр | 1 | | | 1 | | | 1 |
| 9 | Өвөрхангай | Богд | 2 | | | | | | 1 |
| 10 | Өмнөговь | Баяндалай | 12 | 5 | 1 | 1 | | | 1 |
| 11 | | Манлай | 11 | 1 | | 1 | | | 1 |
| 12 | Сэлэнгэ | Сайхан | 11 | 6 | | | | | 1 |
| 13 | Төв | Батсүмбэр | | | 1 | 1 | | | 1 |
| 14 | Хөвсгөл | Эрдэнэбулган | | | 1 | | 1 | | 1 |
| 15 | Хэнтий | Биндэр | 2 | | | | 2 | | 1 |
| 16 | | Жаргалтхаан | 11 | 5 | 2 | | | | 1 |

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралт бусад сумдаас ихтэй, гадаад, дотоодын аялагч ихээр зорчдог, экологийн асуудал хариуцсан байцаагч томилон ажиллуулах шаардлагатай сумдыг харвал:

*Хүснэг*
*т №3*

| д/д | Аймаг | Сум | Тусгай зөвшөөрөл | | Бүртгэгдсэн гэмт хэрэг | | | Зөрчлийн гомдол 2021.02 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хайг | Ашиг | 2018 | 2019 | 2020 | |
| 1 | Баян-Өлгий | Ногооннуур | 5 | 11 | | 1 | 4 | |
| 2 | | Цэнгэл | 7 | 3 | | 3 | 1 | |
| 3 | Говь-Алтай | Бигэр | 10 | 5 | 1 | | 6 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Дундговь | Гурвансайхан | 21 | 11 | | 2 | 4 | |
| 5 | | Өлзийт | 25 | 6 | | 2 | 5 | |
| 6 | Завхан | Завханмандал | 9 | 3 | 1 | | 2 | |
| 7 | | Отгон | | | | | | |
| 8 | Сүхбаатар | Эрдэнэцагаан | 15 | 16 | 1 | | 8 | |
| 9 | | Сүхбаатар | 7 | 23 | | | 1 | 2 |
| 10 | Увс | Сагил | 3 | 2 | | | 4 | |
| 11 | | Түргэн | 2 | 3 | 1 | 3 | 3 | |
| 12 | Ховд | Мянгад | 8 | 8 | | | 3 | |
| 13 | | Цэцэг | 1 | 1 | 1 | 7 | 1 | |

Дээрхи хүснэгтээс харвал хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил бага гардаг хэдий ч гарч болох нөхцөл байдал, сумын нутаг дэвсгэрийн байгалийн баялаг, ан амьтны онцлог, аялал жуулчлалын нягтрал ихтэй байдлыг харгалзан экологийн асуудал хариуцсан байцаагч нэн шаардлагатай байгааг харгалзан үзэх цаг болжээ.

Тухайлбал, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум нь 6,893 хүн амтай, 127,028 га талбайд хайгуулын, 14,618 га талбайд ашиглалтын /молибден, нүүрс, жонш, гянтболд/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 9 гэмт хэрэг бүртгэгдсэн, 2020 онд 6 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Төмстий сэрвээ” гэх газар гар аргаар, хууль бусаар ашигт малтмал олборлох, хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байсан цагдаагийн алба хаагчдын тавьсан шаардлагыг эсэргүүцэн, биед халдсан үйлдэл бүртгэгдсэн, Дарьганга, Асгат сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой албан хаагчийн орон тоог нэмэх шаардлагатай байна.

Түүнчлэн Дундговь аймгийн Гурвансайхан сум нь 2,141 хүн амтай, 54,478 га талбайд хайгуулын, 60,226 га талбайд ашиглалтын /алт, жонш, нүүрс, гантиг/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 6 гэмт хэрэг бүртгэгдсэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил сумдтай хил залгаа оршдог нь эдгээр сумдыг хариуцан ажиллах экологийн асуудал хариуцсан байцаагч ажиллуулах шаардлага бий болсон байна.

2020 онд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Нийслэлийн байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Туул голын сав газрын захиргаатай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын бичил уурхайн нэгдсэн “Дээвэр” холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг”

байгуулан, хэрэгжилтийг хангах чиглэлээр нэлээдгүй ажлыг хийж гүйцэтгэсэн ч хөдөө орон нутагт дээрхи ажлууд хүссэн үр дүнд хүртэл зохион байгуулагдаж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

**Дүгнэлт.** Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр олон ажил, арга хэмжээ зохион байгуулж байгаа хэдий ч орон нутагт хүссэн үр дүнд хүртэл ажиллаж чадахгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэ нь байгалийн баялаг ихтэй, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг гардаг сумдыг хариуцсан экологийн асуудал хариуцсан байцаагчийн орон тоо дутагдалтай, тухайн газар, нутаг дэвсгэрт хүрч шуурхай ажиллах боломж хязгаарлагдмал байгаатай салшгүй холбоотой гэж үзэж байна.

**Санал**: Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Аймаг дахь цагдаагийн газар хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авах; /хүснэгт №1/

*Тухайлбал: Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Цэнгэл сум, Говь-Алтай аймгийн Бигэр сум, Дундговь аймгийн Гурвансайхан, Бигэр сум, Завхан аймгийн Завханмандал, Отгон сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сум, Увс аймгийн Сагил, Түргэн сум, Ховд аймгийн Мянгад, Цэцэг сум зэрэг нийт 7 аймгийн 13 суманд экологийн асуудал хариуцсан байцаагчийн орон тоог шийдвэрлэж, зэргэлдээ сумдын нутаг дэвсгэрийг давхар хариуцах боломжийг бүрдүүлэх;*

2. Хөдөө орон нутгийн Экологийн асуудал хариуцсан байцаагчид нэн шаардлагатай дэвшилтэд техник хэрэгслээр хангах асуудлыг судалж, хангах ажлыг олон улсын байгууллагын санхүүжилтээр шат дараатай шийдвэрлэх;

*Тухайлбал: бага оврын нисдэг тэрэг, алсын зайн дрон гэх мэт*

3. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4. Стратегийн томоохон ордууд дээр гэрээт экологийн асуудал хариуцсан байцаагчийн орон тоо бий болгож, үйлдвэрийн үйл ажиллагаанд нь хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Хавсралт №1

| № | Орон тоо шаардлагатай аймаг, сумд |
|---|---|

| | Аймаг | Сум |
|---|---|---|
| 1. | Баян-Өлгий аймаг | Ногооннуур сум нь 6,424 хүн амтай, Оросын Холбооны Улсын Тува улстай хил залгаа оршдог, 20,468 га талбайд хайгуулын, 2,566 га талбайд ашиглалтын /мөнгө, гянтболд, зэс/ тусгай зөвшөөрөл олгогдсон, ирвэс, чоно, үнэг, хярс, аргаль, угалз, янгир, тарвага, бүргэд, ёл, тас, харцага, хойлог зэрэг ан амьтантай Цагааннуур, Алтанцөгц сумдтай хил залгаа учир эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 2. | | - Цэнгэл сум нь 9,690 хүн амтай, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хил залгаа оршдог, 26,542 га талбайд хайгуулын, 2,685 га талбайд ашиглалтын /гянтболд, алт/ тусгай зөвшөөрөл олгогдсон, Алтайн нурууны эх Таван богд уул, байгалийн үзэсгэлэнт газар ихтэй тул гадаад дотоодын жуулчид ихээр зорчдог, мөн ан, амьтан ихтэй, Улаанхус, Сагсай сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 3. | Говь-Алтай аймаг | Бигэр сум нь 2,253 хүн амтай, 61,177 га талбайд хайгуулын, 4,928 га талбайд ашиглалтын /алт/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 7 гэмт хэрэг бүртгэгдсэн, Дэлгэр, Халиун, Чандмань, Эрдэнэ, Цогт сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 4. | Дундговь аймаг | Гурвансайхан сум нь 2,141 хүн амтай, 54,478 га талбайд хайгуулын, 60,226 га талбайд ашиглалтын /алт, жонш, нүүрс, гантиг/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 6 гэмт хэрэг бүртгэгдсэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 5. | | - Бигэр сум нь 2,406 хүн амтай, 60,555 га талбайд хайгуулын, 2,013 га талбайд ашиглалтын /алт/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 7 гэмт хэрэг бүртгэгдсэн, Хулд, Луус сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 6. | Завхан аймаг | Завханмандал сум нь 1,097 хүн амтай, 54,478 га талбайд хайгуулын, 60,226 га талбайд ашиглалтын /алт, жонш, нүүрс, гантиг/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 3 гэмт хэрэг бүртгэгдсэн, Ургамал, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой, Эрдэнэхайрхан суманд Улаагчны хар нуур, Мухартын гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газар оршдог тул гадаад, дотоодын жуулчид ихээр ирдэг; |
| 7. | | - Отгон сум нь 2,619 хүн амтай, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй, Отгонтэнгэр хайрхан, Бадархундага нуур байрладаг бөгөөд гадаад, дотоодын жуулчид ихээр ирдэг, 2018 онд Бадархундага нуураас 279 ширхэг мөнгөн аяга авсан этгээдүүд хойшоос нь хөөсөн иргэдийг ТОЗ-8 маркийн буугаар буудаж, хүндэвтэр гэмтэл учруулсан гэмт хэрэг үйлдэгдэж байсан, Шилүүстэй, Цагаанхайрхан сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 8. | Сүхбаатар аймаг | Эрдэнэцагаан сум нь 6,893 хүн амтай, 127,028 га талбайд хайгуулын, 14,618 га талбайд ашиглалтын /молибден, нүүрс, жонш, гянтболд/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 9 гэмт хэрэг бүртгэгдсэн, 2020 онд 6 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Төмстий сэрвээ” гэх газар гар аргаар, хууль бусаар ашигт малтмал олборлох, хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байсан цагдаагийн алба хаагчдын тавьсан шаардлагыг эсэргүүцэн, биед халдсан үйлдэл бүртгэгдсэн, Дарьганга, Асгат сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 9. | | - Сүхбаатар сум нь 3,505 хүн амтай, 15,113 га талбайд хайгуулын, 26,622 га талбайд ашиглалтын /нүүрс, алт, зэс, төмөр, цайр, жонш/ тусгай зөвшөөрөл |

| | | |
|---|---|---|
| | | олгогдсон, 2020 онд хүрээлэн байгаа орчны эсрэг 1 гэмт хэрэг, 2021 оны эхний 2 сард зөрчлийн шинжтэй 2 үйлдэл бүртгэгдсэн, Айраг, Улбаян сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 10. | Увс аймаг | Сагил сум нь 2,483 хүн амтай, 9,519 га талбайд хайгуулын, 153 га талбайд ашиглалтын /алт/ тусгай зөвшөөрөл олгогдсон, Аргал, угалз, янгир, ирвэс, гахай, зэрэг зэрлэг ан амьтантай, 2020 онд хүрээлэн байгаа орчны эсрэг 4 гэмт хэрэг бүртгэгдсэн, Давст сумтай хил залгаа оршдог тул хариуцан ажиллах боломжтой; |
| 11. | | - Түргэн сум нь 2,078 хүн амтай, 1,612 га талбайд хайгуулын, 2,321 га талбайд ашиглалтын /алт, төмөр/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 7 гэмт хэрэг бүртгэгдсэн, Бөхмөрөн сумтай хил залгаа оршдог тул хариуцан ажиллах боломжтой; |
| 12. | Ховд аймаг | Мянгад сум нь 3,693 хүн амтай, 16,399 га талбайд хайгуулын, 3,018 га талбайд ашиглалтын /алт, ховор металл/ тусгай зөвшөөрөл олгогдсон, Хар-Ус нуурын байгалийн цогцолбор Улсын Тусгай хамгаалалттай 5.412 га талбайтай, 2020 онд хүрээлэн байгаа орчны эсрэг 3 гэмт хэрэг бүртгэгдсэн, Эрдэнэбүрэн, Ховд, Буянт, Дөргөн сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой; |
| 13. | | - Цэцэг сум нь 3,166 хүн амтай, 2,041 га талбайд хайгуулын, 447 га талбайд ашиглалтын /алт/ тусгай зөвшөөрөл олгогдсон, сүүлийн 3 жилийн хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг 8 гэмт хэрэг бүртгэгдсэн, Дарви, Мөст, Зэрэг сумдтай хил залгаа оршдог тул эдгээр сумдыг хариуцан ажиллах боломжтой байна. |

## ЦАГДАА-ОЛОН НИЙТИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

# ОРЧИН ЦАГИЙН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ИМИДЖ

**Дугарын Бат-Эрдэнэ,**
*Цагдаа судлалын магистрант,*
*Цагдаагийн хошууч*

**Товчлол.** Өнөөгийн Монголын нийгэмд цагдаагийн алба хаагчийн болоод байгууллагын имидж хэрхэн үнэлэгдэж байгаа талаар болон түүнийг эерэг талаас хэрхэн түгээх талаар судлаачийн байр сууринаас өөрийн үзэл бодлоо энэхүү өгүүлэлд тусгасан болно. Тодорхой үр дүнтэй үйл ажиллагаа, зорилтот арга хэмжээг зохион байгуулах талаар өөрийн саналаа гаргаж өгснөөр тухайн тулгамдаж буй асуудлыг илтгэлээрээ дамжуулан шийдэх арга замыг тодорхойлж өгөх ач холбогдолтой гэж үзэж байна.

**Түлхүүр үг**
- Анализ – бүхэл зүйлийг түүний бүрэлдэхүүн хэсэг нэгжид нь сэтгэхүйдээ салган хуваах задлах үйл явц
- Синтез – танин мэдэгдсэн нэгж, салангид хэсгүүдийг нэг цогцод оруулан сэргээн холбож, нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл
- Имидж- шинж төрх, нэр хүнд
- Байгууллагын имидж - хамт олны шинж төрх, нэр хүнд, нийгэмд эзэлж буй байр суурийн тухай ойлголт

**Үндсэн хэсэг.** Орчин үед хүмүүс "имидж" гэх үгийг ямар нэгэн орчуулгагүйгээр тодорхой хэмжээнд ойлгодог болжээ. Түүгээр ч барахгүй олны өмнө ил байдаг урлаг, спорт, улс төрчдийн тухай болон имиджийнх нь талаар ам уралдан ярих дуртай. Чухамдаа “Имидж” гэдэг нь шинж төрх, нэр хүнд гэсэн утгатай англи үг. Тиймдээ ч хүний гадаад дүр төрх болон дотоод сэтгэл зүйн өвөрмөц шинж, онцлог байдлын илэрхийлэл болдог байна.

Зөвхөн үс засалт, хувцаслалтаар тогтохгүй өөрийгөө илэрхийлэх чадвар болон бусдад төрүүлсэн сэтгэгдлийн нийлбэр нь имидж болдог. Нөгөө талаас имидж нь тухайн хүнд өгч байгаа бусдын үнэлэлт юм. Тэгэхээр имидж гэдэг асуудал нь нэр хүндээс илүү өргөн хүрээтэй ойлголт гэж хэлж болох байна. Хувь хүний имиджээс гадна хамт олон, байгууллага нэгж, цаашлаад улс үндэстний имидж гэх асуудал яригддаг. Яг үүнтэй адилаар Цагдаагийн алба хаагчдын имиджийн асуудал яригддаг нь Цагдаагийн алба хаагчид өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахдаа хувцаслалт, биеэ авч яваа байдал, иргэдтэй харьцаж буй харилцааны соёл зэрэг олон зүйлээс шалтгаалан иргэд дундах Цагдаагийн алба хаагчийн имидж буюу үнэлэмжийн

асуудал байдаг бөгөөд энэ нь эерэг болон сөрөг талаас буурах, өсөх хандлагатай байдаг.

Тэгвэл цагдаагийн алба хаагчийн болон байгууллагын имидж нь хэрхэн бүрэлдэн тогтож иргэд, олон нийтэд түгдэг талаар, өнөөгийн Монголын нийгэмд цагдаагийн алба хаагчийн имидж хэрхэн тодорхойлогдож байгаа талаар, хэрхэн эерэг талаас цагдаагийн алба хаагчийн имиджийг түгээх тухай асуудал дэвшүүлэн судалгаа хийж асуудлыг шийдвэрлэх талаас миний бие санал дэвшүүлэхийг зорилоо.

"Имидж" хүмүүс энэ үгийг ямар нэгэн орчуулгагүйгээр тодорхой хэмжээнд ойлгодог болжээ. Түүгээр ч барахгүй олны өмнө ил байдаг урлаг, спорт, улс төрчдийн тухай болон имиджийнх нь талаар ам уралдан ярих дуртай. Чухамдаа “Имидж” гэдэг нь шинж төрх, нэр хүнд гэсэн утгатай англи үг. Тиймдээ ч хүний гадаад дүр төрх болон дотоод сэтгэл зүйн өвөрмөц шинж, онцлог байдлын илэрхийлэл болдог байна. Зөвхөн үс засалт, хувцаслалтаар тогтохгүй өөрийгөө илэрхийлэх чадвар болон бусдад төрүүлсэн сэтгэгдлийн нийлбэр нь имидж болдог. Нөгөө талаас имидж нь тухайн хүнд өгч байгаа бусдын үнэлэлт юм. [120]

Хэн нэгэнтэй уулзахад ердөө л эхний дөрвөн секундэд имиджийн эхний сэтгэгдэл төрнө. Гэтэл энэ хугацаа хоёр хүн зөвхөн гар барих, амар мэндээ мэдэх төдийд л өнгөрнө. Тэгэхээр хүний нэр, яриа, хувцаслалт зэрэг нь эзнээ юунаас ч өмнө илэрхийлчихдэг гэсэн үг. Ер нь хүмүүсийн имиджийг бүрдүүлж буй зүйлд гэр орон, ажлын байр, нийгэмтэйгээ харилцаж буй өөрийн хүрээлэл хүртэл ордог байна. Хүн бүр өөрийн имиджтэй байдаг. Зөвхөн нэртэй цуутай хүмүүсийн хүрээнд ойлгож болохгүй. Нийгэмд байр суурь эзлэх, сайхан амьдрахыг хүсдэг жирийн нэгнээс улс төр, урлаг, эдийн засаг, бизнесийн салбарын хүмүүст хамаарах өргөн ойлголт.[121]

Сэтгэл судлаач Жерард Неренберг хэлэхдээ, “Юу ярьж байгаа нь чухал биш, яаж ярьж байгаа нь чухал. Хүмүүсээс гарах хөдөлгөөн, алхаа гишгээ, сууж буй байрлал нь ч тухайн хүний имидж болж байдаг”[122] гэжээ.

Тэгэхээр имидж гэдэг асуудал нь нэр хүндээс илүү өргөн хүрээтэй ойлголт гэж хэлж болох байна. Хувь хүний имиджээс гадна хамт олон, байгууллага нэгж, цаашлаад улс үндэстний имидж гэх асуудал яригддаг. Тухайлбал Ирланд хүмүүс харамч, Герман хүмүүс арвич нямбай, Еврэй хүмүүс ухаантай гэх мэтчилэн. Гэлээ гээд Ирланд хүмүүс бүгд харамч, Герман хүмүүс бүгд арвич нямбай, Еврэй хүмүүс бүгд ухаантай гэсэн үг биш бөгөөд тэнэг Еврэй хүн байж л таараа. Үүнээс үзэхэд имидж гэдэг нь бас нэг талаар харьцангуй ойлголт гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл Еврэй хүмүүс дундаас суут ухаантан, философич, гайхалтай нээлтүүдийг хийсэн эрдэмтэд их байдаг тул Еврэй хүмүүсийг харах хүмүүсийн өнцөг нь Еврэй хүмүүс ухаантай гэсэн имиджийг бүрдүүлсэн учир хүмүүс Еврэйчүүд ухаантай гэж ярьдаг.

Яг үүнтэй адилаар Цагдаагийн алба хаагчдын имиджийн асуудал яригддаг нь Цагдаагийн алба хаагчид өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахдаа хувцаслалт, биеэ авч яваа байдал, иргэдтэй харьцаж буй харилцааны соёл зэрэг олон зүйлээс

[120] www.Naver.com
[121] www.Naver.com
[122] www.wikipedia.com

шалтгаалан иргэд дундах Цагдаагийн алба хаагчийн имидж буюу үнэлэмж буурах өсөх асуудал яригддаг. Үүнийг даган дийлэнх алба хаагчийн имиджээс үүдэн байгууллагын нэр хүнд, иргэд дунд эзлэх байр суурь, иргэдийн хандлага зэрэг маш өргөн хүрээтэй ойлголт юм.

Тэгвэл имидж нь хэрхэн бүрэлдэн тогтож иргэд, олон нийтэд түгдэг бэ? Цагдаагийн алба хаагчийн имидж нь ихэвчлэн иргэд асуудал гаргаад цагдаагийн байгууллагад хандах, аль эсхүл ямар нэгэн зөрчил гаргаж саатуулагдах, цагдаагийн алба хаагчаас ямар нэгэн туслалцаа авах /зам асуух/ гэх мэт тодорхой хэмжээгээр харилцаа үүсгэн хоромхон хугацааны дотор ямар нэгэн сэтгэгдлийг өөртөө үлдээдэг. Энэ мэтчилэн хувь хүнд үлдсэн энэхүү имидж төсөөллүүдийн нийлбэр нь Монголын нийгэм дэх Цагдаагийн алба хаагчдын имидж, дүр төрх, нэр хүндийг илэрхийлдэг гэсэн үг бөгөөд цаашлаад байгууллагын нэр хүндийн асуудал яригдана гэсэн үг юм. Би тодорхой хэмжээний судалгааг авч үзэхэд Цагдаагийн алба хаагчдын имидж иргэд олон нийтэд дараах байдлаар бий болдог. Тухайлбал:

**а/ Иргэд цагдаагийн алба хаагчидтай харьцахад үлдэх сэтгэгдэл.**

Цагдаагийн алба хаагч бүр иргэдтэй харилцахдаа хүн болгон харилцан адилгүй зан төлөвийг үзүүлж байдаг. Тухайлбал эрүүгийн мөрдөгч иргэнийг сэжигтнээр татаж, таслан сэргийлэх арга хэмжээ авах, дүрэм зөрчсөн жолоочид торгуулийн арга хэмжээ ногдуулах гэх мэт үйл ажиллагаанд тухайн иргэнд эерэг сэтгэгдэл төрүүлэх нь хэцүү бөгөөд ихэвчлэн сөрөг сэтгэгдэл үлдээдэг. Үүнтэй адилаар хөгжлийн бэрхшээлтэй болон хөгшин хүнийг зам хөндлөн гаргаж өгөх, жолоочид хариуцлага оногдуулахгүйгээр сануулан явуулах, иргэдэд туслах, нийгмийг цочроосон хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоон баривчлах, сайн үйлсийн аян зохион байгуулах гэх мэт явдал нь иргэдэд эерэг сэтгэгдэл төрүүлэх тохиолдох нь элбэг байдаг. Ихэвчлэн иргэдтэй харьцаж буй зан төлөв, харилцааны соёл, гаднах төрх гэх мэт олон зүйлсээс шалтгаалж энэхүү имидж нь бүрдэж байдаг. Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагын имидж нь хамгийн анхан шатны иргэдтэй хамгийн ойр байж харьцдаг замын цагдаа, хөдөлгөөнт эргүүлийн алба хаагчдаас Монголын цагдаагийн нэр, төр, үнэлэмж тодорхойлогдож байна гэсэн үг юм.

**б/ Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлэх үед**

Цагдаагийн алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ мэдээч хэрэг шуурхай тасралтгүй байх ёстой гэсэн хэдий ч  цагдаагийн байгууллага нь хязгаартай байдаг. Цагдаагийн байгууллага дуудлага мэдээлэл хүлээж аван шуурхай хэргийн газарт очсон ч гэсэн гэмт хэрэг, зөрчил аль хэдийн үйлдэгдэж гэм буруутай этгээд хэргийн газраас зугтсан байх тохиолдол нэлээдгүй байдаг. Энэ үед хохирогч этгээд нь буруутай этгээдийг олж тогтоож хохиролгүй болгож өгөхийг хүсэхээс гадна тодорхой хэмжээний сэтгэл санааны болон бусад дэмжлэг туслалцааг хүсэж байдаг энэ үед хохирогчид үлдээсэн сэтгэгдэл нь мөн л адил энэхүү имиджийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

**в/ Замын хөдөлгөөнд оролцох үед**

Автомашин иргэдийн хувьд хэрэглээ болсон энэ үед замын хөдөлгөөний ачаалал их, зам тээврийн осол, хэрэг ихээр үйлдэгдэж буй энэ үед замын хөдөлгөөн

зохицуулах, хянан, шалгах үүрэг бүхий замын цагдаагийн алба хаагчид бусад алба, нэгжээс илүүтэйгээр иргэдтэй хамгийн ихээр харилцаж байдаг билээ. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн иргэд өөр хүмүүс бүгд дүрэм зөрчиж байхад ганцхан намайг саатуулан арга хэмжээ ногдууллаа, торгууль ихээр хийж улсын төсвийг бүрдүүлэх гэлээ гэсэн буруу, ташаа ойлголт иргэдэд үлдээж болохгүй нь маш чухал бөгөөд үүнд харилцааны ур чадвар маш чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэр цагдаагийн байгууллагын нүүр царай нь Замын цагдаагийн алба хаагчид юм. Өнөөдөр Монголын нийгэмд Цагдаагийн алба хаагчид том жийптэй хүнийг яаж ч чадахгүй хирнээ ядарсан иргэдэд хатуу ханддаг гэх мэт имидж нэлээдгүй тархсан нь нууц биш.

**г/ Мэдээлэлтэй байж иргэдэд мэдээлэл өгөх**

Алба хаагчид УИХ, Засгийн газраас шинээр батлагдан мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын талаар мэдээлэлтэй байх нь чухал. Өөрөөр хэлбэр гудамж замд эргүүл, хяналт хийж буй замын цагдаагийн алба хаагчаас иргэд энэ төрлийн мэдээллийг авахыг хүсдэг гэсэн үг юм. Тиймээс алба хаагчдыг мэдээллээр хангаж байх нь чухал гэсэн үг бөгөөд иргэд ямар нэг зүйл асуухад мэдэхгүй байх нь цагдаагийн байгууллагын имидж бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх магадлал их гэсэн үг юм.

**д/ Цагдаагийн хэлтэс, тасаг, нэгжийн байрны тохижилт**

Иргэд ямар нэгэн байдлаар цагдаагийн хэлтсээр үйлчлүүлэх үед иргэдэд үлдэх сэтгэгдэл нь Цагдаагийн байгууллагын имиджэд чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал цагдаагийн хэлтсийн байраар орох үед бохир, заваан, эмх цэгцгүй байх, хүлээлгийн өрөө, сандал байхгүй байх гэх мэт нь цагдаагийн байгууллагын нэр хүндэд халтай гэсэн үг юм.

**е/ Ойр дотнын хүний үзэл бодол**

Өөрөө ямар нэгэн байдлаар цагдаатай харилцаж үзээгүй эсхүл ямар нэгэн байдлаар цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж үзээгүй хүмүүс өөрийн ойр дотно, найз нөхөд, төрөл садны хүний яриа, хэвлэл мэдээллийн байгууллага, цахим ертөнцөөс цагдаагийн байгууллагын тухай ойлголт авах нь элбэг байдаг. Энэ нь цахим орчинд иргэд үзэл бодол, бухимдлаа илэрхийлэхэд цагдаатай ямар нэгэн байдлаар огт харилцаж үзээгүй хүн мэдээлэл аван ямар ч шалтгаангүйгээр цагдаагийн байгууллага, алба хаагчийг үзэн ядах сөрөг ойлголт авч болдог гэсэн үг юм. Үүнийг үзэхэд имидж гэдэг зүйл нь хувь хүн бүрд үлдээсэн жижиг сэтгэгдлийн нийлбэрийг тухайн хувь хүн, байгууллагын имидж гэж хэлж болно.

**ё/ Хэвлэл мэдээлэл**

Цагдаагийн алба хаагчид нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлах эрх, үүрэгтэй байдаг тул үргэлж хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд гол бай байх нь элбэг байдаг. Эерэг талаар ч тэр сөрөг талаар байсан ч энэ нь иргэд, олон нийтэд хамгийн ихээр нөлөөлдөг. Өөрөөр хэлбэр хэвлэл мэдээллийн байгууллага иргэдийн анхаарлыг татаж хандалт ихтэй мэдээ бэлтгэхийн тулд

цагдаагийн байгууллага, алба хаагчийн алдаа дутагдал, хууль зөрчсөн зарим асуудлаар мэдээ, мэдээлэл бэлтгэх хандлага ажиглагддаг.

**ж/ Гадаад төрх**

Цагдаагийн алба хаагчийн гадаад төрхөөр тухайн алба хаагчийг үнэлэх асуудал яригддаг. Жишээлбэл дүрэмт хувцас, энгэрийн тэмдэг, ялгах тэмдэг, агсамж, тусгай хэрэгслийн бүрдэл, галт зэвсэг, цагдаагийн тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглогдсон тээврийн хэрэгсэл, богино долгионы станц зэрэг маш олон зүйлсээс хамаарч мөн Цагдаагийн алба хаагчийн имидж бүрддэг.

Тухайлбал: Энгийн машинаас үс нь өрвийсөн, халтар хувцастай, ямар нэгэн хантааз болон агсамж, тусгай хэрэгсэл юу ч байхгүй хүн бууж ирээд иргэдэд шаардлага тавихад хэрхэн хүлээн авч шаардлагыг биелүүлэх бол? Эсрэгээрээ алаг тэрэгнээс дүрэмт хувцсаа дүрмийн дагуу өмссөн, агсамж тусгай хэрэгслээ бүрэн зүүсэн алба хаагч бууж ирэн шаардлага тавихад хэрхэн яаж хүлээж авах бол? Энэ талаар туршилт хийж үзэхэд үр дүн нь тодорхой харагдана.

Мөн бас нэг сонирхолтой баримт байдаг нь цагдаагийн алба хаагчийн имидж бүрдүүлэхэд чухал нэг зүйл байдаг нь галт зэвсэг юм. Галт зэвсэг агссан алба хаагчийг иргэд хараад эмээдэг, шаардлагыг нь эсэргүүцэх юм бол болохгүй шүү гэсэн байдлаас хардаг гэсэн үг юм.

**3. Боловсрол, мэдлэг чадварын асуудал**

Цагдаагийн алба хаагчдын мэдлэг чадварын асуудал шалгагдаж байгаа хүнийхээ үгэнд баригдсан зөв бичгийн дүрмийн алдаатай бичдэг, шивж чаддаггүй гэх мэт хамгийн наад захын жижигхэн зүйлээр алба хаагчдын имидж сөрөг талаар үлдэж байдаг. Тиймээс алба хаагчдын мэдлэг чадвар, Компьютер технологи, Цахим гэмт хэрэг, Цахим мөнгө, орчин цагийн гэмт хэргийн нөхцөл байдал хувьслын, талаар сургалтыг түлхүү явуулах шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагын имидж нь алба хаагчдын имиджээс бүрдэх ба энэ нь харьцангуй өргөн ойлголт юм. Өнөөдөр хүмүүс "Цагдаа" гэх үгийг сонсоод толгойд нь юу буудаг бэ? гав, бороохой, торгууль гэж боддог. Өөрөөр хэлбэр бид иргэдэд ийм сэтгэгдлийг төрүүлж энэхүү имиджийг бүрдүүлсэн байна гэсэн үг юм. Өнөөгийн Цагдаагийн байгууллагын имидж ямар төвшинд байгаа бэ? Эерэг тал нь давамгай юу, Сөрөг тал уу? Та бүхэн хэлүүлэлтгүй гадарлаж байгаа байх.

Цагдаагийн алба хаагчидтай холбоотойгоор өнөөдрийн нийгэмд цахим орчинд иргэд уур бухимдлаа илэрхийлэх нь ихэсжээ. Дуртай иргэн нь цагдаагийн алба хаагчтай маргах юм уу өөрт шударга бус санагдсан тохиолдолд утсаа гаргаж ирэн бичлэг хийн Фейсбүүкт байрлуулна хэмээн сүрдүүлэх хандлага нэгэнт тогтож бий болсон байна. Өөрөөр хэлбэр иргэд цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдлыг хариуцсан газарт нь өргөдөл гаргахаас илүүтэй Фейсбүүкт байрлуулж алба хаагчдын нэр хүндэд халдах зорилгоор олон нийтэд мэдээлэлж байна гэсэн үг юм. Үүний улмаас бидний имидж, дүр, төрх нийгэмд сөрөг талаасаа давамгайлах илүү их магадлал өндөртэй байна гэсэн үг юм.

Цагдаагийн байгууллагын имидж нь алба хаагчдын имиджээс бүрдэх ба энэ нь харьцангуй өргөн ойлголт юм. Өнөөдөр хүмүүс "Цагдаа" гэх үгийг сонсоод

толгойд нь юу буудаг бэ? гав, бороохой, торгууль гэж боддог. Өөрөөр хэлбэр бид иргэдэд ийм сэтгэгдлийг төрүүлж энэхүү имиджийг бүрдүүлсэн байна гэсэн үг юм. Өнөөгийн Цагдаагийн байгууллагын имидж ямар төвшинд байгаа бэ? Эерэг тал нь давамгай юу, Сөрөг тал уу? Та бүхэн хэлүүлэлтгүй гадарлаж байгаа байх.

Та бүхэнд би имиджийн талаар ойлголтыг ярихдаа тодорхой дурдсан билээ. Цагдаагийн алба хаагчийн имидж хэрхэн бүрэлдэн бий болж үнэлэгддэг талаар. Энэ нь дийлэнх хэсэг нь алба хаагчийн харилцааны хандлага, ажилдаа чин сэтгэлээсээ хандах хандлага, мэдлэг, мэдээлэлтэй байж байнга өөрийгөө дайчлан сурч боловсрох асуудлууд нь бүгд алба хаагчийн хувийн шинж чанар, хандлага бөгөөд тухайн хүнийг төлөвшилдээр тогтсон зүйл гэж хэлж болно.

"Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа" хэмээх Монгол ардын зүйр цэцэн үг байдаг та бүхэн мэдэж байгаа байх. Өөрөөр хэлбэл бие хүний хөгжил нь багаасаа өөрийн өсөж торниж буй орчноос хамаарч төлөвшдөг. Тийм атал бид 2 цагийн ажилсаг, хөдөлмөрч байх талаар лекц тавиад багаасаа залхуу хойрогдуу өссөн хүнийг ажилсаг, хөдөлмөрч болгож төлөвшүүлж чадах уу? чадахгүй. Тэгвэл бид сургалт соён гэгээрүүлэх ажлыг хувь хүний төлөвшил талруу түлхүү чиглүүлж энэ төрлийн урт болон богино хугацааны сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

**Боловсон хүчний зөв бодлого баримтлах**

Хувь хүний хандлага төлөвшлийг бид амархан өөрчилж чадахгүй энэ бол харьцангуй өргөн ойлголт учир бид анхнаас нь боловсон хүчний зөв бодлого баримталж анх цагдаагийн байгууллагын сонгон шалгаруулалтад хамрагдаж буй иргэдийг маш нарийн судалж, сонгон шалгаруулж элсүүлэх шаардлагатай.

Өнөөдөр бидний сонгон шалгаруулалт эрүүл мэнд, бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд гэсэн хэдхэн төрлийн цензур тавин элсүүлж байна. Бид хувь хүний төлөвшлийг амархан өөрчилж чадахгүй учир анхнаасаа зөв боловсон харьцаатай, сурч мэдэх арвин их хүсэл тэмүүлэлтэй бие хүн болон төлөвшсөн хүнийг сонгон шалгаруулж элсүүлэх нь чухал асуудал юм. Өөрөөр хэлбэл сонгон шалгаруулалтад энэ төрлийн тусгай шаардлагыг тавин хувь хүний төлөвшлийг тодорхойлж элсүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

**Орчин цагтайгаа хөл нийлүүлсэн мэдлэг, чадвартай цагдааг бий болгох асуудал.**

Орчин цагт иргэд ямар цагдаатай байхыг хүсдэг вэ? Хуучин нийгмийн үзэл суртлын сэргийлэх, Богд хаант Монгол улсын үеийн арван тавны цагдаа юу? Өнөөдөр харанхуй бүдүүлэг, чулуун зэвсгийн үе биш хүний эрх, эрх чөлөөг хангасан, шударга, зарчимч, техник технологи, мэдээллийн хэрэгсэл маш ихээр хөгжсөн 21-р зуунд иргэд, олон нийт хүнлэг, энэрэнгүй, итгэлтэй, хүчирхэг, боловсролтой мөн гагцхүү чадварлаг, орчин үетэйгээ хөл нийлүүлсэн цагдаатай байхыг хүсдэг.

Мэдээллийн аюулгүй байдал нэн тэргүүнд тавигдаж инноваци, хамтын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн 4-р хувьсал, хиймэл оюун ухаан, Дрон, "Big data-Их өгөгдөл" зэрэг орчин үеийн техник, технологи болон тэдгээрээс үүдэн гарч болох

эрсдлээс урьдчилан сэргийлсэн, энэ төрийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд бэлэн цагдаатай байхыг хүснэ.[123]

Мөн орчин үед уламжлалт гэмт хэргүүд болох /хулгай, дээрэм, залилан мэхлэх, хүчиндэх г.м/ бүхий л гэмт хэргүүд цахим орчноор дамжин үйлдэгдэж хувьсан өөрчлөгдөж байна. Мөн цахим мөнгө, интернэт банк, мобайл банк зэрэг үйлчилгээнүүд иргэдийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрэн үүнийг даган цахим эдийн засгийн эсрэг гэмт хэргүүд ихээр гарч байна. Үүнд бид бэлэн үү нийгэм өөрчлөгдөж байна та бид хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

Өнөөдөр дүүрэг дэх Цагдаагийн хэлтсүүдийн эрүүгийн мөрдөгч нар цахим гэмт хэргийг шалгаж буруутай этгээдийг олж тогтоон илрүүлэх чадвартай алба хаагч хир их байгаа бол? Нийгэм өөрчлөгдөж байна бид бас үүнийг даган хувьсан өөрчлөгдөх шаардлагатай байна. Тиймээс бид цахим гэмт хэрэгтэй тэмцэх, мэдээлэл холбооны технологийн талаар сургалтыг чанартай зохион байгуулах, цаашлаад энэ чиглэлээр сурч боловсрох хүсэл сонирхолтой алба хаагчдыг байгууллагаас тодорхой хэмжээгээр дэмжин ажиллах хэрэгтэй байна.

Өнөөдөр намайг хувиараа өөрийн халааснаас мөнгөө гарган мэдээлэл холбооны технологи өндөр хөгжсөн Япон, БНСУ-д энэ чиглэлээр их, дээд сургуульд суралцах хүсэлт гаргавал манай удирдлага юу гэж хариулах бол? Ажлаа өгөөд яв гэх байх тийм атал Цагдаагийн алба хаагч хугацаа алдаж гадны улсруу сурч боловсрохоор явах сонирхолгүй болно. Тиймээс ЦЕГ-аас тал дээр анхаарч тодорхой хэмжээний бодлого баримтлан ажиллаж чадвал бидний өнөөдрийг харсан бодлогоос илүүтэйгээр ирээдүйг харсан зөв бодлого юм болвуу.

Иргэд олон нийтэд Цагдаагийн алба хаагчийн болоод байгууллагын имиджийг эерэг талаас бүрдүүлэхэд хамгийн хүчтэй зэвсэг болох хэвлэл мэдээллийн байгууллагыг түшиглэн зохион байгуулдаг хэдий ч энэ нь хангалтгүй байгаа юм. Өөр бусад өндөр хөгжилтэй улсууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр энтертаймент реалити шоуг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал:
"Өгөөшний автомашин" реалити шоуны хэсэг 2007-2012

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд энтертаймент аргыг хамгийн өргөнөөр ашигладаг улс бол АНУ юм. Тэд автомашины хулгайтай тэмцэхийн тулд "bait car" буюу "Өгөөшний автомашин" гүйцэтгэх ажлын комбинац-ыг реалити шоу болгон улс орон даяар цацаж хүмүүсийн нэлээдгүй хандалтыг авч чадсанаар тус улсад дэл сул автомашиныг уг телевизын шоу өгөөшний автомашин юм биш биздээ хэмээн болгоомжилсноор уг төрлийн гэмт хэргийг 40% хүртэл бууруулж чадсан нь урьдчилан сэргийлэх, албаны үйл ажиллагааг сурталчлахад реалити шоуны арга ямар их үр дүнтэй бэ гэдгийг харуулж чадсан.

"Хурд хэтрүүлэгч" реалити шоуны хэсэг 2012-2015 он

АНУ-ын "Tru" Тв-ээс хөтлөн явуулсан замын хөдөлгөөний дүрэм зөрчигчидтэй цагдаагийн алба хаагчид хэрхэн тэмцэж буй талаар өгүүлэх тус цуврал реалити нэвтрүүлэг нь зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэхээс гадна

[123] www.Naver.com

цагдаагийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны зовлон жаргал, тулгарч байдаг харамсалтай болон хөгжилтэй явдлуудыг энтертайнмент аргаар маш гоёор найруулан хийж олны хүртээл болгож чадсан. Тус нэвтрүүлгийн тусламжтайгаар Цагдаагийн алба хаагчдын имиджийг эерэг талаас нь харуулж чадсан нэвтрүүлэг болсон.

Бид үүнтэй адилаар “Хулганын хавх”, "Өгөөшний байшин" гэх мэт нэртэй өөрсдийн гэсэн онцлог нэвтрүүлгийг хийлгэж болохгүй гэж үү?. Монголд хамгийн ихээр үйлдэгдэж буй халаасны хулгай, орон байрны хулгайн гэмт хэрэгтэй Цагдаагийн алба хаагчид хэрхэн тэмцэж хулгайчдыг олж тогтоон илрүүлж буй талаар нэвтрүүлгийг бэлтгэж хүргэх хэрэгтэй. Хамгийн гол нь үзэгчдийн анхаарлыг татсан энтертаймент цуврал шоу хийж албаны үйл ажиллагааг эерэг талаас нь сурталчлах хэрэгтэй.

Би нэг жишээ дурдъя. ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвын дарга нь 2020 оны 10 дугаар сард МҮОНРТ-д "Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2020" аян амжилттай зохион байгуулагдлаа гэх ярилцлага зэргээс илүүтэйгээр хуучний "Зөн билгийн тулаан" нэвтрүүлгээр гарсан Баянзүрх дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэж буй байдал болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочийг хараад л илрүүлж байгаа нь алба хаагчийн ажилдаа мэргэшсэн байдал иргэдэд хэр их эерэг сэтгэгдэл үлдээсэн бэ гэдэг харагдаж байна. Үүнээс үзэхэд энтертаймент төрлийн нэвтрүүлгүүд иргэд, олон нийтэд хэр их сэтгэгдэл үлдээдэг тухай тодорхой харагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас маш их хэмжээний хөрөнгө төсөв гаргаж алба хаагчдыг энгэрийн камераар хангасан билээ. Тэгвэл алба хаагчдыг тухайн энгэрийн камерыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэн хэвшүүлэх, ач холбогдлыг нь ойлгуулах, цаашлаад албаны эзэмшлийн автомашинуудыг бүрэн хар хайрцагжуулах шаардлагатай байна.

Албаны эзэмшлийн автомашинуудыг бүрэн хар хайрцагжуулж, алба хаагчдыг энгэрийн камерыг өдөр тутамд ашиглаж хэвшүүлэх шаардлага нь гэвэл алба хаагчийн гэм буруугүй талаар нотолж албан үүргээ гүйцэтгэх хугацаанд болсон үйл явдлын процессыг бүрэн бичиж аван нотлох баримтаар ашиглах боломжтой болно. Хамгийн гол нь ямар нэгэн хүний амь нас аварсан, гэмт этгээдтэй тэмцэж буй байдал зэрэг ямар нэгэн гавьяат үйлдлүүдийг баримтжуулан авч дараад нь хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр тарааж Цагдаагийн алба хаагчийн эерэг имиджийг бүрдүүлэх боломжтой болох юм.

**Дүгнэлт.** Цагдаагийн алба хаагчидтай холбоотойгоор өнөөдрийн нийгэмд цахим орчинд иргэд уур бухимдлаа илэрхийлэх нь ихэсчээ. Дуртай иргэн нь цагдаагийн алба хаагчтай маргах юм уу өөрт шударга бус санагдсан тохиолдолд утсаа гаргаж ирэн бичлэг хийн Фейсбүүкт байрлуулна хэмээн сүрдүүлэх хандлага нэгэнт тогтож бий болсон байна. Өөрөөр хэлбэр иргэд цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдлыг хариуцсан газарт нь өргөдөл гаргахаас илүүтэй Фейсбүүкт байрлуулж алба хаагчдын нэр хүндэд халдах зорилгоор олон нийтэд мэдээллэж

байна гэсэн үг юм. Үүний улмаас бидний имидж, дүр, төрх нийгэмд сөрөг талаасаа давамгайлах илүү их магадлал өндөртэй байна гэсэн үг юм.

Цахим орчинд Цагдаагийн байгууллага болон Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээллүүд болон Цагдаагийн алба хаагчийг доромжилж буй, биед нь халдаж буй дүрс бичлэг, агуулга бүхий мэдээ мэдээлэл тасралтгүй тавигдаж байгаа нь Цагдаагийн алба хаагчийн соёлгүй болон мэдлэг чадвар дутмагаас үүдэн хүнтэй зөв харилцаж чадахгүй байгаа байдал, өөрийнхөө биеийг хамгаалж чадахгүй байгаа дүр төрх нийгэмд бүрэлдэн тогтох өндөр эрсдэлтэй байна. Уг хүчин зүйлсээс хамаарч Цагдаагийн байгууллагатай огт харилцаж үзээгүй “Z” үеийнхэн дунд Цагдаагийн байгууллагыг үзэн ядах, би хүний эрх эдэлж байгаа тул Цагдаагийн алба хаагч намайг яаж ч чадахгүй гэх үзлээс үүдсэн алба хаагчийн эрх, эрх чөлөөнд халдах том эрсдэл үүсэж байна. Иймээс Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг эсэргүүцсэн үед холбогдох хууль, журмын дагуу өөрийгөө болон бусдын эрх, чөлөөг хамгаалах зорилгоор шаардлагатай тохиолдолд эргэлзэлгүйгээр биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэдэг, хэрэглэхдээ холбогдох журам ЦБҮАЖ-д заагдсан арга техникээр хэтрүүлэн хэрэглэхгүй байх мэдлэг, чадварыг алба хаагч бүрт дадал зуршил болгох шаардлагатай байна.

**Санал.** Цахим орчин, хүн бүрийн хэрэглээ болсон мэдээллийн эрэн зуунд байгаа бидний хувьд цагдаагийн алба хаагчийн болоод байгууллагын имиджийг хэрхэн эерэг талаас бий болгож албаны нэр хүндийг өргөх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээнүүдийг цаашид зохион байгуулах шаардлагатай байна. Үүний тулд бид хамгийн эхэнд бүх шатандаа зөв боловсон харьцаатай, ажилсаг, хүнд сурталгүй, иргэдэд чирэгдэл учруулдаггүй алба хаагчдыг бий болгох шаардлагатай юм. Мөн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг иргэд олон нийтэд эерэг талаас нь сурталчилж, ажиллах шаардлагатай байна. Тиймээс дараах саналуудыг гаргаж байна. Үүнд

1. Алба хаагчийн хувь хүний хөгжил, төлөвлшилрүү хандсан тодорхой төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах. Нөлөөллийн урт болон богино хугацааны сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.
2. Боловсон хүчний зөв бодлогыг явуулах. Сонгон шалгаруулалтыг чангатгах
3. Орчин цагтайгаа хөл нийлүүлсэн техник технологи, цахим гэмт хэрэгтэй тэмцэх, цахим мөнгөний талаар тодорхой сургалтыг орох. Мөн энэ чиглэлээр гадаад болон дотоодод суралцах хүсэлтэй алба хаагчдыг тодорхой хэмжээнд дэмжиж холыг харсан боловсон хүчний бодлого явуулах
4. Цагдаагийн алба хаагчийн болоод байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр тодорхой ажил арга хэмжээг зохион байгуулах. Тухайлбал цуврал реалити шоуг бэлтгэж хүргэх.
5. Албаны эзэмшлийн автомашинуудыг хар хайрцагжуулж, энгэрийн камерыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэж хэвшүүлэх, ач холбогдлыг нь ойлгуулах.

6. Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг эсэргүүцсэн үед холбогдох хууль, журмын дагуу өөрийгөө болон бусдын эрх, чөлөөг хамгаалах зорилгоор шаардлагатай тохиолдолд эргэлзэлгүйгээр биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэдэг, хэрэглэхдээ холбогдох журам ЦБҮАЖ-д заагдсан арга техникээр хэтрүүлэн хэрэглэхгүй байх мэдлэг, чадварыг алба хаагч бүрт дадал зуршил болгох шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж:
Веб хуудас:
- www.Naver.com
- www.wikipedia.com
- www.google.mn

**ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

# “ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ АРГА ЗАМ”

ДХИС-ийн магистрант,
ахмад П.Оюунболд

***Товч агуулга:*** Энэхүү өгүүлэлд Дотоодын цэрэгт хуулиар хүлээлгэсэн үндсэн чиг үүрэг болох зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх ажиллагаа, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй байдал”-ын тухай ойлголт, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар товч авч үзсэн.

***Түлхүүр үг:*** Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тээвэрлэлтийн хамгаалалт, эрх зүйн зохицуулалт.

## Үндсэн хэсэг

Монгол улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж байгаатай холбоотой тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хэрэгцээ, импорт ихээхэн нэмэгдэж байгаа өнөө үед улс орны үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болсон дотоод аюулгүй байдлыг хангах томоохон цогцолбор ажиллагааны нэг хэсэг нь Тэсэрч, дэлбэрэх бодисыг тээврийн замд харгалзан хүргэх харуул хамгаалалт юм.

Олон зуун жилийн өмнөөс хүн төрөлхтөн дарийг мэддэг, ашигладаг байжээ. Гэхдээ эмийн журмаар хэрэглэдэг байсан. Орчин үеийн тэсрэх бодисын анхдагч нь “Грекийн гал” нэртэй ёслолын буудлагын зориулалтаар хэрэглэж эхэлсэн гэж үздэг. Эх сурвалжуудад дурдсанаар манай эриний 667 онд Коллинокос гэгч хүн “Грекийн гал”-ыг бүтээсэн гэж үздэг.[124]

Манай эриний 682 онд хятадад шүү, хүхэр, модны нунтаг гэсэн бүтэцтэй болж анх удаа дарины зориулалтаар ашиглаж эхэлсэн байна.[125]

Тухайлбал Венгрт XVII-р зууны үед уул, уурхайд тэсрэх бодис ашигласан тухай мэдээ байдаг.

Тэсрэх бодисын дараагийн хөгжлийн үе шат нь XVIII-р зууны төгсгөлтэй холбоотой. Энэ үед маш хүчтэй тэсэрдэг тэсрэмтгий мөнгө /гремучее сребро/ нээгдсэн.

350 жилийн өмнөөс эхлэн тэсрэх бодисыг эрдсийн болон уул уурхайн салбарт ашигласан байдаг.

Баруун Европын томоохон хэрэглэгч орнуудын жилийн дундаж хэрэглээ нь 40000-аас 50000 тонн хүрдэг.

АНУ дэлхийн тэргүүлэгч спонсор орон бөгөөд жилд 2.7×109 kg тонн нь ANFO (ammonium nitrate-fuel oil). ANFO нь хямд үнэтэй, арга техник нь аюул багатай сонгомол бүтээгдэхүүн. Манай оронд уул уурхайн компаниуд ANFO ба түүний холимгуудыг ашигласаар байна.

[124] “Дарины үйлдвэрлэл” Б.Чадраабал УБ 2013 он
[125] “Дарь, тэсрэх бодисын шинж чанар, үйлдвэрлэл, хэрэглээ” А.Хүү-Ухнаа, Б.Чадраабал УБ 2011 он

Тэсрэх бодис /хольц/ гэж орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг, химийн урвалд өөрөө орох чадвар бүхий бодисыг (хольц) хэлнэ. Пиротехникийн бодис нь хий ялгаруулахгүй байсан ч энэхүү ангилалд хамаарна

Пиротехникийн бодис /хольц/ гэж аяндаа экзотермийн урвалд орон, тэсрэлтгүйгээр дулаан, гал, дуу чимээ, утаа эсвэл эдгээрийн цогцыг үзүүлбэр маягаар гаргах зориулалттай бодисыг хэлнэ.

Тэсрэх бодис нь тодорхой нөхцөлд гадны нөлөөнд автсан химийн хувиргалт (дэлбэрэлт)-ийг хурдасгах чадвартай, өтгөрүүлсэн химийн бодис буюу эдгээр бодисын холимог юм.

Тэсрэх бодис, тэсрэх хэрэгсэлийг ашиглахад түүний бүтэц, зохион байгуулалт, физик химийн чанар, харьцах, ашиглах дүрэм заавар, тэдгээрийг зохицуулах хуулийн заалт, тавигдах шаардлагыг сайтар судалсан байх шаардлагатай.

**“Тэсэрч дэлбэрэх бодис”** гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг[126] хэлнэ гэж заасан байна.

Тэсрэх бодисын судалгааны нэг чиглэл бол түүнийг үйлдвэрлэх болон хадгалах үеийн аюулгүй ажиллагаа юм. Тэсрэх бодис нь урт хугацаанд найдвартай хадгалагдах шинж чанарыг агуулсан байх бөгөөд тэр нь түүний түүхий эдийн чанараас хамаарна.

Тээвэрлэлтийн явцад хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай. Иймучраас Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн физик, хими шинж чанарыг товч авч үзье.

Тэсрэх бодисуудын шинж чанар эь дараах байдлаар тодорхойлогддог. Үүнд:

- Тэсрэх өөрчлөлтийн хурд
- Шаталтын даралт
- Тэсрэлтийн дулаан
- Тэсрэх бодисын хийн бүтээгдэхүүний эзлэхүүн, найрлага
- Тэсрэх бүтээгдэхүүний хамгийн өндөр хэм
- Гадны нөлөөлөлд мэдрэмтгий чадвар
- Тэсрэлтийн тойргийн хэмжээ
- Тэсрэлтийн нягтрал

Тэсрэх бодисын үйлчлэлээр дараах байдлаар ангилна.

- Байрлалын үйлчилгээтэй буюу бутлах /бризант/
- Ерөнхий үйлчилгээтэй буюу шидэх /фугас/

Тэсрэх бодисыг физик чанар, төлөвөөр нь байдлаар ангилна.:

- Хийн
- Шингэн
- Гель хэлбэрийн
- Суспенз хэлбэрийн
- Эмульсийн
- Хатуу
- Пластик
- Уян хатан

[126] “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль” төрийн мэдээлэл эмхэтгэл 2013 он, №8

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэгээний хэрэгслийн тээвэрлэлтийн явцад бусдын санаатай болон болгоомжгүй үйлдийн улмаас дэлбэрэлт үүсэж ноцтой хор уршиг учирч болзошгүй учраас дэлбэрэлт үүсэх шалтгааныг хувьд авч үзье. Судлаачдын тодорхойлсоноор:

**Дэлбэрэлт гэдэг нь:** Физикийн болон химийн өөрчлөлтөөр маш богино хугацаанд их хэмжээний энерги ялгарах үзэгдэл юм.

**Механик дэлбэрэлт гэдэг нь**: Хий агуулсан сав даралтын нөлөөгөөр гэнэт дэлбэрэх үзэгдэл юм.

**Химийн дэлбэрэлт гэдэг нь**: Бүтээгдэхүүн, хольц нь задрах эсвэл маш хурдан хариу урвалд орсноор үүсдэг байна.

**Цөмийн дэлбэрэлт гэдэг нь**: Атомын задрал болон атом бөөмсийн задралын улмаас үүснэ.

**Цахилгаан дэлбэрэлт гэдэг нь**: Металл утсаар дамжин хүчтэй цахилгаан гүйдэл үүссэнээр бий болно.

Дэлбэрэлт нь их хэмжээний дулаан ялгаруулсан урвал байх бөгөөд урвал маш хурдан явагдаж урвалын бүтээгдэхүүнээр их хэмжээний хий үүсдэг бөгөөд маш богино хугацаанд ихээхэн хор уршиг учрах эрсдэлтэй.

Манай оронд байлдааны зориулалттай тэсрэх бодис, бүтээгдэхүүний илэрцийн тоо хэмжээ буурахгүй байгаа нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй юм.

Ийм учраас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд, нэн ялангуяа хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад тэсэрч дэлбэрэх бодис, бүтээгдэхүүний талаар зохих мэдлэг олгохыг зүй ёсоор шаардаж байна.

Нөгөө талаас Монгол улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд гарч байгаа бодит өөрчлөлт, шинэчлэлтүүдийг дагаж эерэг, сөрөг олон нөлөөлөл нийгэмд мэдрэгдэж байгаа өнөө үед тэсэрч дэлбэрэх бодис буюу аюултай ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх үйл ажиллагаа түүний хамгаалалтын асуудлын судлах хэрэгцээ шаардлага гарч байна.

Дотоодын цэргийн байгууллагын Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмээр[127] “Улсын онц чухал обьектыг хамгаалах, бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх”-тэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заасан билээ.

Тиймээс тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийн тээвэрлэлтийн хамгаалалтын тухай, аюулгүй байдлыг хангах ажиллагааны талаар товч авч үзье.

Тээвэр нь улс орны дотоодын болон олон улсын харилцааны ачаа, зорчигчдыг нэг газраас нөгөөд цаг хугацаанд нь хүргэж үйлчлэхэд чиглэдэг үйлдвэрлэлийн тасралтгүй үйл явц юм.

Тээврийн салбарын хөгжил нь техникийн түвшин, үйл ажиллагааны чиглэл нь тухайн улс орны байгаль цаг уурын нөхцөл, үйлдвэрлэх хүчний байршил, зам харилцааны байдлаас шууд шалтгаална.

Одоогоор Монгол улсад төрийн болон хувийн хэвшлийн ачаа тээврийн үйлчилгээний дараах төрлүүд байна. Тухайлбал:

- Улс хоорондын тээвэр
- Орон нутгийн тээвэр
- Аюултай, хортой ачааны тээвэр

[127] Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоол

- Овортой, хүнд ачааны тээвэр
- Гэрээт түгээлтийн үйлчилгээ
- Хамгаалалттай тээвэр
- Үнэт ачааны тээвэр

Тээврийн аль нэр төрлөөр тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон нислэгийн аюулгүй ажиллагаанд хохирол, аюул учруулж болох эд зүйлс болон бодисыг **аюултай ачаа** гэнэ.

Аюултай ачааг дараах 9 ангилалд хуваагддаг. Үүнд:

1. Тэсрэмтгий бодис.
2. Хийнүүд
3. Шатамхай шингэн
4. Шатамхай хатуу бодис
5. Исэлдэгч ба  Органик бодис.
6. Хортой ба Халдвартай бодисууд
7. Цацраг идэвхит бодис
8. Идэмхий бодис
9. Бусад төрөл бүрийн аюултай бараа

Иймээс бидний сонгон судлаж байгаа **“**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл” нь өөрөө аюултай ачааны зэрэглэлд хамаардаг байна.

**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

Монгол Улсын эдийн засаг зах зээлийн харилцаанд шилжин төрийн өмчийн үйлдвэрүүдийн бүтэц задарч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд буй болж тэсрэх материалын эргэлтэнд хяналт тавих эрх зүйн орчин хангалтгүй, уул уурхайн тэсэлгээний бодисын хэрэглээ тухайн үед ямар ч зохицуулалтгүй замбараагүй байсан учраас хууль санаачлах хэрэгцээ шаардлага бий болж, Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Багабанди “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг анх санаачилж УИХ-д өргөн барьсан түүхтэй.

Монгол Улсын Их Хурлаас Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай бие даасан хуулийг 2004 онд батлан мөрдүүлж, улмаар 2013, 2015, 2017, 2020 онд шинэчлэн найруулсан байна.

Өнөөдөр Монгол улсын хэмжээнд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн сан бүрдүүлэх “APPS” программд  2020 оны байдлаар улсын хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдаалах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй 78 аж ахуйн нэгж, байгууллага цахим санд бүртгэгдсэн байна.[128]

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр [129] тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих хуулийн шаардлага тодорхой бус, Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрт нөлөө бүхий дүгнэлт гаргах эрхтэй “Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага”-ын болон шинжээчийн эрхийг хэн, хэрхэн олгох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг тодорхой заагаагүй зэрэг нь эрх зүйн

[128] УУХҮЯ-ны статистик мэдээллээс.

[129] Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. 2017 он. ХЗДХЯ

хийдэл үүсгэж хуулийн хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлж байна хэмээн дүгнэсэн байна.

Мөн хүн амын дунд өргөн хэрэглээ болсон пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах зохицуулалтыг тодорхойлох, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулах дүрэм, журмыг батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага үүсээд байна[130] гэжээ.

Дээр дурьдсан дүгнэлтийг үндэслэн Хууль сахиулах байгууллагаас тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд тавих хяналтыг сайжруулах зорилтоор тулгуурлан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулсан.

Тус хууль нь батлагдан хэрэгжиж эхэлснээр тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих төрийн нэгдсэн бодлого, хөтөлбөр хэрэгжих нөхцөл бололцоо бүрдсэний зэрэгцээ холбогдох чиг үүрэг бүхий байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй Зохицуулах зөвлөл, Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагыг байгуулж өгснөөр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалт, импорт, хадгалалт, үйлдвэрлэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын болон үйл ажиллагааны үндэс суурь бий болсон байна.

***Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагаанд дор дурьдсан хууль, эрх зүйн актаар зохицуулагддаг байна. Үүнд:***

- Монгол Улсын Үндсэн хууль
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Терроризмоос сэргийлэх тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх хууль
- Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
- Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрэм”, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хяналт, туршилтын ажил хийх журам” /Засгийн газрын 2006 оны 149 дугаар тогтоолоор батлагдсан /
- Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам
- Стандарчлал, хэмжилт зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Аюултай ачааны стандарт
- Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам
- Улсын хилээр лизенцтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт /Засгийн газрын 2006 оны 149 дугаар тогтоолоор батлагдсан/
- Тэсэрч дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажлын заавар
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд Зэвсэгт хүчнээс

[130] Мөн дээрх үнэлгээний дүгнэлт.

тодорхойлолт олгох тухай журам
- Мэргэжлийн зөвлөлийн дүрэм
- “Техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах заавар”-/2013 онд Уул уурхайн сайдын тушаалаар батлагдсан/
- ЦЕГ, МХЕГ-ын дарга нарын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн а/32/231 дугаар хамтарсан тушаалаар “тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрэлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь дээр дурьдсан хууль тогтоомжоос гадна Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хуулийн хүрээнд үйл ажилагаагаа явуулж байгаа бөгөөд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний ажил явуулдаг хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хуулинд заасан чиг үүргийнхээ хэмжээнд хяналт тавьж ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-ийг батлаж, Улсын онц чухал обьектыг хамгаалах, бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заасан байна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн стандартыг баримтлан тусгай тоноглосон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрутыг Цагдаагийн байгууллага олгож, харуул хамгаалалтыг Дотоодын цэрэг гүйцэтгэж, аюулгүй байдалд хяналт тавина.[131] гэж тус хуулинд тусгайлан заажээ.

Өөрөөр хэлбэл Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл /автомашин/-ийн аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, зөвшөөрөл олгох, хот суурин газарт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх чиглэл, хугацааг ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төв /орон нутагт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага/ батладаг байна.[132]

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь онц аюултай ачаанд хамаарах тул тээвэрлэх үед гарч болох аливаа аюул эрсдлээс урьдчилан сэргийлж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд нь Дотоодын цэргийн штабтай хамгаалалтын гэрээ байгуулж хамтран ажиллаж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Дотоодын цэргийн анги байгууллагын даргын тушаалаар томилогдсон харгалзан хүргэх харуул заагдсан нутаг дэвсгэрт харгалзан хүргэх хамгаалалтын ажлыг зохион байгуулдаг ингэхдээ хууль тогтоомж, ЦЕГ, МХЕГ-ын дарга нарын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн а/32/231 дугаар тушаалаар батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Энэхүү журамд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, хуяглан хүргэх харуулын төрөл, онцлог, алба хаагчдыг томилж үүрэгжүүлэх, удирдлагаас тавих хяналт, харуулуудын харилцан ажиллагаа, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл, харуулын хориглох зүйл, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар тус тус нарийвчлан тусгасан байдаг.

---

[131] Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хуулийн 14-р зүйлийн 14.1 дэх хэсэг

[132] Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх зөвшөөрөл олгох журам код-607

Дотоодын цэргийн хамгаалалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хот суурингийн төвөөр тээвэрлэн явж байгаа автомашины цуваag дамжин өнгөрөхөд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь “Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хууль”-ийн 14.1 дэх хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд аюулгүй байдлыг хангаn, мэдээ мэдээллийг тухай бүр цаг алдалгүй солилцон хамтран ажиллаж байна.

**Аюултай ачаа тээвэрлэлт**

Аюултай ачаанд хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй болон тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой зэрэг бусад шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдэл болон ийм шинж чанарыг агуулсан эд зүйлс бүхий ачаа багтана.

Аюултай ачааг олон улсын хэмжээнд хэрэглэгддэг аюултай ачааны таних тэмдэг болон аюулын шинж чанарын тухай санамж байрлуулсан, техник ашиглалт, аюулгүйн байдлыг хангасан, зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэж мэргэжлийн хяналтын холбогдох байцаагчаар шалгуулж ашиглахыг зөвшөөрсөн тухай дүгнэлт гаргуулсан автотээврийн хэрэгслээр холбогдох хууль тогтоомж, энэхүү журам, аюултай ачааны стандарт, аюулгүй ажиллагааны зааврын дагуу тээвэрлэнэ.

Аюултай ачааг хүн, мал, амьтан болон өөр бараа бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэх, шуудан тээвэр, нийтийн тээврийн хэрэгсэл, суудлын автомашин, ердийн хөсгөөр тээвэрлэхийг хориглоно.

Аюултай ачааны хайрцаг, сав нь гэмтэлтэй, автотээврийн хэрэгсэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй байвал тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж, тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлсэн байна. Аюултай ачаа тээвэрлэх автомашиныг унтраасны дараа ачааг ачиж, буулгахыг зөвшөөрнө.

Тээвэрлэх үед бодисын сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдах, ачаа нурах зэрэг зогсох шаардлага гарсан тохиолдолд уг аюултай ачааг тээвэрлэж яваа автотээврийн хэрэгслээс хоёр тийш 100м зайд “Орохыг хориглоно” тэмдгийг байрлуулна. Ийм ачаатай автотээврийн хэрэгслийг хот, суурин газрын ойролцоо удаан хугацаагаар зогсоохыг хориглоно.

Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэнийг үйлдвэрлэгчээс савласан зориулалтын тусгай шилэн саванд тээвэрлэнэ. Шилэн сав нь гадуураа модон хайрцаг, гөрмөл шээжгий, давхар савтай байна. Автотээврийн хэрэгслийн тэвшинд шилэн савны хоолой /таг/-г дээш харуулж босоогоор хөдөлгөөнгүй байхаар бэхэлж ачина.

Аюулын зэрэг өндөр химийн хорт болон аюултай бодис бүхий ачааг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба түүний ачааны тэмдгэнд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хатуу сахина.

Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь /цуваагаар тээвэрлэх үед цуваны ахлагч нь/ замын хөдөлгөөний эрчим, автотээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан автомашины хурд болон хоорондын зайг замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны стандартаар тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгон өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна.

Аюултай ачааг нэгэн зэрэг 3 буюу түүнээс дээш автомашинаар цуваагаар тээвэрлэх үед дараах шаардлагыг биелүүлнэ:

- **тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан**
- /цувааны ахлагч/ цуваag зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны стандарт, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан аюултай ачааг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана;
- цувааны ахлагч цувааны эхний автомашинд явах бөгөөд цувааны эхэнд хамгаалалтын автомашин, төгсгөлд нөөц автомашин явна;
- цувааны эхний болон сүүлчийн автомашин “цуваа” гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг автомашин бүрийн урд болон ард талд харагдахуйцаар жигд байрлуулна.

Аюултай ачаа тээвэрлэсэн автотээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.

Дотоодын цэргийн хамгаалалттай хуулийн этгээдийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээврийн замд харгалзан хүргэх үүргийг сүүлийн 8 жилийн байдлаар нэгтгэн авч үзвэл:

| № | Жил | Тээвэрлэсэн тоо | Хүн | Хоног | Цаг | Явсан км | Харгалзан хүргэсэн ачаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тонн/ кг | Метр | Ширхэ |
| 1 | 2012 | 638 удаа | 656 | 1450 | 34800 | 620,486 | 17,774,764 кг | 2,939,589 метр | 3,395,5 ширхэ |
| 2 | 2013 | 559 удаа | 598 | 1520 | 36480 | 560,048 | 10,158,566 кг | 3,535,023 ширхэг | 4,367,6 ширхэ |
| 3 | 2014 | 626 удаа | 679 | 1880 | 45120 | 656,039 | 129,735,435 кг | 3,977,062 метр | 3,567,1 ширхэ |
| 4 | 2015 | 580 удаа | 1346 | 1697 | 40728 | 590,355 | 8,561,141 кг | 3,865,409 метр | 3,062,8 ширхэ |
| 5 | 2016 | 598 удаа | 974 | 2028 | 48672 | 574,770 | 29,795,236 кг | 3,330,172 метр | 2,500,0 ширхэ |
| 6 | 2017 | 1251 удаа | 1346 | 4321 | 103704 | 1,367,676 | Цианит натри 502,000 кг Тэсрэх бодис 6,707,394 кг | 5,297,994 метр | 4,991,5 ширхэ |
| 7 | 2018 | 937 удаа | 974 | 3037 | 72888 | 614,581 | Цианит натри 1,010,000 кг Тэсрэх бодис 11,992,732 кг | 11,452,697 метр | 7,575,3 ширхэ |
| 8 | 2019 | 1039 удаа | 1076 | 3827 | 91848 | 657,816 | Цианит натри 1,057,600 кг Тэсрэх бодис | 6,694,269 метр | 9,936,1 ширхэ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 17,224,698 кг | | |
| 9 | 2020 | 954 удаа | 985 | 3563 | 85512 | 576719 | Цианит натри 5,720,000 кг Тэсрэх бодис 18601178 кг | 10046950 метр | 991552 ширхэ |

Давхардсан тоогоор 18 аймгийн 37 сумын нутаг дэвсгэрт байрладаг уул уурхайн компаниудын агуулахад тээвэрлэн хүргэх ажиллагааг тус тус төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран гүйцэтгэсэн байна.[133]

8 жилийн интервалаар авч үзэхэд тээвэрлэлтийн хамгаалалт цаашид улам өсөх хандлагтай, ачаалал их байгаа тул өнөөгийн зохицуулж байгаа эрх зүйн акт учир дутагдалтай байгаа юм.

## Дүгнэлт

Манай оронд байлдааны зориулалттай тэсрэх бодис, бүтээгдэхүүний илэрцийн тоо хэмжээ буурахгүй байгаа нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд аюул занал учруулж байгаагаас гадна, хууль бус эргэлтээр олж авсан тэсрэх бодис, тэсрэх хэрэгслийг “Террорист ажиллагаа”-нд ашиглахгүй гэсэн баталгаа байхгүй байна.

Иймээс Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагаа нь Цэргийн хамгаалалтад явагдах нарийн төвөгтэй, асуудал тул олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн хөгжүүлэн бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, тодорхой төсөв хөрөнгийг улсын төсөвт жил бүр тусгайлан суулгаж өгдөг байх, бүтэц, зохион байгуулалт, техник хэрэгслийн хувьд боловсронгуй болгох, хүний нөөцөө сургаж бэлтгэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн, зохицуулах, сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1. Хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодис, инженерийн мэргэжлийн чиглэлээр ажиллах мэргэжилтэнг гадаадын их, дээд сургуулиар бэлтгэх эсвэл энэ чиглэлийн дээд боловсрол эзэмшсэн инженерүүдийг сонгон авч, цагдаагийн мэргэжлийн богино хугацааны сургалтад хамруулж, хосолсон мэргэжилтэн бэлтгэх.
2. Одоо ажиллаж байгаа офицер, ахлагч нарт уул уурхайн маркшэйдэр, инженер, галын байцаагч зэрэг мэргэшсэн хүмүүсээр хамтарсан ажлын байран дахь сургалтыг явуулах.
3. Дотоодын цэрэг нь хуулийн хүрээнд өөр бусад үйл ажиллагааг явуулж ажлын ачаалал өндөр байгаа тул алба хаагчаас үүсэх эрсдэлийг бууруулах

[133] Дотоодын цэргийн 805 дугаар ангийн 2012-2020 оны үйл ажиллагааны тайлан

зорилгоор хосолсон хэлбэрээр үүрэг гүйцэтгүүлэх.

4. Байгууллага, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах. Жишээ нь: тээвэрлэлтийн хамгаалалтын үед зогсох, амрах эрхгүй явж байгаа жолоочийг амраах, Онцгой байдлын байгууллага нь өөр өөрийн хариуцсан хэсэгт хяналт тавьж, хамтран ажиллах шаардлагатай байна.
5. Бичил уурхайд гар аргаар тэсрэх бодис үйлдвэрлэхийг эрс хориглох. Ингэснээр тэсрэх бодисын хууль бус эргэлтийг буурна.
6. Эх орныхоо байгалийн баялаг, эрдэс бодис, давс, хужир, шүү одоо ажиллаж байгаа үйлдвэрүүдийн илүүдэл, хаягдал бүтээгдэхүүн болох хүхрийн хүчил, биодизель түлшний үйлдвэрийн хаягдал- глицерин, хавар намрын цагт их хэмжээгээр ялгаран зам, талбай гудамжийг бохирдуулан хаягддаг модны хөвөн, энд тэндгүй хаягддаг хуванцар сав, ундааны лааз, удахгүй манайд ашиглалтад орох нефть нэрэх, нүүрс коксжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ашиглан, Монгол оронд дарь, тэсрэх бодисын үйлдвэр байгуулах боломж байна.
7. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлж, стратегийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр нэг орноос хараат бус байх зорилтыг биелүүлэхэд зэвсэг галт хэрэглэлийн үндэсний үйлдвэрлэл чухал байгаа зэрэг нийгэм эдийн засгийн хувьд ашигтай арга хэмжээг зохион байгуулж болохыг дурьдая.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**НЭГ. Монгол Улсын хууль, тогтоомж:**

- Монгол улсын үндсэн хууль. УБ.,1992.
- Монгол улсын засгийн газрын тухай хууль. УБ.,1993.
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.,1994.
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ.,2001
- Цагдаагийн албаны тухай хууль. УБ.2017.
- Дотоодын цэргийн тухай хууль. УБ.,2017.
- “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хууль, /2013/
- Онц байдлын тухай хууль. УБ.,1995.

**ХОЁР. Ном, сурах бичиг, сэтгүүл**

- Д.Булган. Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. УБ.,2019.
- Н.Баярмагнай. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны онол, арга зүйн зарим асуудал. УБ.,2013.
- Т.Хүрэлбаатар. Дотоодын цэргийн түүхэнд холбогдох зарим баримт бичгүүд. УБ.,2012.
- Терроризмын эсрэг монголын холбоо, аюулгүй байдал, хамгаалалтын академи. Терроризм, аюулгүй байдал. УБ.,2012.

- Дарины үйлдвэрлэл” Б.Чадраабал УБ 2013 он
- “Дарь, тэсрэх бодисын шинж чанар, үйлдвэрлэл, хэрэглээ” А.Хүү-Ухнаа, Б.Чадраабал УБ 2011 он
- “Монголын зэвсгийн товч түүх” А.Дамдинсүрэн УБ 1997 он
- “Чингис хааны цэргийн зэр зэвсэг”. Ж.Базарсүрэн УБ 2000 он